



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ

2022-2023 оны хичээлийн жилийн тайлан

УЛААНБААТАР ХОТ

2023 он



Хянасан:

Захирлын ажлын албаны дарга

Н.Ганзориг

Эмхэтгэсэн:

ЗАА-ын мэргэжилтэн

Ш.Доржсүрэн

Хянан тохиолдуулсан



ӨМНӨХ ҮГ

Их сургуулийн олон талт үйл ажиллагааг сайжруулах, бүтцийн нэгжийн чиг үүргийн давхардлыг арилгах, бүтээмжийг дээшлүүлэх, нөөц бололцоог зөв хуваарилах зорилгоор бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтийг тухайн онд хийж хэрэгжүүлээ.

Манай их сургуулийн эрдмийн хамт олон дэвшүүлсэн зорилго, зорилтын хүрээнд ололт амжилт дүүрэн байсан билээ. Дэвшилтэт шинэ техник, технологийн хөгжилтэй зэрэгцэн инженерийн боловсрол хурдтайгаар хувьсан өөрчлөгдөж байгаа үед тавигдах шаардлага, мэдлэг, ур чадварыг эзэмшсэн мэргэжилтнийг бэлтгэхэд чиглэсэн Сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийг хийж эхлүүлэв. Их сургуулийн санхүүгийн үйл ажиллагааг зохицуулах шинэчилсэн эрх зүйн орчныг бий болгож ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудад санхүүгийн захиран зарцуулах эрхийг, мөн тодорхой хүний нөөцийн асуудлаа бие даан шийдвэрлэх эрхийг шилжүүллээ. Их сургуулийн үйл ажиллагаанд Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлж, бүтцийн өөрчлөлтийг хийж, их сургуулийн үйл ажиллагааг илүү үр ашигтай зохион байгуулах, байгууллагын үйл ажиллагааны чанарыг дээшлүүлэх зорилтын хүрээнд их сургуулийн бүхий л үйл ажиллагаанд чанарын менежментийн тогтолцоог бүрдүүлж, олон улсын шалгуураар үнэлж дүгнэдэг боллоо.

ШУТИС-ийг хөгжүүлэх хөгжлийн хөтөлбөрийг шинэчлэн, Нийгмийн үйлчилгээ, хамтын ажиллагаа, Боловсролын инноваци, Судалгаа, инновацийн шинэчлэл, Санхүү, дэд бүтэц, Засаглал, манлайллын гэсэн 5 чиглэлээр богино, дунд хугацаанд хэрэгжүүлэх өөрчлөлт, шинэчлэлтийг мөн эхлүүлээд байна.

ЮНЕСКО-ИСНЕI, Европын холбооны Ерасмус, "Инженер, технологийн дээд боловсрол" төслийн хүрээнд МJEED, ЖАЙКА зэрэг гадаад дотоодын байгууллагуудтай хамтарсан олон төслийг амжилттай хэрэгжүүлж байна. Дээрх төслүүдийн хүрээнд тус их сургуульд дэлхийн хамгийн сүүлийн үеийн лабораторийн тоног төхөөрөмж нийлүүлэгдэж оюутан, судлаачид судалгаа шинжилгээний ажил хийх боломж улам нэмэгдэж байна. Мөн орчин үеийн судалгааны тэргүүлэх лабораториуд, гарааны компаниуд шинээр байгуулах, олон улсын эрдэм шинжилгээний хурал, олон улстай хамтарсан судалгааны ажлыг амжилттай зохион байгуулах зэргээр эрдэм судлалын хөгжилд ахиц дэвшил гарсан хичээлийн жил боллоо.

Оюутан суралцагсдын суралцах, судалгаа хийх шаардлагыг хангасан орчин нөхцөлийг бүрдүүлэх, хүний хөгжлийг дэмжих талаар их сургуулийн зүгээс үе шаттай арга хэмжээ, олон улсын төсөл хөтөлбөр хэрэгжүүлэв.

Ирэх хичээлийн жилд Монгол улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал Алсын хараа 2050, Шинэ сэргэлтийн бодлого, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Боловсролын багц хууль, ШУТИС-ийн стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх чиглэлд олон ажлуудыг бид төлөвлөн хийж гүйцэтгэнэ.



Шинэ хичээлийн жилд бид өмнөх ололт, амжилтаа улам бататгаж судалгаанд суурилсан их сургууль болон хөгжих эрхэм зорилтуудаа улам илүү үр дүнтэйгээр хэрэгжүүлэн ажиллах болно.

ШУТИС-ийн стратеги төлөвлөгөөний хүрээнд 2030 онд дэлхийн шилдэг 1000 сургуулийн эгнээнд багтаж, дэлхийн жишигт нийцсэн их сургууль болон хөгжих, нийт профессор багш, ажилтан, оюутан суралцагсдын оролцоонд тулгуурлан боловсролын шинэчлэлийг хэрэгжүүлэх, улс орны өмнө тулгамдаж байгаа асуудлууд, эдийн засаг, аж үйлдвэрлэлийн сэргэлтийг дэмжих технологи, инновацийн үйл ажиллагааны манлайлагч нь байх зорилго, зорилтуудаа мөн хэрэгжүүлнэ.

Шинэ хичээлийн жилд бид өмнөх ололт, амжилтаа улам бататгаж судалгаанд суурилсан их сургууль болон хөгжих эрхэм зорилтуудаа улам илүү үр дүнтэйгээр хэрэгжүүлэн ажиллах болно.

Эрдэм номын эрхэм буян эгнэгт дэлгэрэх болтугай!

ШУТИС-ийн ЗАХИРАЛ Т.НАМНАН



НЭГДҮГЭЭР БҮЛЭГ


УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

ШУТИС 2020-2021 оны хичээлийн жилд Улаанбаатар хотод 10, орон нутагт 1, нийт 11 бүрэлдэхүүн сургууль, Орхон аймаг дахь харьяа “Эрдэнэт цогцолбор” дээд сургууль, Өмнөговь аймаг дахь технологийн дээд сургууль, “ШУТИС-Коосэн” технологийн коллеж, ШУТИС-ийн харьяа ЕБС-ийн ахлах сургууль, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн 2 төв, 4 хүрээлэнтэй үйл ажиллагаа явууллаа.

ШУТИС-ийн захиргаа, удирдлагын түвшинд 3 газар, 10 алба, 4 төвтэй ажиллав. ШУТИС-ийн Захирал, Эрдэм шинжилгээ, технологийн газар, Сургалт, цахим шилжилтийн газар, Санхүү, төлөвлөлтийн газар, Захирлын ажлын алба, Хяналт шинжилгээ, дотоод аудитын алба, Хүний нөөцийн алба, Гадаад харилцаа, нийгмийн түншлэлийн алба, Судалгаа, хөгжүүлэлтийн алба, Ахисан түвшний хөтөлбөрийн алба, Сургалтын бодлого, хөтөлбөрийн алба, Оюутны хөгжил, соёл үйлчилгээний алба, Санхүү, хөрөнгө оруулалтын алба, Хангамж, үйлчилгээний алба, Инновац, технологи дамжуулалтын төв, Нээлтэй боловсролын төв, Эрүүл мэндийн төв, мэдээллийн технологийн төв, Шинжлэх ухаан технологийн төв номын сан, ШУТИС-Хэвлэлийн газартай тухайн хичээлийн жилд ажиллалаа.





1.1. УДИРДАХ ЗӨВЛӨЛ:

Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалангийн 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/119 дугаар тушаалаар ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний төрийн төлөөллийг баталсан.

Удирдах зөвлөлийн даргаар Боловсрол, шинжлэх ухааны яамны шинжлэх ухаан технологийн бодлого, инновацын хөгжүүлэлт, хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Баттогтох ажиллав.

ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн

Хүснэгт 1.1

Д/д	Нэрс	Эрхэлж буй албан тушаал
I.Төрийн төлөөлөл		
1	Дарга	Д.Баттогтох
2	Гишүүн	М.Батгэрэл
3		А.Мөнх-Оргил
4		Д.Эрдэнэбаяр
5		Д.Одгэрэл
6		Н.Цэрэнбат
7		Т.Батмөнх
8		Т.Дүүрэн
9		Л.Энхбат
II.Хамт олны төлөөлөл		
10	Гишүүн	Б.Бат-Эрдэнэ
11		Ц.Энхбаатар
12		Ц.Тэнгис
13		Ч.Золбаяр



14		С.Дэлгэрмаа	ШУТИС-ийн Үйлдвэрчний эвлэлийн нэгдсэн хорооны дарга
15		Г.Ганчимэг	ШУТИС-ийн Оюутны холбооны тэргүүн

ШУТИС-ийн Удирдах зөвлөл 2022-2023 оны хичээлийн жилд 5 удаа хуралдаж

1. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны “Их дээд сургуулийг “Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор” болгон орон нутагт хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 321 тоот тогтоол, “Төрийн өмчийн боловсролын сургалтын байгууллагын талаар авах арга хэмжээний тухай” 293 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх, БШУЯ-ны сайдын 2022 оны 09 сарын 09-ний өгсөн чиглэлийн дагуу Өмнөговь аймагт Технологийн дээд сургууль, Орхон аймагт “Эрдэнэт цогцолбор” дээд сургуулийн харьяа Эрдэнэт политехник коллежийг ШУТИС-ийн бүтцэд оруулан батлах тухай

2. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн захиргааны бүтцийг шинэчлэн батлах тухай

3. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн захирлыг сонгон шалгаруулах ажлын хэсэг байгуулах тухай.

4. ШУТИС-ийн 2022 оны төсвийн тодотгол

5. ШУТИС-ийн 2023 оны төсвийн төсөл

6. Сургалтын төлбөрийн нэг кредитийн үнэлгээ тогтоох тухай

7. Оюутны байрны төлбөр шинэчлэн батлах тухай

8. Удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргыг томилох тухай

9. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн захирлын сонгон шалгаруулалттай холбоотой мэдээлэл

10. Элсэлтийн хяналтын тоо батлах тухай

11. Сургалтын төлбөрийн нэг кредитийн үнэлгээ тогтоох тухай зэрэг асуудлыг хэлэлцэж 12 тогтоол гаргаж, хурлын шийдвэрийг тухай бүрт нь их сургуулийн веб сайтаар дамжуулан мэдээлэл хүргэсэн байна.

Удирдах зөвлөлийн багшийн төлөөлөл сонгогдов.

ШУТИС-ийн захирлын 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдөр баталсан Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд ажиллах багшийн төлөөллийг сонгох үйл ажиллагааны удирдамж баталж, ШУТИС-ийн Захирлын 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн А/132 тоот тушаалаар ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд хамт олныг төлөөлөн гишүүнээр ажиллах багшийн төлөөллийг сонгох үйл ажиллагааг зохион байгуулах бүрэлдэхүүн сургууль болон захиргааны сонгох хорооны гишүүдийг батлав. Сонгох хороог БАС 10, БуХС 10, БАТС 10, ГУУС 10, ГХС 10, ДаТС10, МехТС 10, УТС 10, ХШУС 10, ЭХС 10, ЗАА 10 гэсэн нийт 120 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан.



ШУТИС-ийн Удирдах зөвлөлд ажиллах хамт олны төлөөлөлд бүрэлдэхүүн сургуулиас дараах нэр дэвшигчдээс:

1. Барилга, архитектурын сургуулийн Барилгын инженерийн салбарын Ахлах багш Т.Мөнх-Өнөр
2. Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль, Технологийн менежментийн салбарын эрхлэгч Л.Амартүвшин
3. Бизнесийн ахисан түвшний сургуулийн Бизнесийн удирдлага, менежментийн салбарын дэд профессор Ж.Ганчимэг
4. Геологи уул уурхайн сургуулийн Эрдэс боловсруулалт, инженерчлэлийн салбарын эрхлэгч Г.Ганбилэг
5. Гадаад хэлний сургуулийн захирал Ц.Энхбаатар
6. Механик, тээврийн сургуулийн Машин үйлдвэрлэлийн салбарын Профессор М.Дэлгэрмаа
7. Мэдээлэл, холбооны технологийн сургуулийн Электроникийн салбарын Дэд профессор Ц.Тэнгис
8. Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн Хүнсний инженерчлэлийн салбарын эрхлэгч Э.Энхцэцэг
9. Хэрэглээний шинжлэх ухааны сургуулийн Математикийн тэнхимийн Дэд профессор Б.Сэр-Од
10. Эрчим хүчний сургуулийн Цахилгаан техникийн салбарын эрхлэгч Б.Бат-Эрдэнэ

2023 оны 05 дугаар сарын 1-ний өдрийн ШУТИС-ийн сонгох хорооны гишүүдийн олонхын санал авсан Эрчим хүчний сургуулийн Цахилгаан техникийн салбарын эрхлэгч Б.Бат-Эрдэнэ, Гадаад хэлний сургуулийн Захирал Ц.Энхбаатар, Мэдээлэл, холбооны технологийн сургуулийн Электроникийн салбарын Дэд профессор Ц.Тэнгис, ШУТИС-ийн Үйлдвэрчний эвлэлийн нэгдсэн хорооны дарга С.Дэлгэрмаа нар Удирдах зөвлөлийн багшийн төлөөллөөр, Оюутны холбооноос ирүүлсэн саналыг үндэслэн ШУТИС-ийн Оюутны холбооны тэргүүн Ш.Өнөболдыг оюутны төлөөллөөр, ШУТИС-ийн төгсөгч дэмжигчдийн холбооноос ирүүлсэн саналыг үндэслэн Мэдээлэл, харилцаа, холбооны үндэсний ассоциаци тэргүүн Ч.Золбаярыг төгсөгчийн төлөөллөөр ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн гишүүнээр баталсан 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А/175 тоот тушаал гарлаа.

Удирдах зөвлөлийн гишүүд 2021-2022 оны хичээлийн жилийн хугацаанд ШУТИС-д зохион байгуулагдсан эрдэм шинжилгээний хурал, үзэсгэлэн, уулзалт семинар бусад арга хэмжээнд оролцож, их сургуулийг хөгжүүлэх, материаллаг баазыг нэмэгдүүлэх, бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох, сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын чанарыг сайжруулахад анхаарч, дэмжлэг үзүүлж ажиллав.



1.2. ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2022-2023 оны хичээлийн жилд ШУТИС-ийн Эрдмийн зөвлөл 2 удаа хуралдаж, бодлогын баримт бичиг хэлэлцэх, эрдмийн ба хүндэт цол олгох, шинэ салбар байгуулах зэрэг асуудлуудыг хэлэлцүүлж шийдвэрлэлээ.

ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн асуудал

/2022-2023 оны хичээлийн жил/

Хүснэгт 1.2

№	Хэлэлцсэн асуудал	Тогтоол
2023 оны 05 дугаар сарын 22-ны өдөр		
1	ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай	№01
2	Хамтын ажиллагаа, нийгмийн түншлэлийн талаар баримтлах бодлогын баримт бичиг хэлэлцэж, батлах тухай	№02
3	ШУТИС-ийн хүний нөөцийн бодлогын баримт бичиг хэлэлцэж, батлах тухай	Дахин хэлэлцүүлэх
4	Шинэ, сэргээгдэх эрчим хүчний салбар байгуулах тухай	№03
2023 оны 06 дугаар сарын 13-ны өдөр		
	ШУТИС-ийн Эрдмийн ба хүндэт цол олгох тухай	№04, 05, 06, 07, 08, 09
	“ШУТИС-ийн хүний нөөцийн бодлого”-ыг батлах тухай	№10
	ШУТИС-ийн бакалавр, магистр, докторын сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн тухай	Дахин хэлэлцүүлэх

1.2.1. Эрдмийн дэд зөвлөлийн хурал

ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн дэргэдэх байнгын ажиллагаатай дэд зөвлөлүүд болох Эрдэм шинжилгээ, технологийн дэд зөвлөл 3 удаа, Эрдмийн ба хүндэт цолны дэд зөвлөл 1 удаа хуралдав. /Хүснэгт 1.3./

Дэд зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн асуудал

/2022-2023 оны хичээлийн жил/

Хүснэгт 1.3

№	Хэлэлцсэн асуудал	Огноо	Үр дүн
Эрдэм шинжилгээ, технологийн дэд зөвлөл			
1	Барилгын судалгаа, хөгжлийн хүрээлэн байгуулах тухай	2022.12.08	Дэмжив. ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх.
2	Хот байгуулалтын салбар байгуулах тухай	2022.12.08	Хот ба бүс нутгийн хөтөлбөрөө боловсруулаад батлуулсны дараа салбар байгуулахыг дэмжив.
3	Дизайн урлаг судлалын докторын зэрэг хамгаалуулах зөвлөл байгуулах тухай	2022.12.08	Дэмжив. БШУЯ-д холбогдох дүрмийн дагуу материалыг бүрдүүлж хүргүүлэх.
4	Шинэ ба сэргээгдэх эрчим хүчний салбар байгуулах тухай	2022.12.08	Дэмжив. Дараагийн шатны хурлаар хэлэлцүүлэх.
5	ШУТИС-ийн харьяа хүрээлэнгийн 2022 оны үйл ажиллагааны тайлан хэлэлцэж үнэлэх тухай	2023.02.13	4 хүрээлэнгийн захирлуудын ажлыг хэлэлцүүлж, тодорхой үр дүнд хүрсэн гэж дүгнэв.



6	Гадаад, дотоодын санхүүжилттэй төслийн явц, эцсийн тайлан хэлэлцэх тухай	2023.02.13	ШУТСангийн 6, ШУТИС-ийн Технологийн сангийн 2, MJeed төслийн 10, гадаадын санхүүжилттэй бусад төсөл 3, нийт 21 төслийн явц болон, эцсийн тайланг хэлэлцэж үнэлэв.
7	Төвүүдийн тайлан хэлэлцэх тухай	2023.04.25-26	42 төвийн 2 жилийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэж дүгнэв.
8	ШУТИС-ийн захиалгат, зорилгот төслийн сонгон шалгаруулалт	2023.04.25-26	“ШУТИС-д академик тогтолцоог нэвтрүүлэх нь” төслийн саналыг дэмжив.
Эрдмийн ба хүндэт цолны зөвлөл			
1	Эрдмийн ба хүндэт цол олгох асуудал	2023.06.07	Хүндэт цолд 2, профессорт 3, дэд профессорт 18 нэр дэвшигчдийг дэмжив.

ШУТИС-ийн Хүндэт ба Эрдмийн цол хүртэгчсэд

/2022-2023 оны хичээлийн жил/

Хүснэгт 1.4

№	Овог нэр	Байгууллага, албан тушаал	ЭЗ-ийн тогтоолын тогтоол
Хүндэт профессор -2			
1	Рэнцэн БАТМЭНД	МУ-ын инженерүүдийн үндэсний академийн дэд ерөнхийлөгч	2023.06.13, №08
2	Сандаг БОЛДБААТАР	ҮТС, Ахмад багш	2023.06.13, №09
Профессор - 3			
1	Сэтэв НЯМДОРЖ	БАС, Барилгын инженерийн салбарын ахлах багш	2023.06.13, №06
2	Банзар НАМЖИЛДОРЖ	ХШУС, Физикийн тэнхимийн ахмад багш	2023.06.13, №06
3	Гончигсүрэн МӨНХСАЙХАН	ХШУС, Физикийн тэнхимийн дэд профессор	2023.06.13, №06
Дэд профессор - 18			
1	Бямбажав ЛХАГВАДУЛАМ	БАС, Хүрээлэн буй орчны инженерийн салбарын дэд профессор	2023.06.13, №07
2	Чойжамц ОЮУНЖАРГАЛ	БАС, Инженерийн зурагзүйн тэнхимийн дэд профессор	2023.06.13, №07
3	Төмөр-Очир ЭРДЭНЭ-БАТ	МехТС, Тээврийн салбарын дэд профессор	2023.06.13, №07
4	Лхагваа ТЭЛМЭНБАЯР	МехТС, Машин үйлдвэрлэлийн салбарын ахлах багш	2023.06.13, №07
5	Мишиг ДЭЛГЭРНАСАН	МехТС, Сургалт, чанарын албаны дарга	2023.06.13, №07
6	Пүрэвсүрэн ӨЛЗИЙСАЙХАН	МехТС, Механик инженерийн ахисан түвшний салбарын эрхлэгч	2023.06.13, №07
7	Шамбалжамц ЦООЖ	МехТС, Техникийн механикийн тэнхимийн эрхлэгч	2023.06.13, №07
8	Аюурзана ОДГЭРЭЛ	МХТС, Электроникийн салбарын эрхлэгч	2023.06.13, №07
9	Гомбосүрэн ЗОРИГТ	ХШУС, Физикийн тэнхимийн дэд профессор	2023.06.13, №07
10	Мөнхбаатар БАТТУЛГА	ЭХС, Цахилгаан техникийн салбарын дэд профессор	2023.06.13, №07
11	Андрей АЮУШ	БуХС, Бизнесийн удирдлагын салбарын ахлах багш	2023.06.13, №07



12	Баатар БОЛОРМАА	БуХС, НУС-ын нийгмийн ажлын хөтөлбөр хариуцсан дэд профессор	2023.06.13, №07
13	Чулуунбат ДОЛЖИНСҮРЭН	БуХС, Нийгмийн ухааны салбарын ахлах багш	2023.06.13, №07
14	Оюунбилэг ТАМИР	БАТС, Эрдэмтэн нарийн бичгийн дарга	2023.06.13, №07
15	Аюурзана БОЛОРМАА	ГХС, Сургалт, чанарын албаны дарга	2023.06.13, №07
16	Рагчаа БИГЭРМАА	ГХС, Ази судлалын салбарын ахлах багш	2023.06.13, №07
17	Пүрэвсүрэн НЯМСҮРЭН	МХТС, Холбооны салбарын ахлах багш	2023.06.13, №07
18	Ранжил БАДМААНЯМБУУ	УТС, Хөнгөн үйлдвэрлэлийн технологи, инженерчлэлийн салбарын ахлах багш	2023.06.13, №07

1.3. ЗАХИРЛЫН ЗӨВЛӨЛ

2022-2023 оны хичээлийн жилд ШУТИС-ийн захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд оруулах санал бүрэлдэхүүн сургууль, нэгж, захиргааны газар, албадаас авч, нэгтгэн батлуулав. https://www.must.edu.mn/media/uploads/2022/09/20/xerox-scan_20092022093502.PDF

Тайлант хугацаанд ШУТИС-ийн Захирлын зөвлөлийн хурал батлагдсан төлөвлөгөөний дагуу 2022 оны 8 дугаар сарын 15-наас 2023 оны 6 дугаар сарын 27-ны өдрийг дуустал 28 удаа хуралдаж, шинээр багш авах, элсэлтийн хяналтын тоо, төсөв, төсвийн тодотгол, төлөвлөгөө, тайлан баланс, цалин, элсэлт, төгсөлт, сургалтын үйл ажиллагааны тухай, мэргэжил, сургалтын төлбөр, судалгааны төв, эрдэм шинжилгээний хурал, үзэсгэлэн зохион байгуулах, дүрэм журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, бодлогын баримт бичиг, багш, ажилчдын нийгмийн асуудал, гадаад харилцаа, олон улсын тэмцээнд оролцох тухай, аудит болон дотоод хяналт шалгалтын дүгнэлт, олон улсын болон дотоодын магадлан итгэмжлэл (хөтөлбөрүүд)-ийн явц, үр дүн, засвар тохижилтын ажил, эрдэм шинжилгээний болон сургалтын нэгдсэн хуанли, цаг үеийн асуудлыг хэлэлцсэн.

Захирлын зөвлөлийн хурлын тэмдэглэл хөтөлж, хурлын тэмдэглэлийн хэсгээс их сургуулийн <https://www.must.edu.mn/mn/content/t/5> вэб хуудаст байршуулан ажиллаж байна.

Захирлын зөвлөлийн бүрэлдэхүүн

Хүснэгт 1.5

Д/д	Овог нэр	Албан тушаал
1	2	3
1	Т.Намнан	ШУТИС-ийн захирлын үүрэг гүйцэтгэгч
2	Ж.Арслан	Захиргаа, хүний нөөцийн газрын дарга
3	Д.Гэрэлт-Од	Сургалтын бодлого, зохицуулалтын газрын дарга
4	Т.Энхцацрал	Эрдэм шинжилгээ, инновацийн газрын дарга
5	Г.Жавхлан	Хөрөнгө оруулалт, хангамжийн газрын дарга
6	Д.Бямбасүрэн	Хөгжлийн хөтөлбөр төлөвлөлтийн газрын дарга
7	Б.Нарантуяа	БАС-ийн захирал
8	А.Энхбат	БуХС-ийн захирал



9	Г.Баттүвшин	БАТС-ийн захирал
10	К.Хавалболот	ГУУС-ийн захирал
11	Ц.Энхбаатар	ГХС-ийн захирал
12	Ц.Батбаатар	ДаТС-ийн захирал
13	Ж.Хашбат	МехТС-ийн захирлын үүрэг гүйцэтгэгч
14	Н.Чулуунбанди	МХТС-ийн захирал
15	Ж.Туяацэцэг	ҮТС-ийн захирал
16	В.Өлзийбаяр	ХШУС-ийн захирал
17	Б.Бат-Эрдэнэ	ЭХС-ийн захирал
18	Д.Зоригтхүү	ЭЦДС-ийн захирал
19	Д.Ганбат	НБТ-ийн захирал
20	Б.Баяржавхлан	ШУТИС-ийн харьяа ӨмТДС-ийн захирлын үүрэг гүйцэтгэгч
21	С.Дэлгэрмаа	ШУТИС-ийн дэргэдэх Үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга
22	Б.Эрдэнэбүрэн	ШУТИС-ийн Оюутны холбооны тэргүүн

Бүтэц зохион байгуулалтын өөрчлөлттэй холбогдуулан ШУТИС-ийн Захирлын 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/355 тушаалаар Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Захирлын зөвлөлийн бүрэлдэхүүн шинэчлэн батлагдсан.

Захирлын зөвлөлийн бүрэлдэхүүн

Хүснэгт 1.6

Д/д	Овог нэр	Албан тушаал
1	2	3
1	Т.Намнан	ШУТИС-ийн захирал
2	Н.Эрдэнэхүү	Сургалт, цахим шилжилтийн газрын захирал
3	Д.Цолмонбаатар	Эрдэм шинжилгээ технологийн газрын захирал
4	Л.Баяр-Эрдэнэ	Санхүү, төлөвлөлтийн газрын захирал
5	Н.Ганзориг	Захирлын ажлын албаны дарга
6	Д.Мягмарсүрэн	Хүний нөөцийн албаны дарга
7	Т.Ууганбаяр	Гадаад харилцаа, нийгмийн түншлэлийн албаны дарга
8	Б.Түмэндэлгэр	Хяналт шинжилгээ дотоод аудитын албаны дарга
9	Б.Нарантуяа	Барилга, архитектурын сургуулийн захирал
10	А.Энхбат	Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургуулийн захирал
11	Г.Баттүвшин	Бизнесийн ахисан түвшний сургуулийн захирал
12	Ц.Энхбаатар	Гадаад хэлний сургуулийн захирал
13	К.Хавалболот	Геологи, уул уурхайн сургуулийн захирал
14	Ц.Батбаатар	Дархан-Уул аймаг дахь технологийн сургуулийн захирал
15	Н.Пүрэвдорж	Механик, тээврийн сургуулийн захирал
16	Н.Чулуунбанди	Мэдээлэл, холбооны технологийн сургуулийн захирал
17	Ж.Туяацэцэг	Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн захирал
18	В.Өлзийбаяр	Хэрэглээний шинжлэх ухааны сургуулийн захирал
19	Б.Бат-Эрдэнэ	Эрчим хүчний сургуулийн захирал
20	н .Зоригтбаатар	ШУТИС-ийн харьяа Эрдэнэт цогцолбор дээд сургуулийн захирал
21	Б.Баяржавхлан	ШУТИС-ийн харьяа Өмнөговь аймаг дахь технологийн дээд сургуулийн захирал
22	С.Дэлгэрмаа	ШУТИС-ийн дэргэдэх Үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга
23	Г.Ганчимэг	ШУТИС-ийн Оюутны холбооны тэргүүн



1.4. ЗАХИРГААНЫ ЗӨВЛӨЛ

Тайлангийн хугацаанд Захиргааны зөвлөл 5 удаа (2022 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл) хуралдаж, багш ажилтнуудыг шагналд нэр дэвшүүлэх, захиргааны зарим бүтэц зохион байгуулалт, цаг үеийн асуудлыг хэлэлцэж цаг тухайд нь холбогдох тушаал, шийдвэр гарган хэрэгжүүлж ажилласан.

Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэж гарсан шийдвэрийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллаж ирсэн. Тухайлбал, багш нарын баярыг тохиолдуулан шагнуулахаар нэр дэвшүүлсэн багш, ажилтнуудын бүрдүүлэх баримт бичгийг Яамны шагналын шинэчилсэн журмын дагуу бүрдүүлж, цахим системд бүртгүүлэн БШУЯ-нд хүргүүлж шийдвэрлүүлсэн. Мөн төрийн цол, одон медалиар шагнуулах багш ажилтнуудын саналыг нэгтгэн хурлаар хэлэлцүүлж, дэмжигдсэн багш ажилтнуудын материалыг бүрдүүлж, СБД-ийн ЗДТГ-т хүргүүлсэн.

1.5. БОДЛОГО ХӨТӨЛБӨР ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ, ТУШААЛ ШИЙДВЭРИЙН БОЛОВСРУУЛАЛТ

ШУТИС-ийн хэмжээнд тодорхой асуудлаар бодлого боловсруулах, дүрэм журам, албан тушаалын тодорхойлолтууд шинэчлэх, шинээр боловсруулж батлуулах ажлууд хийгдсэн.

ШУТИС-ийн захирлын тушаалын төсөл боловсруулж, танилцуулан, батлуулах ажлыг хийж гүйцэтгэсэн.

/Хүснэгт 4/

№	Ажлын хэсгийн нэр	Хүрэн үр дүн
1	ШУТИС-ийн Хүний нөөцийн бодлого (2023-2030) (ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн 2023.06.13-ны 10 дугаар тогтоолоор баталсан)	2023.07.01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
2	ШУТИС-ийн Цаг бүртгэлийн түр журам (2023.02.07-ны А/38 дугаар тушаалын 1-р хавсралтаар баталсан)	2023.02.01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
3	ШУТИС-ийн Хөдөлмөрийн дотоод журамд оруулсан нэмэлт өөрчлөлт (2023.02.07-ны А/38 дугаар тушаалын 2-р хавсралтаар баталсан)	2023.02.01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
4	Цагийн ажлын төрөл, жишиг хөлсний хэмжээг батлах тухай /ОСҮА-тай хамтран/ (2023.09.20-ны А/275 дугаар тушаалаар баталсан)	2023.10.02-ны өдрөөс мөрдөж эхэлсэн.
5	Цалин нэмэгдүүлэх, цалингийн сүлжээг шинэчлэн батлах тушаал боловсруулж батлуулсан. 3 удаа /СХОА-тай хамтран/ (1. ШУТИС-ийн захирлын 2022.02.14-ний А/31 дугаар тушаалаар	1. 2022.01.01 – 2022.09.01 хүртэл мөрдсөн. 2. 2022.09.01-нээс мөрдөж эхэлсэн.



	(2. ШУТИС-ийн захирлын 2022.09.14-ний А/242 дугаар тушаалаар (3. ШУТИС-ийн захирлын 2023.02.16-ны А/40 дүгээр тушаалаар	3. 2023.01.01 – 2023.09.16-ны өдрийг хүртэл мөрдөх
6	ШУТИС-ийн захиргааны бүтэц шинэчлэн батлагдсантай холбогдуулан захиргааны газар, алба нэгжийн үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг, албан тушаал, орон тоог шинэчлэн боловсруулж батлуулсан. (ШУТИС-ийн захирлын 2022.11.04-ний А/307 дугаар тушаалаар)	2022.12.15-ны өдрөөс мөрдсөн.
7	ШУТИС-ийн захиргааны бүтэц шинэчлэн батлагдсантай холбогдуулан захиргааны газар, алба нэгжүүдийн дарга нарын болон бусад албан тушаалтнуудын албан тушаалын тодорхойлолтуудыг шинээр болон шинэчлэн боловсруулж, батлуулсан. (1.ШУТИС-ийн захирлын 2022.12.01-ний А/327 дугаар тушаалаар, 2.ШУТИС-ийн захирлын 2022.12.15-ны А/344 дугаар тушаалаар, 3.ШУТИС-ийн захирлын 2023.02.07-ны А/39 дүгээр тушаалаар)	1. 2022.12.01-ний өдрөөс мөрдсөн. 2. 2022.12.15-ны өдрөөс мөрдсөн. 3. 2023.02.01-ний өдрөөс мөрдсөн.
8	ШУТИС-ийн захирлын тушаал Үндсэн үйл ажиллагаатай холбоотой А тушаал	362 тушаалын төсөл боловсруулж, танилцуулан батлуулсан.
9	ШУТИС-ийн захирлын тушаал Хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой Б тушаал	662 тушаалын төсөл боловсруулж, танилцуулан батлуулсан.

1.6. ШУТИС-ИЙН ХҮНИЙ НӨӨЦ, АЖЛЫН БАЙРНЫ ШИЛЖИЛТ, ХӨДӨЛГӨӨН

ШУТИС нь 2022-2023 оны хичээлийн жилд 775 үндсэн багш, 113 гэрээт багш, 642 ажилтан ажиллагчидтай үйл ажиллагаа явууллаа. Нийт багш, ажиллагчдын эрдмийн зэрэг, цолтой багш 49,1 хувийг эзэлж байна.

Эрдмийн зэрэг, цолтой багшийн тоог 50 хувьд хүргэх зорилтын хүрээнд хүний нөөцийн тогтвортой хөгжих нөхцөл боломжийг бүрдүүлэх, гадаадын их, дээд сургуульд эрдмийн зэрэг, цол хамгаалсан багш нарыг ажиллуулах боломжийг судлах, хүний нөөцийн бодлого, хөтөлбөрт тусган ажиллаж байна.

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль, сургуулийн “Хөдөлмөрийн дотоод журам”, холбогдох бусад дүрэм журмын хүрээнд Ректорын тушаалаар 2022-2023 оны хичээлийн жилд гадаад суралцах, бүтээлийн, хүүхэд асрах, хувийн хүсэлтээр чөлөө авсан нийт 154 багш, ажиллагчид, мөн тэтгэвэр тогтоолгохоор 43, өөрийн хүсэлтээр 94, сахилгын шийтгэлээр 6, нийт 143 багш, ажилтан ажлаас чөлөөлөгдөж, туршилтаар 40 багш ажилтан ажилд авсан байна.

Шинээр ажилд орсон багш, ажилтнуудын хувийн хэргийг хүн тус бүрээр бүрдүүлж, төрийн албан хаагчийн программд мэдээллийг нэмж оруулав.

Хүний нөөцийн алба нь хүүхэд асрах чөлөө, ажлаас чөлөөлөгдсөн, шинээр ажилд орсон гэх мэт хүний нөөцийн холбогдолтой өөрчлөлт хөдөлгөөн, шагналын мэдээллийг



бүртгэл хөтлөн, хяналт тавьж ажиллаж байгаа нь тушаалын биелэлтэд хяналт тавих, тодорхой мэдээлэл, судалгааг богино хугацаанд шуурхай гаргахад үр дүнтэй байдаг.

2022-2023 оны хичээлийн жилд ажлаас чөлөөлөгдсөн байдлыг хүснэгтээр харуулбал:
/Хүснэгт .../

Ажлаас чөлөөлөгдсөн байдал	Хүйс	Багш ажилчдын тоо	Нийт
Тэтгэврээ тогтоолгосон	Эр	3	43
	Эм	40	
Өөрийн хүсэлт	Эр	51	94
	Эм	43	
Сахилгын зөрчил гаргасан	Эр	3	6
	Эм	3	

1.7. ХҮНИЙ НӨӨЦИЙН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЭЛ

ШУТИС-ийн Хүний нөөцийн албанаас хүний нөөцтэй холбоотой дараах 3 төрлийн цахим мэдээллийн санг хариуцан, бүртгэл мэдээлэл, нэмэлт өөрчлөлт, шилжилт хөдөлгөөнийг тухай бүр шинэчлэн, төрийн албан хаагчдын мэдээллийн санг баяжуулж ажиллаж байна. Үүнд:

1. ШУТИС-ийн веб сайтын Хүний нөөцийн вэб <https://emp.must.edu.mn/> -д шинээр ажилд орсон, шилжсэн, ажлаас гарсан шилжилт хөдөлгөөний бүртгэлийг тухай бүр нь хийх,
2. БШУЯ-ны Дээд боловсролын удирдлага мэдээллийн систем <https://hemis.edu.mn/>-д багш, ажилтнуудын томилогдсон, албан тушаал өөрчлөгдсөн, чөлөөлөгдсөн хөдөлгөөнийг бүртгэх,
3. Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем <https://erp.e-mongolia.mn/> -д 2023 оны 02 дугаар сараас ШУТИС-ийн захиргааны алба, бүрэлдэхүүн сургууль, нэгж, албан тушаалуудыг үүсгэн, албан хэрэг хөтлөлттэй холбоотой албан тушаалтнуудыг төрийн албан хаагч цэсэд бүртгэсэн (Захирлын ажлын албаны зөвлөмжийн дагуу)

Бүрэлдэхүүн сургууль, нэгжийн захирлын туслахуудад ШУТИС-ийн хүний нөөцийн систем, БШУЯ-ны дээд боловсролын удирдлага мэдээллийн системд мэдээлэл оруулах, шилжүүлэхтэй холбоотой зөвлөгөө, мэдээллийг тогтмол өгч ажиллаж байна.

1.8. ШИНЭ БАГШИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ

“ШУТИС-ийн салбар, тэнхимийн үйл ажиллагаа зохицуулах журам”-ын дагуу 2022/2023 оны намрын улирал, 2023/2024 оны хаврын улиралд шинэ багш сонгон шалгаруулалтыг 2 удаа зохион байгуулж явууллаа.

1. 2022/2023 оны хичээлийн жилийн намрын улиралд 8 бүрэлдэхүүн сургууль нийт 18 мэргэжлээр 19 багшийн орон тоо зарлаж, 26 хүн бүртгүүлсэн. Эдгээрээс ярилцлагад орж, шалгалтад тэнцсэн 2 доктор (Ph.D), 6 магистр зэрэгтэй, нийт 8 хүнийг ШУТИС-д багшаар ажиллуулахаар шийдвэрлүүлэв.

Сургууль тус бүрээр хүснэгтлэн харуулбал:

Сургууль	Хүснэгт				
	БАС	БАТС	ДаТС	МХТС	ЭХС
Шинэ багшийн тоо	2	1	1	2	2



2. 2023/2024 оны хичээлийн жилийн хаврын улиралд 11 бүрэлдэхүүн сургууль нийт 28 мэргэжлээр 34 багшийн орон тоо зарлаж, 35 хүн бүртгүүлсэн. Эдгээрээс ярилцлагад орж тэнцсэн 3 доктор (Ph.D), 11 магистр зэрэгтэй, нийт 14 хүнийг ШУТИС-д багшаар ажиллуулахаар шийдвэрлүүлэв.

Сургууль тус бүрээр хүснэгтлэн харуулбал:

Сургууль	Хүснэгт							
	БАС	ГХС	ГУУС	ДаТС-ЕБАС	МХТС	ЭХС	ШУТИС-КТК	ШУТИС-ЕБАС
Шинэ багш тоо	2	1	2	1	2	2	2	2

Сонгон шалгаруулалтад тэнцсэн нийт 22 хүнийг ахлах багш, багш, дадлагжигч багшийн албан тушаалд ажиллуулах тухай Захирлын тушаалаар багшаар авч ажиллуулсан.

1.9. ШАГНАЛ, ТЭТГЭМЖ УРАМШУУЛАЛ

Тайлант хугацаанд ШУТИС-ийн Захирлын зөвлөлийн хурлаар эмчилгээний зардал хүссэн 3 багш, ажилтанд 8,200,000 төгрөгийн буцалтгүй тэтгэмж, Хамтын гэрээний дагуу захиргааны 12 ажилтанд нийт 5,503,200 төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тэтгэмж үзүүлсэн байна.

Тайлангийн хугацаанд тэмдэглэлт ой, түүхэн явдлыг тохиолдуулан шинжлэх ухаан, техник, технологийг хөгжүүлэх, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, сайн мэргэжилтэн бэлтгэх сургалтын ажилд хамт олноо манлайлан үр бүтээлтэй ажиллаж байгаа багш ажилчдыг Төрийн цол одон, медалиар 45, Засгийн газрын шагнал БТА, ШУТА, СТА хүндэт тэмдгээр 33, БШУЯ-ны Жуух бичгээр 30 багш ажилтныг шагнуулахаар хамт олноос ирүүлсэн нийт 106 багш ажилтны материалыг зохих журмын дагуу бүрдүүлж, саналыг СБД-ийн ЗДТГ, МИДСК, БШУЯ, Соёлын яаманд уламжлан хүргүүлсэн.

ШУТИС-ийн багш, ажилтнуудаас 2022/2023 оны хичээлийн жилд МУ-ын Ардын багш цолоор 1, Төрийн шагналаар 4, МУ-ын ШУ-ны Гавъяат зүтгэлтэн цолоор 2, ХГУТО-оор 2, Алтан гадас одонгоор 7, Хөдөлмөрийн хүндэт медалиар 3, нийт 19 багш, ажилтан шагнагдсан. Мөн Засгийн газрын шагнал БТА хүндэт тэмдгээр 26, ШУТА хүндэт тэмдгээр 4, СТА хүндэт тэмдгээр 1, БШУЯ-ны Жуух бичгээр 27, ШУТИС-ийн Хүндэт өргөмжлөлөөр 2, Эрдмийн зөвлөлийн шагналаар 6, Ректорын нэрэмжит шагналаар 17 багш ажилтан шагнагдсан байна.

1.10. ХҮНИЙ НӨӨЦИЙН ТАЛААР ХИЙГДСЭН СУДАЛГАА

Тайлангийн хугацаанд БШУЯ, агентлаг, бусад төрийн болон төрийн бус байгууллагуудаас ирүүлсэн ШУТИС-ийн хүний нөөцтэй холбогдолтой судалгааг цаг тухайд нь гаргаж, зохих газарт нь хүргүүлж ажиллалаа.

/Хүснэгт .../

Судалгаа нэгтгэсэн байдал



Хариуцсан ажил үүрэгтэй холбоотой дараахь судалгааг нэгтгэн гаргаж, холбогдох яам, газруудад хүргүүлсэн.		Цаг хугацаа
1	Шагнуулах хүмүүсийн судалгааг сургууль, шагнал тус бүрээр нэгтгэж, Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн.	2022.09
2	ДБ тайлан шинэ загвараар /захиргааны ажиллагчдын/	2022.09.26
3	4ШУТИС-ийн багш, ажилчдын боловсролын зэргийн судалгаа	2022.10.04
4	БШУЯ-нд төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөн, томилсон, чөлөөлсөн мэдээ	2022.12.22
5	ШУТИС-д ажиллаж буй 55 нас хүрсэн эмэгтэй, 60 нас хүрсэн эрэгтэй багш нарын судалгаа	2023.02
6	ШУТИС-ийн захиргаанаас тэтгэвэрт гарсан ахмад настны судалгаа шинэчилсэн /захиргааны ахмадын зөвлөлийн дарга Ж.Сэр-Одод хүлээлгэн өгсөн/	2023.02.08
7	Захиргааны ажилтнуудын ээлжийн амралтын төлөвлөлт	2023.02.16
8	Тэтгэврийн насанд хүрсэн багш, ажилчдын судалгаа	2023.03.21
9	ШУТИС-ийн багш, ажилтнуудын ЕБС-ийн судалгаа	2023.03.21
10	ШУТИС-ийн багш, ажилтнуудын хүүхдийн судалгаа /8-12 дугаар анги/	2023.03.21
11	Албан тушаалын тодорхойлолтын шаардлага хангаагүй албан тушаалтнуудын мэдээлэл /шүүр ажиллагааны хүрээнд/	2023.03.31
12	Захиргааны ажилтнуудын 16 хүртэлх насны хүүхдийн судалгаа	2023.05

Дөрөв. Байгууллагын хөгжил, хувь хүний соёл, ажлын байранд өөрийн мэдлэг чадвараа дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан ажлууд

№	Сургалтын чиглэл	Хугацаа, хаана	Хамрагдсан хүмүүс
ШУТИС-ийн багш, ажилтнуудыг чадавхижуулах, шинэ багш ажилтнуудад чиглүүлэх сургалтууд			
1	“Байгууллагын харилцаа-харилцан ойлголцол-гарц шийдэл” фокус бүлгийн ярилцлага	2023 оны 01 сарын 20-ны өдөр 11: 00 цагт, ШУТТНС-3 давхар	СБХА, СХОА, ОХСҮА, ЭМТ, Номын сан, БХБ-ийн ахлагч нар, Оюутны зөвлөл 20 хүн оролцсон
2	Хувь хүний ёс зүйд харилцаа нөлөөлөх нь	ШУТТНСан 504 тоот, 2023 оны 2-р сарын 16-нд 11:00-14:00 цагт	Сургалтын бодлого, хөтөлбөрийн албаны мэргэжилтэнгүүд,



			бүрэлдэхүүн сургуулийн СБХА-ны мэргэжилтэн нар
3	Ажилтны энгэйжмэнтэйг нэмэгдүүлэх асуудал	ШУТИС-ийн VIII-байр 12 давхрын хурлын танхим, 2023 оны 3-р сарын 17-нд 12:00-14:30	Хангамж үйлчилгээний алба, үйлчилгээний ажилтан нар
4	Шинээр ажилд орсон багш, ажилтан нарт зориулсан чиглүүлэх сургалт	Эрдмийн зөвлөлийн өрөө 203 тоот, 2023 оны 9 сарын 7	Шинээр орсон багш, ажилтан нарт
5	Шинээр ажилд орсон багш нарт зориулсан чиглүүлэх сургалт	Эрдмийн зөвлөлийн өрөө 203 тоот, 2023 оны 9-р сарын 15-нд 11:00-12:30 цагт	Шинээр орсон багш нарт
Олон нийтийн арга хэмжээ			
1	Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Мартын 8-ыг тохиолдуулан “Ээжийн бүүвэйтэй хорвоо” хүндэтгэлийн арга хэмжээ	ШУТТНСан 604 тоот, 2023 оны 3-р сарын 6-нд 14:00-17:00	ШУТИС-ийн алдарт эхийн одонтой ээжүүд
2	ШУТИС-тай танилцаж аав, ээжийн ажлын газраар аялах өртөөчилсөн өдөрлөг	ЭХС, 2023 оны 5-р сарын 5-нд 13:00-16:00 цагт	Эрчим хүчний сургуулийн багш, ажилчдын хүүхдүүд
3	ШУТИС-ийн 2023 оны багш, ажилчдын спортын тэмцээн	2023 оны 1-р сарын 10 -17 Спорт зал	ШУТИС-ийн багш, ажиллагсад
4	“Тэжээхүй ухааны цаг улирлын идээ ба явдал мөр” эрүүл мэндийн өдөрлөг	2023 оны 3 сарын 20-нд ШУТТНС	ЭМТ, бүрэлдэхүүн сургуулийн багш ажилчид
5	Хар тамхи мансууруулах бодисын хор уршиг өдөрлөг	2023 оны 4 сарын 10	ОХСҮА, Коосен ТК
Их сургуулийн бодлогод чиглэсэн ажлууд			
1	Алсын хараа-2050, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын багш нарт таниулах сургалт./ Боловсролын ерөнхий газар, Удирдлагын академи, ШУТИС хамтарсан/	2023 оны 01-р сарын 05-нд цахимаар, 01-р сарын 12, 13 нд танхимаар ШУТИС-ийн 8-р байрны хурлын танхимд	ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудаас ЭХС-11, МехТС-12, ГУУС-5, БАС-10, ҮТС-6, БАТС-1, ГХС-10, БуХС-5, ДаТС-16, ХШУС-9 нийт 85



			багш тус тус оролцов.
2	Дээд боловсролын тогтолцоонд ажлын байранд суурилсан сургалтыг нэвтрүүлэх асуудлууд сэдвийн хүрээн доор ШУТИС-аас Эерэг монгол -2023 чуулганд багш нарын төлөөлөл бүрдүүлэн оролцов.	Төрийн ордон 2023 оны 03-р сарын 21-нд 09:00 цагт	БАС-М.Цас-Оргилмаа, ГХС-С.Сэржмядаг, МХТС-Ц.Батцэцэг, МТС-С.Дэлгэрмаа, ХШУС-С.Туяа, БАТС-Б.Алтанцэцэг, СБХА-ны дарга М.Эрдэнэтуяа, ЭХС-Ч.Батгэрэл
3	ШУТИС-ийн Шинэ багш, ажилтныг чиглүүлэх, дасан зохицуулах хөтөлбөрийн төсөл боловсруулсан. 2023-05 сар		
4	ШУТИС-ийн бодлого, үйл ажиллагаа, ажлын орчин нөхцөл, удирдлага, хамт олны уур амьсгалын талаар үнэлэлт дүгнэлт хийх, цаашид багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэх, хамт олонч уур амьсгалыг бүрдүүлэх зорилгоор СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА-2023 нэгтгэн, дүгнэсэн		

Хавсралтаар зураг



Хувь хүний ёс зүйд харилцаа нөлөөлөх нь сэдэвт сургалтад Сургалтын бодлого, хөтөлбөрийн албаны мэргэжилтнүүд, бүрэлдэхүүн сургуулийн СБХА-ны мэргэжилтэн нар оролцов.



Ажилтны энгэйдэмэнтгийг нэмэгдүүлэх асуудал сургалтад хангамж үйлчилгээний алба, үйлчилгээний ажилтан нар оролцдоо.




ШУТИС-ийн 2023 оны хичээлийн жилд шинээр ажилд орсон багш нарт 2 удаа чиглүүлэх сургалт явуулсан



Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Мартын 8-ыг тохиолдуулан “Ээжийн бүүвэйтэй хорвоо” хүндэтгэлийн арга хэмжээ зохион байгуулсан



ШУТИС-тай танилцаж аав, ээжийн ажлын газраар аялах өртөөчилсөн өдөрлөг зохион байгуулсан



Эрүүл мэндийн төвтэй хамтран “Тэжээхүй ухааны цаг улирлын идээ ба явдал мөр” сэдэвт сургалт зохион байгуулсан





БАТЛАВ. ШУТИС-ийн ХҮНИЙ НӨӨЦИЙН АЛБАН ДАРГА Д.МЯГМАРСҮРЭН



**ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ХУСГУУЛИЙН
2023 ОНЫ БАГШ, АЖИЛЧДЫН СПОРТЫН ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ**

Наг. Тэмцээний зорилго

Боловсролын тухай хууль, Биеийн тамир спортын тухай хуулийн хүрээнд багш, ажилчдын дунд биеийн тамир спортыг хөгжүүлэх, спортоор хичээлэх сонирхлыг өргүүлэх, аварга баг тамирчдыг тодруулах зорилготой.

Хоёр. Тэмцээний төрөл, зохион байгуулах хугацаа

№	Төрөлүүд	Хүний тоо			Хугацаа	Хариуцах эзэн	Явагдах байр
		Эр	Эм	Дас			
1	Шатар	Баг /5 хүртэй/ Ганцарчилсан			2023 оны 1-р сарын 9-нд 9 цагт	Ч.Навчаа	Номын сан
2	Волейбол	12	12	2	2023 оны 1-р сарын 10-14	М.Баг-Очир	2-р байр спорт заал
3	Шарээний теннис	Баг /5 хүртэй/ Ганцарчилсан			2023 оны 1-р сарын 9-нд 9 цагт	М.Амаржаргал	МХТС спорт заал
4	Ажлын байрны дасгал	9		1	2023 оны 1-р сарын 9-нд 11 цагт	Г.Ерөөлбат	2-р байр спорт заал
5	Сагсан бөмбөг	12	12	2	2023 оны 1-р сарын 15-20	Б.Ганзориг	2-р байр спорт заал
6	Биллиард	Захирын зөвлөл			2023 оны 1-р сарын 14-нд 10 цагт	О.Баатарзоригт Г.Мөнх-дорж	Биллиард клуб

Гурав. Тэмцээний зохион байгуулалт

ШУТИС-ийн Хүний нөөцийн алба, Багшийн хөгжлийн багийн ахлагч нар, ХШУС-ийн Биеийн тамир, спортын тэнхим хамтран зохион байгуулав. ШУТИС-ийн бүрэлдэхүүн болон харьяа сургуулиудаас удирдагчийн дагуу төрөл тус бүр баг тамирчид оролцов. Спортын тэмцээний нэгдсэн нээлтийн ажиллагаа 1-р сарын 10-ны 17⁰⁰ цагт, хаалтын ажиллагаа сагсан бөмбөгийн тэмцээний сүүлийн өдөр болно. Нэгдсэн нээлтийн ажиллагаанд баг тамирчид сургуулийнхаа туг, хаягаа барин, жигд тоглолтын хувцастай ороцоно.

ШУТИС-ийн 2023 оны багш, ажилчдын спортын тэмцээн зохион байгуулсан





Шинэ сэргэлтийн бодлого

- ✓ Боловсрол сургалт
- ✓ Эрчим хүчний сургалт
- ✓ Ам үйлдвэрлэлийн сургалт
- ✓ Хөт хөдөлгөөний сургалт
- ✓ Нэгж хөдөлгөөний сургалт
- ✓ Төрийн бүтэц хөдөлгөөний сургалт

• Хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд ТАХ-ын оролцоо гэсэн сэдвүүдээр Удирдлагын академийн багш нар хичээл зааж, сургалт амжилттай хязгада. Шиндэг баг 1, шиндэг оролцогч 5 багийнх шалгарууллаа.



Шиндэг баг



Шиндэг оролцогч нар

Боловсролын ерөнхий газар, Удирдлагын академи, ШУТИС хамтран Алсын хараа-2050, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын багш нарт таниулах сургалтыг хамтран 2023 оны 01-р сарын 05-нд цахимаар, 01-р сарын 12, 13 нд танхимаар ШУТИС-ийн 8-р байрны 12 давхрын хурлын танхимд тус тус зохион байгуулав.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
ЛУУСАН НАМСРАЙН ОЮУН-ЭРДЭГИЙН ЧИВЭЭЛ ДОР
ЗОХИОН БАЙГУУЛАГДАЖ БҮН "ЭЭРЭГ МОНГОЛ" ЧУУЛГАН

JCI Mongolia 2023
CROWNED BY VALUE

OTGONTENGER UNIVERSITY
ӨНӨГ ӨНӨ

ЭЭРЭГ МОНГОЛ

ЧУУЛГАН - 2023

ДЭЭД БОЛОВСРОЛЫН ТОГТОЛЦООНД АЖЛЫН БАЙРАНД
СУУРИЛСАН СУРГАЛТЫГ НЭВТРҮҮЛЭХ АСУУДАЛД

2023 оны 01 сарын 21 09:00 12:00 ТӨРИЙН ОРДОН





Дээд боловсролын тогтолцоонд ажлын байранд суурилсан сургалтыг нэвтрүүлэх асуудлууд сэдвийн хүрээн доор ШУТИС-аас Эерэг монгол -2023 чуулганд багш нарын төлөөлөл бүрдүүлэн оролцов.

ШУТИС-ийн Шинэ багш, ажилтныг чиглүүлэх, дасан зохицуулах хөтөлбөр боловсруулсан

ШУТИС-ийн бодлого, үйл ажиллагаа, ажлын орчин нөхцөл, удирдлага, хамт олны уур амьсгалын талаар үнэлэлт дүгнэлт хийх, цаашид багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэх, хамт олонч уур амьсгалыг бүрдүүлэх зорилгоор [СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА-2023](#) хийж нэгтгэн дүгнэсэн.



ХОЁРДУГААР БҮЛЭГ

СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА,
ЦАХИМ ШИЛЖИЛТ



ХОЁР. СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Сургалтын хөтөлбөрийн бүртгэлийн алба нь Захирлын зөвлөлийн 2022 оны 6-р сарын 07-ны өдрийн хурлаар батлагдсан 2022-2023 оны хичээлийн жилийн Сургалтын нэгдсэн хуанлийн дагуу бакалаврын түвшний сургалтын элсэлт, төгсөлт, явцын сорил, улирлын шалгалт, диплом хамгаалалт гэсэн сургалтын үндсэн үйл ажиллагааг зохион байгуулж ажиллав. Мөн ШУТАС, Коосэн ТДС, коосен хөтөлбөрийн сургалтын үйл ажиллагааг удирдлагаар ханган, байгууллагын магадлан итгэмжлэлийн асуудлыг хариуцан ажиллав.

2.1. ЭЛСЭЛТ

ШУТИС-ийн Захирлын 2022 оны 03 дугаар сарын 16-ны “ШУТИС-ийн бакалаврын хөтөлбөрт 2022-2023 оны хичээлийн жилд суралцагч элсүүлэх журам”-ын дагуу элсэлтийн үйл ажиллагаа 05 сарын 24-аас 08 сарын 30-ны хооронд элсэлтийн комисс зохион байгуулсан.

Элсэгчдийн бүртгэл, онооны жагсаалтыг программ хангамжийн тусламжтайгаар гарган, болзол хангасан элсэгчдийн www.elselt.edu.mn веб хуудсаар дамжуулан суралцах цахим мэргэжлийн сонголтыг хийлгэв.

Удирдах зөвлөлийн 2022 оны 06 сарын 28-ны 04 тоот тогтоолоор оюутан элсүүлэх элсэлтийн хяналтын тоог баталсан.

БШУС-ын 2022 оны 12 дугаар сарын 16-ны А/540 тоот “Журам шинэчлэн батлах тухай” тушаалын дагуу БҮТ-өөс зохион байгуулагдсан ЭЕШ нь жилд 2 удаа зохион байгуулагдаж, элсэлтийн үйл ажиллагаа жилд 2 удаа зохион байгуулагдаж эхлэв.

БШУС-ын 2022 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн А/160 тоот Мэргэжлийн чиглэл /хөтөлбөрийн нэр/, индекс шинэчлэн батлах тухай тушаалаар элсэгч авсан.

Өмнөговь аймагт харьяа сургууль байгуулагдах засгийн газрын тогтоол гарч, 4 хөтөлбөрөөр сургалт явуулах зөвшөөрөл авч Уул уурхайн ашиглалтын технологи, Цахилгааны инженер, Мэдээллийн технологи хөтөлбөрөөр элсэлт авч эхлэв.

БШУ-ны сайдын 2021 оны 10 дугаар сарын 06 –ны өдрийн А/347 дугаар тушаалаар “Олон улсын шалгалтын үнэлгээг Монгол улсын ЭЕШ-ын үнэлгээтэй дүйцүүлэн тооцох тухай” журам 34 элсэгч хамрагдав.

Элсэлтийн ажлын график дараах хуваарийн дагуу явагдав. Үүнд:

Намрын элсэлт

Бүртгэл: 2022 оны 07 сарын 01-04-ний өдрүүдэд 24 цагийн турш www.elselt.edu.mn вэб хаягаар бүртгэв.

Хар зургийн шалгалт: 2022 оны 06 сарын 28-ны өдөр Улаанбаатар хот
2022 оны 06 сарын 27-29-ны өдрүүдэд Орон нутагт

Онооны жагсаалт: 2022 оны 06 сарын 30-ны өдөр

Мэргэжил сонголт: 2022 оны 07 сарын 01- 05-ны өдрүүдэд

Өвлийн элсэлт

Бүртгэл: 2022 оны 12 сарын 20-24-ны өдрүүдэд 24 цагийн турш www.elselt.edu.mn вэб хаягаар бүртгэв.

Хар зургийн шалгалт: 2022 оны 12 сарын 24-ны өдөр Улаанбаатар хот



Онооны жагсаалт: 2022 оны 12 сарын 25-ны өдөр

Мэргэжил сонголт: 2022 оны 12 сарын 25-30-ны өдрүүдэд

ШУТИС-ийн намрын элсэлтээр бүрэлдэхүүн сургуулиудад нийт 3401 оюутан, өвлийн элсэлтээр 122 оюутан тус тус шинээр элсэн суралцах болсон.

Элсэлт элсэлтийн ерөнхий шалгалтгүйгээр тухайн салбартаа 3-аас доошгүй жил ажилласан 30-аас дээш насны тэргүүлэх мэргэжлээр намрын элсэлтээр 53 оюутан, өвлийн элсэлтээр 3 оюутан тус тус суралцав.

Ажил олгогчийн саналын дагуу Геологи, уул уурхайн сургуулийн Уул уурхайн машин тоног төхөөрөмж хөтөлбөрөөр, Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн Нэхмэлийн үйлдвэрлэлийн технологи хөтөлбөрөөр 42 элсэгчид элссэн суралцав.

Шинээр элсэн орсон элсэгчид


Хүснэгт 2.1

Д/д	СУРГУУЛЬ	Хяналтын тоо	Элсэн оюутан	Хувь /%/
1	Барилга, Архитектурын сургууль	600	427	71%
2	Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль	600	268	45%
3	Геологи, уул уурхайн сургууль	665	359	54%
4	Гадаад хэлний сургууль	130	66	51%
5	Механик, тээврийн сургууль	560	252	45%
6	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	820	789	96%
7	Үйлдвэрлэлийн технологийн сургууль	500	347	69%
8	Хэрэглээний шинжлэх ухааны сургууль	310	112	36%
9	Эрчим хүчний сургууль	595	436	73%
10	Дархан-Уул аймаг дахь Технологийн сургууль	430	229	53%
11	Ш.Отгонбилэгийн нэрэмжит "Эрдэнэт цогцолбор" дээд сургууль	290	162	56%
12	Өмнөговь аймаг дахь технологийн сургууль	80	76	95%
ШУТИС		5580	3523	63%





Зураг 2.1. Сүүлийн гурван хичээлийн жилийн элсэгчдийн тооны харьцуулалт



Зураг 2.2. Элсэхээр бүртгүүлсэн ЕБС төгсөгчдийн тоо /Сүүлийн 7 жил/

ШУТИС-д элсэгчдийн 1 ба 2-р шалгалтад тооцдог хичээлүүдийн дундаж онооны эзлэх хувь (480-580) хязгаарт хамгийн их буюу 40-45% байна.

ЭЕШ оноо	Мат	Нийгэм	Англи хэл	Физик	Хими	Хар зураг
680-аас дээш	584	184	451	292	68	85
580-679	2418	1172	1771	1325	236	301
480-579	4119	2439	3434	2481	462	259
410-479	1929	1181	1740	1272	219	106
409-ээс доош	1063	518	961	623	120	86

Хүснэгт 2.2 Элсэгчдийн хичээлийн дундаж онооны эзлэх хувь

Цахим анкет бөглөж, оюутны код амжилттай авсан элсэгчид бүрэлдэхүүн сургуулиудтай суралцах **гэрээ байгуулж явууллаа.**

Цагийн сургалт

Бакалаврын түвшинд цагийн сургалтаар ажил олгогчийн хүсэлтийн дагуу 2022-2023 оны хичээлийн жилийн хаврын улиралд элсэлт хийв.

Д/д	СУРГУУЛЬ	Элссэн оюутны тоо
1	Геологи, уул уурхайн сургууль	14
2	Өмнөговь аймаг дахь технологийн сургууль	9
3	Дархан-Уул аймаг дахь Технологийн сургууль	1
ШУТИС		24

Хүснэгт 2.3 Цагийн сургалтаар элссэн элсэгчдийн тоо

“Монгол Улсын үндсэн хууль”-ийн 17 дугаар зүйлийн 17.1.4, “Цэргийн албаны тухай хууль”-ийн 4.2-ын дагуу 2022 оны хоёрдугаар ээлжийн хугацаат цэргийн албанд татагдсан 193 суралцагчдын сонгосон хичээлийн кредитийн төлбөрийг шилжүүлэх захирлын тушаал гаргав. 2023 оны нэгдүгээр ээлжийн хугацаат цэргийн татлага 2023 оны 04 дүгээр сарын 27-ноос 05 дугаар сарын 08-ны өдрүүдэд зохион байгуулагдсан тул суралцагчдын сонгон суралцаж буй хичээлийн явцыг үнэлж, мэдээлэл оруулах тухай



сургалт, цахим шилжилтийн газрын захирлын албан тоот бичиг бүрэлдэхүүн сургуульд хүргүүлэв.

2.2. ТӨГСӨЛТ

2022-2023 оны нөхөн дипломын материалыг намрын улиралд 2022 оны 10 дугаар сарын 01-30-ны хооронд, хаврын улиралд 03 дугаар сарын 01-30-ны хооронд тус тус хүлээн авсан. Нөхөн диплом авах хүсэлт гаргасан намрын улиралд 9, хаврын улиралд 10 нийт 19 төгсөгчдийн материалыг шалгаж, холбогдох бүрэлдэхүүн сургуультай хамтран дүйцүүлэлтийг хийж дүйцүүлэлтийн комиссоор батлуулсан болно. Нөхөн дипломын бичилтийн баазыг бүрдүүлэн дипломуудыг кирилл, уйгуржин болон англи хэлээр хэвлэн гаргаж баталгаажуулан хүсэлт гаргасан төгсөгчдөд хүлээлгэн өгөв.

2022-2023 оны хичээлийн жилд бакалавр, мэргэжлийн дипломтой төгсөх төгсөгчдийн төгсөлтийн ажлын сэдэв, удирдагчийн мэдээллийг дипломын нарийн бичгийн дарга нар “UNIMIS” системд оруулж, сургалтын нэгдсэн хуанлид заагдсан хугацаанд Захирлын тушаалаар батлуулав.

2022-2023 оны хичээлийн жилийн намрын төгсөгчдийн сэдэв удирдагч, зөвлөх бүрэлдэхүүнийг Захирлын 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А/311, төгсөлтийн салбар комиссын бүрэлдэхүүнийг 2022 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/332 тоот тушаалаар, хаврын төгсөгчдийн сэдэв удирдагч, зөвлөх бүрэлдэхүүнийг Захирлын 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн А/136, ИТДБТөслийн хүрээнд Бакалаврын Япон улстай хамтарсан 4 дүгээр ээлжийн хамтарсан хөтөлбөрөөр төгсөх төгсөгчдийн сэдэв удирдагч, зөвлөх бүрэлдэхүүнийг Захирлын 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн А/199, төгсөлтийн салбар комиссын бүрэлдэхүүнийг Захирлын 2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн А/143 тоот тушаалаар тус тус батлуулав.

2022-2023 оны хичээлийн жилийн намрын улиралд төгсөх оюутны тушаалын дагуу 908 бакалавр, 1 мэргэжлийн диплом захиалах тухай 2023 оны 01 дугаар сарын 04-ны өдрийн 2/03 тоот албан бичиг, хаврын улиралд төгсөх оюутны тушаалын дагуу 1247 бакалаврын диплом захиалах тухай 2023 оны 5 дугаар сарын 10, 12-ны өдрийн 1/260, 1/270 тоот албан бичгээр БШУЯ-нд тус тус хүргүүлэв.

2022-2023 оны хичээлийн жилийн намар, хаврын улирлын диплом хамгаалуулах, төгсөлтийн шалгалт өгөх батлагдсан хуваарийн дагуу 1 сарын 02-с 1 сарын 11-ний өдрүүдэд танхим хосолсон хэлбэрээр, хаврын улиралд 2023 оны 5 сарын 29-өөс 6 сарын 07-ны өдрүүдэд төгсөлтийн салбар комиссын бүрэлдэхүүнтэйгээр тухайн мэргэжлийн харьяалагдах салбар дээр тус тус явагдав. Төгсөлтийн салбар комиссоос төгсөлтийн файлууд болон холбогдох материалыг хүлээн авч дипломын бичилтийн баазыг бүрдүүлэн дипломуудыг кирилл, уйгуржин болон англи хэл дээр хэвлэн гаргаж баталгаажуулав.


Төгсөгчдөд мэргэжил, мэргэжлийн зэрэг олгох тухай Захирлын тушаалыг боловсруулан батлуулж, тушаалд нэр заагдсан төгсөгчдөд олгох бакалаврын дипломыг бичин баталгаажуулж, бүрэлдэхүүн сургуулиудад олгож, төгсөгч оюутнуудад диплом, энгэрийн тэмдэг гардуулах Төгсөлтийн ёслолын ажиллагааг намрын улиралд 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр, хаврын улиралд 6 дугаар сарын 15-ны өдөр тус тус зохион байгуулав.

Хүснэгт 2.4 Төгсөгчдийн товчоо




№	Улирал	Бакалаврын зэрэгтэй төгсөгч		Мэргэжлийн дипломтой төгсөгч
		Нийт	Үүнээс онцх дипломтой төгсөгч	
1	Намрын улиралд	678	24	1
2	Хаврын улиралд	1242	90	
2022-2023 оны хичээлийн жилд		1920	114	1


Зураг 2.3. Төгсөгчдийн үнэлгээний голч дүн




Зураг 2.4. Онцлох дипломтой төгсөгчдийн тоо /сүүлийн 3 жилээр/



Зураг 2.5. Төгсөөгүй хойшилсон оюутны судалгаа



Зураг 2.5. Төгсөгчдийн үнэлгээний голч дүн /Сүүлийн 3 жилээр/



2022-2023 оны хичээлийн жилийн ашиглагдаагүй үлдсэн дипломыг тооцоог үндэсний үнэт цаас ХХК-тай хийж дуусгав.

2.3. ШАЛГАЛТЫН ХУВААРЬ

Намрын улиралд 12 сарын 19-нөөс 30-ны өдрүүдэд ерөнхий болон мэргэжлийн 95 хичээлийн шалгалтын хуваарийг цахим, танхим хэлбэрээр зохиож

Намрын улиралд 28878 ширхэг, хаврын улиралд 10384 ширхэг шалгалтын картгыг шалгалт зохион байгуулж байгаа бүрэлдэхүүн сургуулийн багш нарт тараан өгч, давхардсан тоогоор 89 хичээлийн 39262 шалгалтын материалыг төстийн машинаар уншиж засав.

2.4. БУСАД

UNIMIS-д оюутны бүртгэлд шинэ элсэгчдийн мэдээллийг регистрээс шууд унших системийн шинэчлэл хийв.



Дархан-Уул аймаг дахь технологийн сургуулийн 337, Эрдэнэт цогцолбор дээд сургуулийн сургуулийн 17 суралцагчийн оюутны код давхардсан тул дахин код олгож, захирлын тушаал гаргав.

МУ-ын нийт их, дээд сургуулиудад суралцаж буй сонсголын бэрхшээлтэй оюутнуудыг дээд боловсролын үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хамруулах зорилгоор “Тэмдэглэл хөтлөгч”-ийн үйлчилгээг нэвтрүүлэх зорилготой оюутнуудын дунд БЕГ-ын ирсэн маягтын дагуу судалгааг явуулж 2022 оны 09 сарын 27-нд БЕГ-т хариуг хүргүүлэв. Цаашид явагдах судалгааг UNIMIS-ийн оюутны бүртгэл хэсэгт байрлуулж, байнга судалгаа авдаг болов.

Ур чадварын шалгалттай шинээр элссэн элсэгчдийн мэдээллийг ДБУМС-д бүртгэлжүүлэхэд шаардлагатай ШУТИС-ийн ур чадварын шалгалтаар элссэн 324 элсэгчдийн оноог БЕГ-т хүргүүлэв.

Эрүүл мэндийн даатгалын газрын хүсэлтийн дагуу шалгалт ХШУС, НБТ-тэй хамтран зохион байгуулав.

Нийгмийн даатгалын хүсэлтийн дагуу байцаагч нараас авах шалгалтыг НБТ-тэй хамтран зохион байгуулав.

ЭЕШ өндөр оноотой элсэгчдийн мэдээллийг ОХҮА-нд гарган өгөв.

Чанарын менежмент ба баталгаажуулалт, Харилцааны ёс зүйн сургалтад тус тус хамрагдав.

ШУТИС-ийн чанарын менежментийн тогтолцоонд дотоод аудитын хүрээнд элсэлт, төгсөлт, сургалтын үйл ажиллагааны түвшинд RACI зураглал хийж, баталгаажуулав.

2022-2023 оны хичээлийн жилийн төгсөгчдийн 1920 төгсөгчдийн дипломын хуулбар, хавсралтын архив, төгсөлтийн салбар комиссын тогтоол шийдвэр, нөхөн дипломын бичиг баримтыг архивын стандартын дагуу хавтаслан ШУТИС-ийн архивт цахим, цаас хэлбэрээр хүлээлгэн өгөв.

2.5. ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН

Бусад их, дээд сургуулиас шилжин суралцаж байгаа оюутны болон давхар мэргэжлээр элсэн суралцаж байгаа оюутнуудын материалыг хянаж, оюутнаар батлах болон шилжүүлэн суралцуулах тушаал боловсруулж батлуулав.

Шилжин суралцсан болон шууд элссэн оюутны тоог сургууль бүрээр гаргавал:

Д д	Сургууль	2022-2023 Намар							2022-2023 Хавар								
		Шилжилт		Давхар мэргэжлээр шууд элсэлт					Нийт	Шилжилт		Давхар мэргэжлээр шууд элсэлт					Нийт
		Барилгын инженерчлэл		2	
2	Бизнесийн ахисан түвшний сургууль	Бизнесийн удирдлага	1		3
		Менежмент	1	1	



3	Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль	Соёл судлал	1		1
4	Гадаад хэлний сургууль	Хэл шинжлэл	1	1	2
5	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	Компьютерын ухаан	2	2	10
		Компьютерын сүлжээ	3		
		Мэдээллийн технологи	2		
		Электроникийн инженерчлэл	1		
6	Нээлттэй боловсролын төв	Боловсрол судлал	12		12
7	Үйлдвэрлэлийн технологийн сургууль	Хувцас үйлдвэрлэлийн технологи, загвар зохион бүтээлт		1	5
		Дизайн, урлаг судлал	3	1	
Нийт			27	9	36

18 дугаар хүснэгт

Докторантурын сургалтын хөтөлбөрөөр элсэгчдийн тоо

д/д	Сургууль	Хөтөлбөрийн нэр	2022-2023 оны хичээлийн жил		Элсэгчдийн тоо
			Намар	Хавар	
1	Барилга, архитектурын сургууль	Архитектур	1	1	2
2		Барилгын инженерчлэл	3	2	5
3		Барилгын геотехник			
4		Барилгын бүтээц эдлэлийн технологи			
5		Гүүрийн инженерчлэл			
6		Усны барилга, байгууламж	4	1	5
7		Авто замын инженерчлэл	2	2	4
8		Усан хангамж, ус цэвэрлэгээ	3	2	5
9		Халаалт, агаар сэлгэлт, кондиционер			
10	Бизнесийн ахисан түвшний сургууль	Бизнесийн удирдлага	8	1	9
11		Менежмент	13	3	16
12		Төрийн удирдлага			
13	Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль	Нийгмийн ажил	2	1	3
14		Соёл судлал	2		2
15	Геологи, уул уурхайн сургууль	Өрөмдлөгийн инженерчлэл			
16		Газрын тосны инженерчлэл			
17		Хийн инженерчлэл			
18		Геодези			
19		Геологи	1		1
20		Гидрогеологи	2	1	3
21		Геозкологи			
22		Инженер геологи, геотехник	2		2
23		Уул уурхайн ашиглалтын технологи	2	1	3
24		Уул уурхайн маркшейдр			
25		Ашигт малтмалын баяжуулалтын технологи		1	1
26		Уул уурхайн машин тоног төхөөрөмж	1	1	2
27		Уул уурхайн цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт	1		1
28	Гадаад хэлний сургууль	Хэл шинжлэл	1	1	2



29	Дархан-Уул аймаг дахь Технологийн сургууль	Барилгын материалын үйлдвэрлэлийн технологи			
30	Механик, тээврийн сургууль	Металлурги, металлын технологи	2		2
31		Мехатроник			
32		Механик инженерчлэл			
33		Авто инженерчлэл	2		2
34	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	Компьютерын ухаан	5	2	7
35		Компьютерын сүлжээ	3		3
36		Мэдээллийн технологи	2		2
37		Электроникийн инженерчлэл	1	1	2
38		Мэдээлэл холбооны сүлжээний инженерчлэл		1	1
39		Утасгүй холбооны инженерчлэл			
40	Нээлттэй боловсролын төв	Боловсрол судлал	16	2	18
41	Үйлдвэрлэлийн технологийн сургууль	Хувцас үйлдвэрлэлийн технологи, загвар зохион бүтээлт		1	1
42		Нэхмэлийн үйлдвэрлэлийн технологи	2		2
43		Ой судлал		1	1
44		Хүнсний үйлдвэрлэлийн машин тоног төхөөрөмж			
45		Хөнгөн үйлдвэрлэлийн машин тоног төхөөрөмж			
46		Хүнс үйлдвэрлэлийн технологи			
47		Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний технологи			
48		Хүнс судлал	2	1	3
49		Дизайн, урлаг судлал	3	1	4
50	Хэрэглээний шинжлэх ухааны сургууль	Хэрэглээний математик			
51		Физик			
52		Химийн боловсруулалтын технологи	1		1
53		Нүүрсний боловсруулалтын технологи			
54		Газрын тосны боловсруулалтын технологи	1		1
55		Ховор ба үнэт металлын химийн технологи			
56	Эрчим хүчний сургууль	Экологийн технологи	1		1
57		Сэргээгдэх эрчим хүч			
58		Цахилгааны инженер	4		4
59		Дулааны эрчим хүч ба үйлдвэрлэл		1	1
Нийт			93	29	122

Сургалт эрхлэх тусгай зөвшөөрлөөр батлагдсан 59 хөтөлбөр хэрэгжиж байгаагаас 34 хөтөлбөрөөр 2022-2023 оны хичээлийн жилд элсэлт авч, сургалтын үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.

МАГИСТР, ДОКТОР ОЮУТНЫ “ЭРДМИЙН ЧУУЛГАН 2023” ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ

2022-2023 оны хичээлийн жилийн хаврын улиралд “Магистр, доктор оюутны эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах удирдамж”-ийг боловсруулан, их сургуулийн Захирлын 2023 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн А/85 тоот тушаалаар батлуулж, хурлыг 2023 оны 4 дүгээр



сарын 27-28-ны өдрүүдэд зохион байгууллаа. Шилдэг судалгааны илтгэл өгүүллийг шалгаруулах комиссын бүрэлдэхүүнд бүрэлдэхүүн сургуулийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга болон бусад багш нар идэвхтэй хамтран ажилласан.



5 дугаар зураг. Магистр, доктор оюутны эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах хөтөлбөр

2022-2023 оны хичээлийн жилийн хаврын улиралд магистр, доктор оюутны эрдэм шинжилгээний хурлыг техник, нийгэм, хүмүүнлэг, байгалийн ухааны чиглэлээр 3 салбар хуралдаан болгон зохион байгуулсан.

Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг магистр, доктор оюутны эрдэм шинжилгээний хуралд техникийн ухааны чиглэлээр 23, нийгэм, хүмүүнлэгийн ухааны чиглэлээр 9, байгалийн ухааны чиглэлээр 12 илтгэлийг тус тус хэлэлцүүлж, магистрантын 9, докторантын 7 илтгэлийг шилдэг илтгэлээр шалгаруулан батламж, их сургуулийн Захирлын 2023 оны 5 дугаар сарын 08-ны өдрийн А/163 тоот тушаалаар 16 оюутанд нийт 32.5 кредитийн урамшуулал олгосон. Магистр, доктор оюутны 23(09)-315 дугаар бүхий “Эрдмийн чуулган-2023 магистр, доктор оюутны эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл”-ийг эмхэтгэтгэн хэвлүүлээ.

19 дүгээр хүснэгт

Шилдэг өгүүллээр шалгарсан бүтээлүүд

д/д	Овог, нэр	Сургууль, төв	Илтгэлийн сэдэв	Эзэлсэн байр
ТЕХНИКИЙН УХААНЫ САЛБАР				
Магистрант				
1	Ө.Халиун	БАС	Төмөрбетон каркасан барилгын газар хөдлөлийн ажиллагааг статик хүчний үйлчлэлд тулгуурлан үнэлэх аргачлал боловсруулах судалгаа	I
2	Н.Ичинхорлоо Б.Чинзориг Б.Лхагвадэмбэрэл	ЭХС	ЦДУС-ТӨХК-ийн 110 кВ-ын өндөр ачаалалтай богино шугамуудаар холбогдсон тойрог схемийн реле хамгаалалт, автоматикийн найдвартай ажиллагааг дээшлүүлэх нь	II
3	Ө.Энх-Амар Г.Отгонбаяр	ЭХС	Цагариг хэлхээтэй дулааны сүлжээний тохируулгын хувилбаруудын тооцооны харьцуулалт	III
Докторант				
1	А.Алтанхуяг	МХТС	A multi-omics data integration approach for drug repurposing study	I
2	Д.Уранчимэг	БАС	Бэхжилтийн ялгаатай орчин бетоны бат бэх, сүвэрхэг чанарт нөлөөлөх байдлын судалгаа	II
3	Г.Ганбаатар	МөхТС	Жишүү хүрдэт шигшүүрийн үндсэн хэмжээст хийсэн үр дүн	III
НИЙГЭМ, ХҮМҮҮНЛЭГИЙН УХААНЫ САЛБАР				
Магистрант				
1	Ө.Анужин	БАТС	Манлайлал нь байгууллагын ажилтны гүйцэтгэлд нөлөөлөх нь	I
2	Э.Отгонбаяр	ГХС	Техник технологийн метафоржсон нэр томъёоны судалгаа	II
Докторант				



1	Д.Баярмаа	БУХС	Байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын шалгуур үзүүлэлтүүдийг хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтад нэгтгэх нь	II
БАЙГАЛИЙН УХААНЫ САЛБАР				
Магистрант				
1	И.Халиунаа	ГУУС	Хан-Алтай алтны ордын хүдэржилт, хувирал	I
2	А.Алтанбагана	ҮТС	Бортогонд үр тарих ажлын механикжуулах боломжийн судалгаа, зохион бүтээлт	II
	Т.Эрдэнэтуул	ҮТС	Хаягдал олсон утсыг дахин боловсруулах технологийн судалгаа	II
3	Х.Ариунтуяа	ХШУС	Зэсийн баяжмалын химийн найрлагын харьцуулсан судалгаа	III
Докторант				
1	Н.Болдбаатар	БАС	Урьдчилсан цэвэрлэгээний тусламжтайгаар механик цэвэрлэгээний үр дүнг сайжруулах судалгаа	I
2	А.Анхбаяр	МХТС	Deep learning based Sers detection model development for COVID-19	II
3	Т.Гэрэлтуяа	ХШУС	Амьдрах хугацааны тархалтын мөхлийн эрчмийн үнэлэлтийг цензуртэй өгөгдлийн хувьд байгуулах	III



6 дугаар зураг. Шалгарсан бүтээлд олгосон батламж



7 дугаар зураг. Эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэл 23(09)-315

Ахисан түвшиний сургалт, судалгааны үйл ажиллагаанд ШУА-ийн харьяа хүрээлэнгүүдтэй хамтран ажиллах, хамтын ажиллагаа

ШУА-ийн ерөнхийлөгч ба ШУТИС-ийн ректорын 2015 оны 10 дугаар сарын 26-ны А/144 тоот хамтарсан тушаал, түүнийг хэрэгжүүлэх 2015 оны 3 дугаар сарын 11-ний өдөр байгуулсан хамтран ажиллах гэрээгээр Шинжлэх ухааны академи ба ШУТИС-ийн хамтарсан докторантурын сургалт явуулах журам батлагдсан.

2014 оноос хойш ШУА-ийн Хими, химийн технологийн хүрээлэнгээс 6, Физик технологийн хүрээлэнгээс 1, Одон орон, геофизикийн хүрээлэнгээс 4, Геологийн хүрээлэнгээс 4, нийт 15 суралцагч докторантурын сургалтад хамрагдсан суралцаж байна. Үүнээс ХААИС руу 1 докторант шилжиж, докторын зэрэг хамгаалсан 3, сургалт дүүргэж гэрчилгээ авсан 5, суралцаж буй 5, чөлөө авсан 1 докторант байна.

Монгол улсын Шинжлэх ухааны академийн 2020 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 1/273 тоот “Хамтын ажиллагааг эрчимжүүлэх тухай” албан бичиг ирсний дагуу



ШУА-ийн харьяа хүрээлэнгүүдээс ШУТИС-ийн докторантурт суралцаж байгаа докторант нарын мэдээллийг нэгтгэн, “Шинжлэх ухааны академи ба ШУТИС-ийн хамтарсан докторантурын сургалт явуулах журам”-ын 5.2-т заасныг үндэслэл болгон зарим нэгэн асуудлын талаар санал солилцох, харилцан шийдвэрлэх шаардлага бий болсон.

20 дугаар хүснэгт

ШУА-ийн харьяа хүрээлэнгүүдээс ШУТИС-ийн докторантурт суралцаж байгаа докторантуудын хичээл сонголт, сургалтын кредит цагийн гүйцэтгэл /2022-2023 оны хичээлийн жилийн намрын улирал/


д/д	Элссэн сургууль	Элссэн он	Суралцаж буй мэргэжил (хөтөлбөр)	Овог	Нэр	Суралцаж буй байдал, судалсан кредит /кр/	Хүрээлэнгийн нэр
1	ҮТС	2020	Хоол зүй, шим судлал	Балтсүх	Оюунтуяа	Суралцаж байгаа /27кр/	Хими, химийн технологийн хүрээлэн
2	ХШУС	2020	Химийн технологи	Силам	Ален	Сургалт дүүргэсэн сертификат авсан.	Хими, химийн технологийн хүрээлэн
3	ХШУС	2017	Химийн технологи	Уяат	Баярзул	Сургалт дүүргэсэн сертификат авсан.	Хими, химийн технологийн хүрээлэн
4	ХШУС	2014	Химийн технологи	Ганхүрэл	Ганзаяа	ХААИС руу шилжсэн.	Хими, химийн технологийн хүрээлэн
5	ХШУС	2014	Нүүрсний боловсруулалтын химийн технологи	Сонинхүү	Жаргалмаа	Докторын зэрэг хамгаалсан	Хими, химийн технологийн хүрээлэн
6	ХШУС	2016	Газрын тосны боловсруулалтын технологи	Жаргалсайхан	Намхайноров	Сургалт дүүргэсэн сертификат авсан.	Хими, химийн технологийн хүрээлэн
7	ЭХС	2020	Сэргээгдэх эрчим хүч	Батсуурь	Мөнгөнцацрал	Суралцаж байгаа /27 кр/	Физик технологийн хүрээлэн
8	ГУУС	2020	Геологи	Шарав	Амаржаргал	Суралцаж байгаа /9/	Одон орон, геофизикийн хүрээлэн
9	ХШУС	2019	Инженер физик	Мэнд	Билгүүн	Чөлөө авсан	Одон орон, геофизикийн хүрээлэн
10	ГУУС	2014	Геологи	Цэнд-аюуш	Нямбаяр	Докторын зэрэг хамгаалсан	Одон орон, геофизикийн хүрээлэн
11	ГУУС	2014	Геологи	Данзансан	Эрдэнэзул	Докторын зэрэг хамгаалсан	Одон орон, геофизикийн хүрээлэн
12	ГУУС	2019	Геологи	Доржсүрэн	Отгонбаатар	Суралцаж байгаа /48/	Геологийн хүрээлэн
13	ГУУС	2020	Геологи	Батхуяг	Энхдалай	Суралцаж байгаа /33/	Геологийн хүрээлэн
14	ГУУС	2019	Геологи	Отгон	Одбаяр	Суралцаж байгаа /12/	Геологийн хүрээлэн
15	ГУУС	2014	Геологи	Пунцаг	Дэлгэрзаяа	Суралцаж байгаа /12/	Геологийн хүрээлэн

ДОКТОРАНТУРЫН СУРГАЛТЫН ТӨГСӨЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА



2022-2023 оны хичээлийн намрын улиралд докторантын сургалт, судалгааны ажлын явцын түвшин тогтоох сарын ажлыг зохион байгуулах удирдамжийг батлуулан, докторантын сургалт, судалгааны ажлын түвшнийг тогтоож, мэргэжлийн нэгдсэн шалгалт авах ажлыг хичээлийн жилийн явцад 2 удаа зохион байгуулсан.

Докторантурын сургалт дүүргэсэн гэрчилгээ авахаар хүсэлт гаргасан докторант нарын материалыг хүлээн авч хяналтын магадалгаа хийн, их сургуулийн Захирлын 2023 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн А-47 тоот тушаалаар 22, 2023 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн А-57 тоот тушаалаар 6 докторантад доктор (Ph.D)-ын сургалтыг дүүргэснийг гэрчлэх гэрчилгээ олгож, нийт 28 докторантыг 2022-2023 оны хичээлийн жилд горилогчоор баталсан.



5 дугаар зураг. Докторантурын сургалт дүүргэж сертификат авсан горилогчдын судалгаа (Бүрэлдэхүүн сургууль, төв тус бүрээр)


Доктор(Ph.D)-ын зэрэг хамгаалж, төгссөн эрдэмтдийн мэдээлэл

Сүүлийн 5 жилийн байдлаар ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургууль, институт, төвийн докторантурын сургалтыг дүүргэж, 113 горилогч доктор(Ph.D)-ын зэрэг хүртсэн байна.

21 дүгээр хүснэгт

ШУТИС-ийн докторантур төгсөгчдийн тоо (2018-2023 оны байдлаар)

Сургууль, төвийн нэр	Хичээлийн жил /он/					Нийт
	2018/2019	2019/2020	2020/2021	2021/2022	2022-2023	
БАС	0	0	1	5	2	8
БАТС	4	3	3	7	1	18
БуХС	0	2	0	2	0	4
ГУУС	1	1	0	8	7	17
MexTC	4	6	0	4	2	16
МХТС	1	0	1	3	2	7
YTC	2	0	0	3	0	5
ХШУС	6	1	1	4	3	15
ЭХС	1	5	1	2	2	11
ОУДБСТ/НБТ	3	1	1	1	0	6
ГХИ/ГХС	1	4	0	1	0	6
Нийт	23	23	8	40	19	113



8 дугаар зураг. Доктор(Ph.D)-ын зэрэг хүртсэн эрдэмтдийн тоо (Бүрэлдэхүүн сургууль, төв тус бүрээр)

2022-2023 оны хичээлийн жилийн намрын улиралд ШУТИС-ийн Захирлын 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн тоот тушаалаар 8, хаврын улиралд 2023 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн А/139 тоот тушаалаар 7, 2023 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн А/210 тоот тушаалаар 5, нийт 20 горилогч диссертация амжилттай хамгаалан, доктор(Ph.D)-ын зэрэг хүртсэн.

22 дугаар хүснэгт

2022-2023 оны хичээлийн жилд доктор(Ph.D)-ын зэрэг хамгаалсан эрдэмтэд

д/д	Овог, нэр	Докторын зэрэг	Судалгааны ажлын сэдэв
1	Дашдондовын Ургамалсүвд	Техникийн ухааны	Газрын тосны бүтээгдэхүүн хадгалах босоо ган савны ашиглалтын судалгаа
2	Дүгэрсүрэнгийн Энхбаатар	Техникийн ухааны	Монгол орны нөхцөлд өвлийн бетон цутгалтын технологийн төсөллөлтийг боловсронгуй болгох нь
3	Баяраагийн Бямбадагва	Техникийн ухааны	Ил уурхайн автогэврийн системийн энерги зарцуулалтын судалгаа
4	Эрдэнэдалайн Уранчимэг	Техникийн ухааны	Уул уурхайн салбарт ашиглах сайжруулсан анфо тэсрэх бодисын хими технологийн судалгаа
5	Отгоны Олдох	Химийн ухааны	Нарийн навчит цахилдаг (<i>iris tenuifolia pall.</i>) Ургамлын газрын доод хэсгийн фитохими ба биологийн идэвхийн судалгаа
6	Дагвийхоролын Наранчимэг	Физикийн ухааны	Нягтын функционалын онолоор атомын үндсэн болон өдөөгдсөн төлөвийг тооцоолох нь
7	Данзансангийн Эрдэнэзул	Геологи, эрдэс судлалын	Монгол орны царцдасын шилжих хөдөлгөөний хурд ба деформацийн судалгаа
8	Балжиннямын Түмэндэлгэр	Менежментийн	Хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх мега төслийг сонгох арга зүйн асуудал
9	Очирбатын Отгоннаран	Техникийн ухааны	Био-тооцоолох төхөөрөмжийн зохиомж, компьютер симуляцийн судалгаа
10	Агваанцэрэнгийн цэцэгмаа	Техникийн ухааны	Автомашинь дизель хөдөлгүүрийн хорт хаягдлыг бууруулах судалгаа (Улаанбаатар хотын нийтийн тээврийн bs106 маркын автобусны жишээн дээр)
11	Такибайн шахслам	Техникийн ухааны	Дулааны цахилгаан станцын хөвмөл үнсний судалгаа ба автоклавын бус хийт бетоны үйлдвэрлэлд ашиглах нь (Казакстаны павлодарийн



			(екибастузын) дулааны цахилгаан станцын үнсний жишээн дээр)
12	Мягмарсүрэнгийн Оюун-эрдэнэ	Техникийн ухааны	Монголын бэлчээрийн малын махны хүйтний боловсруулалтын судалгаа
13	Жинчингийн Нандагсамба	Техникийн ухааны	Ухаалаг цахилгаан шугам сүлжээний бүтцийн загвар боловсруулах
14	Төмөрбаатарын мөнхбат	Техникийн ухааны	Хүндийн өргөлтийн тамирчдын техникийн кинематик шинжилгээ
15	Дармаагийн сурмаажав	Техникийн ухааны	Бага хүчин чадалтай нүүрсний ил уурхайн тэсэлгээний ажлын судалгаа
16	Дамбын Батжаргал	Геологи-эрдэс судлалын	Сав газрын газар доорх усны нөөц бүрэлдэн тархах зүй тогтол (Орхон голын сав газрын жишээн дээр)
17	Гэндэндоржийн Тунгалаг	Геологи-эрдэс судлалын	Хөшигийн хөндийн инженер-геологийн нөхцөл ба неогены хурдсын норматив үзүүлэлтийн судалгаа
18	Батгэрэлийн Улаанбаатар	Техникийн ухааны	Хүдрийн ил уурхайн ажлын бус хажуугийн параметруудийг тогтворжилтын нөхцөлөөр тодорхойлох судалгаа
19	Базаргүрийн Батзориг	Техникийн ухааны	Гүний уурхайн холбооны системийн найдваржилтын судалгаа
20	Ишгээгийн Гэрэлмаа	Менежментийн ухааны	Чанарын удирдлагын тогтолцооны загвар боловсруулах нь (Монгол улсын авто замын жишээн дээр)


Докторантурт суралцагчдын голч дүнгийн судалгаа

2022-2023 оны хичээлийн жилд докторантурт суралцагчдын голч дүнд шинжилгээ хийж үзэхэд доктор оюутны голч дүнгийн дундаж 3.75 байна.

23 дугаар хүснэгт

Докторантурт суралцагчдын голч дүнгийн судалгаа

Дд	Сургууль	Намар		Хавар		Голч дүнгийн дундаж
		Оюутны тоо	Голч дүн	Оюутны тоо	Голч дүн	
1	Барилга, архитектурын сургууль	15	3.91	21	3.71	3.81
2	Бизнесийн ахисан түвшний сургууль	18	3.57	25	3.67	3.62
3	Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль	7	3.75	12	3.81	3.78
4	Гадаад хэлний сургууль	2	3.59	3	3.82	3.71
5	Геологи, уул уурхайн сургууль	43	3.82	34	3.75	3.79
6	Механик, тээврийн сургууль	7	3.77	7	3.68	3.73
7	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	3	4.00	3	3.64	3.82
8	Үйлдвэрлэлийн технологийн сургууль	16	3.92	8	3.60	3.76
9	Хэрэглээний шинжлэх ухааны сургууль	3	3.45	4	3.71	3.58
10	Эрчим хүчний сургууль	9	3.88	12	3.87	3.88
11	Нээлттэй боловсролын төв	9	3.65	22	3.26	3.46
ШУТИС		132	3.76	151	3.68	3.72



9 дүгээр зураг. Доктор оюутны голч дүнгийн судалгаа
(Бүрэлдэхүүн сургууль, төв тус бүрээр)

3.16. ИННОВАЦ, ТЕХНОЛОГИ ДАМЖУУЛАЛТ

3.10.3. ЗОХИОН БАЙГУУЛСАН АРГА ХЭМЖЭЭ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛСАН СУРГАЛТ, СЕМИНАР

- “Оюуны өмчийг эргэлтэд оруулах, менежментийн асуудал” сургалт

Инновац, технологи дамжуулалтын төв нь үйл ажиллагааныхаа үндсэн чиглэлийн хүрээнд тус сургалтыг их сургуулийн эрдэм шинжилгээ, инновацын бодлогыг хэрэгжүүлэгч баг болох бүрэлдэхүүн сургууль, хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, эрдэм шинжилгээ, инновацын ажилтнууд болон судалгааг дэмжих алба, ахисан түвшний хөтөлбөрийн албаны албан хаагчдын дунд 2023 оны 2 сарын дугаар 16-ны өдөр зохион байгуулав.



Сургалтын хүрээнд БШУЯамны Шинжлэх ухаан, технологийн бодлого, инновацийн хөгжүүлэлт, хэрэгжилтийг зохицуулах газрын шинжээч Б.Урьболд “Технологи дамжуулах төв, хамтын оффист гишүүнчлэлээр бүртгүүлсэн гарааны компани болон программ хангамжийн үйлдвэрлэл, хөгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжид татварын дэмжлэг үзүүлэх журам, Оюуны өмчийн газрын шинэ бүтээл, ашигтай загварын ахлах шинжээч, Дэлхийн оюуны өмчийн байгууллагын “TISC” хөтөлбөрийн зохицуулагч Б.Одгэрэл “Их сургуулийн оюуны өмчийн менежмент” сэдвээр, ШУТИС-ийн Бизнесийн ахисан түвшний сургуулийн ахлах багш доктор Б.Түмэндэлгэр “Төсөл хөгжүүлэлт” сэдвээр, Инновац, технологи дамжуулалтын төвийн



захирал М.Зулбаяр их сургуулийн инновац, технологи дамжуулалтын төвөөс оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулахад барьж бодлого зорилт, их сургуулийн өнөөгийн дүрэм журмын талаар талуудад мэдээлэл хүргэв.

• **“Инновацын төслийг хөгжүүлж, гарааны компани байгуулах” чадавхжуулах сургалт**

Инновац, технологи дамжуулалтын төв нь судалгааны үр дүнгээрээ гарааны компани байгуулах зорилготой багш, судлаачдын дэмжих, амжилттай үйл ажиллагаа явуулах гарааны компанийг бий болгох зорилгынхоо хүрээнд Инновацын төсөл хөгжүүлэх, гарааны компани байгуулах” бойжуулах хөтөлбөрийг 2023 оны 2 дугаар сараас эхлэн хэрэгжүүлж эхлэв.



Тус хөтөлбөрт хамрагдахаар бүртгүүлсэн баг, старт-ап санаачлагчдад **“Инновацын төслийг хөгжүүлж, гарааны компани байгуулах”** чадавхжуулах сургалтыг 2023 оны 2 сарын 7-ны өдөр зохион байгуулав. Сургалтаар гарааны компани байгуулах боломж, тавигдах шаардлагыг хэрхэн хангах талаар зөвлөгөө, мэдээлэл хүргэв. Сургалтад Бойжуулах хөтөлбөрийн I ээлжийн элсэгч багууд болох “Эрчим хүчний хэмнэлтийн үйлчилгээ”-ний төсөл хэрэгжүүлэх Б.Сэргэлэн ахлагчтай баг, “Хатуу хайлшны үйлдвэрлэл”-ийн төсөл хэрэгжүүлэх М.Дэлгэрмаа ахлагчтай баг, “CNC машины үйлдвэрлэл үйлчилгээ” -ний Б.Баянжаргал ахлагчтай баг, “Физикийн сургалтын тоног төхөөрөмж үйлдвэрлэл”-ийн Г.Зоригт ахлагчтай баг, “Дулаан хангамжийн менежментийн үйлчилгээний П.Бямбацогт ахлагчтай STES багууд хамрагдлаа.



Сургалтын хүрээнд хөтөлбөрийн ерөнхий ментор доктор Б.Түмэндэлгэр “Инновацын төсөл хөгжүүлэх, гарааны компани байгуулах” бойжуулах хөтөлбөрийн агуулга, хүрэх үр дүнгийн талаар мэдээлэл хүргэсэн бол Оюуны өмчийн газрын патентын ахлах шинжээч Б.Одгэрэл патентын мэдүүлэг, түүний онцлогийн талаар хөтөлбөрт хамрагдаж буй багуудад мэдээлэл хүргэж, багуудад оюуны өмчийн талаар тулгарч буй асуудлаар зөвлөгөө хүргэлээ. Сургалтын үеэр хөтөлбөрт хамрагдсан багуудтай хамтран ажиллах гэрээг Инновац, технологи дамжуулах төвөөс байгууллаа.




- **“Төслийн санхүүжилт, өртөг зардлын тооцоолол, тайлагнал” сургалт**

Гарааны компанийн үйл ажиллагаа явуулах багш, судлаачдад тулгардаг бэрхшээл нь аж ахуй нэгжийн нягтлан бодох бүртгэлийн асуудал тэр дундаа санхүүжилтийн асуудал байдаг. Төвийн зүгээс “Инновацийн төслийг хөгжүүлж, гарааны компани байгуулах” хөтөлбөрт хамрагдаж байгаа багууддаа зориулж санхүүгийн тайлагнал, зөрдөл, өртгийн тооцоолол, төслийн санхүүжилтийн талаар сургалтыг 2023 оны 4 дүгээр сарын 7-ны өдөр зохион байгууллаа. Сургалтын санхүүгийн тайлагнал сэдвийг бизнесийн удирдлагын салбарын ахлах багш Ц.Баярцог, зардал, өртгийн тооцоолол сэдвээр профессор Л.Оюунцэцэг сургалт явуулсан бол төслийн санхүүжилтийн асуудлаар хөтөлбөрийн ерөнхий ментор доктор Б.Түмэндэлгэр оролцогчдод сургалт зохион байгууллаа.



- **“Хөрөнгө оруулагчдад зориулсан бизнес төлөвлөгөө боловсруулах” сургалт**

2023 оны 6 дугаар сарын 9-ны өдөр “Инновацийн төслийг хөгжүүлж, гарааны компани байгуулах” хөтөлбөрийн зүгээс нийт оролцогч багуудад зориулсан цуврал сургалтын хүрээнд “Хөрөнгө оруулагчдад зориулсан бизнес төлөвлөгөө боловсруулах” сургалтыг зохион байгуулав. Сургалтаар гарааны компанийн зүгээс хөрөнгө оруулагчдад хэрхэн бизнес төлөвлөгөөгөө танилцуулах тухай танилцууллаа.



- **“Технологид суурилсан гарааны компани байгуулах боломж, туршлага” семинар**

Инновац, технологи дамжуулалтын төвөөс нийт багш, судлаач, сонирхогч талуудад зориулж Технологид суурилсан гарааны компани байгуулах боломж, туршлага” семинарыг 2023 оны 6 дугаар сарын 19-ны өдөр “Инженер технологийн дээд боловсрол” төслийн М.Дэлгэрмаа ахлагчтай судалгааны багтай хамтран зохион байгууллаа. Семинарын хүрээнд олон улсад технологийн компани хөгжүүлэгч, эксперт болох Япон улсын NJS-Japan компанийн захирал Масао Токита оролцож Монгол улсад хөгжүүлж болох гарааны компани, технологийн талаар сонирхолтой яриа өрнүүлэв. Монгол улсын аж үйлдвэрийн салбарын хөгжилд өндөр хувь нэмэр оруулж болох SPS (Spark Plasma Sintering) тохногийн давуу талууд ШУТИС-д хэрэгжүүлэх асуудлаар туршлага солилцож загвар бүтээгдэхүүнээ танилцууллаа. Семинарт Нагаока технологийн их сургуулийн профессор Макато Нанко оролцож ШУТИС-ийн багш, профессоруудтай хамтын ажиллагааны талаар санал солилцлоо.



САНААЧЛАН ЗОХИОН БАЙГУУЛСАН АРГА ХЭМЖЭЭ

- “MUST Student Start Up-2023” уралдаан

“Монголын инновацийн 7 хоног -2023” арга хэмжээний хүрээнд MUST Start-Up” оюутны гарааны бизнесийн уралдааныг 2023 оны 3 дугаар сарын 18-ны өдрөөс 5 дугаар сарын 10-ны өдрийн хооронд зохион байгууллаа.

Уралдаанд нийт бүрэлдэхүүн сургуулиудаас 26 баг оролцсоноос сүүлийн шатанд Мэдээлэл, холбооны технологийн сургуулийн 8 баг, ШУТИС-Коосэн технологийн коллежийн 2 баг, Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн 1 баг тус тус шалгарч хурдасгуур хөтөлбөрт хамрагдан 2023 оны 5 сарын 10-ны өдөр сүүлийн шатны шалгаруулалт “Demo Day”-д оролцлоо.



Уралдааны сүүлийн шалгаруулалт буюу “Demo Day” арга хэмжээ Старт-Ап аргачлалын дагуу ШУТИС-ийн Эрдэм шинжилгээ, инновацийн төв байранд явагдаж багууд асуудал, шийдэл, бизнес модел гэх зэрэг агуулгаар өөрсдийн зохион бүтээсэн, санаачилсан бүтээгдэхүүн, үйлчилгээгээ шүүгч, олон нийтэд танилцуулснаас 1 дүгээр байранд ШУТИС-ийн



Коосэн Технологийн коллежийн оюутны баг “SF (SafetyFirst)” шалгарч 3 сая төгрөгийн бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн зардлын грант хүртсэн бол Мэдээлэл, холбооны технологийн сургуулийн оюутнуудын “Хангарьд” баг үйлдвэрлэгч, борлуулагч, хэрэглэгчдийг холбосон “Smart Sales” гэх мэдээллийн технологид суурилсан бүтээгдэхүүнээрээ шалгарлаа. Гуравдугаар байранд Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн “Хармаг” баг хүнсний салбарт шинэ төрлийн бүтээгдэхүүн нэвтрүүлэх санаагаараа шалгарав.





М.ЗУЛБААР
ШУТИС-ийн ИННОВАЦ ТЕХНОЛОГИ ДАМЖУУЛАЛТЫН ТӨВ-ийн ЗОРИЛТ

БҮРЬБОЛД
БЭЛГЭСЭЭ, ШИНЖЭЭЛЭХ АЖААНЫ БИЭРИЙН ХААЛ, ТЭХНИК УМАА ПЕРСОНАЛ ИННОВАЦИЙН АЖУУРААДЫГ ДЭГЭЭЖИЛГЭЭГЭЙ ТӨВ-ӨСӨНГӨН ХӨТӨЛБӨРИЙН ШИНЖЭЭ

Д.ЗОЛЗАА
БЭЛГЭС АЖУУРААДЫН ХӨТӨЛБӨР, ТЭХНИК УМАА ПЕРСОНАЛ ИННОВАЦИЙН АЖУУРААДЫГ ДЭГЭЭЖИЛГЭЭГЭЙ ТӨВ-ӨСӨНГӨН ХӨТӨЛБӨРИЙН ШИНЖЭЭ

Б.МАНДХАЙ
БААНЫ БИЗНЕСИЙН УРАЛДААН ХӨТӨЛБӨР, ТЭХНИК УМАА ПЕРСОНАЛ ИННОВАЦИЙН АЖУУРААДЫГ ДЭГЭЭЖИЛГЭЭГЭЙ ТӨВ-ӨСӨНГӨН ХӨТӨЛБӨРИЙН ШИНЖЭЭ

О.МӨНХНАСАН
БИЗНЕСИЙН ШИНЖЭЭЛЭХ АЖААНЫ БИЭРИЙН ХААЛ, ТЭХНИК УМАА ПЕРСОНАЛ ИННОВАЦИЙН АЖУУРААДЫГ ДЭГЭЭЖИЛГЭЭГЭЙ ТӨВ-ӨСӨНГӨН ХӨТӨЛБӨРИЙН ШИНЖЭЭ

ШҮҮГЧДИЙН БАГ

ГАРААНЫ БИЗНЕС, БҮТЭЭГДЭХҮНЭЭ ТАНИЛЦУУЛАХ БАГУУД

SOFTI	МХТС
SHOWSHOW BOT	МХТС
SWEBER CHAIN	МХТС
ENG TEAM	КОССЭН
JUSTDOIT	МХТС
KHANGARDI	МХТС
LIMS SYSTEM	МХТС
SPASAFETY FIRST	КОССЭН
STARFALL	МХТС
XARMAГ	УТС
EVASCENSION	МХТС

БАГУУДИЙН ТАНИЛЦУУЛАГА ӨР УНШУУЛНА УУ.



УРИЛГА

Эрхэл хандэт танив

"Монголын инновацийн 7 хоног 2023" арга хэмжээний хүрээнд зохион байгуулагдаж буй "MUST Start-Up 2023" оюутны гарааны бизнесийн уралдааны сүүлийн шатны шалгаруулалт "DEMO Day"-д хуралцан ирэхийг урьж байна

05 САРЫН 10-НЫ 14:00 ЦАГТ

ШУТИС - VIII БАЙР, 12 ДАВХАРТ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЛЙН
ТАНХИМ

ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:
ШУТИС-ийн ИННОВАЦ ТЕХНОЛОГИ ДАМЖУУЛАЛТЫН ТӨВ
БИЗНЕСИЙН УРАЛДААН, ХӨТӨЛБӨРИЙН ШИНЖЭЭ



ИННОВАЦ, ТЕХНОЛОГИ ДАМЖУУЛАЛТЫН ТӨВ
INNOVATION AND TECHNOLOGY TRANSFER OFFICE

МОНГОЛЫН INNO3 StartUP Week "MUST START-UP" ОЮУТНЫ БААНЫ БИЗНЕСИЙН УРАЛДААН

2,000,000₮

Уралдааны хурдасгуур хөтөлбөрийн ерөнхий ментороор МУИС-ийн Бизнесийн сургууль, Менежментийн тэнхимийн багш Н.Батсүх ажилласан бол менторуудаар ийн технологийн менежментийн багш нар болон ШУТИС-ийн Инновац, технологи дамжуулалтын төв ажиллалаа.

- ШУТИС-ийн аварга шалгаруулах “MUST Roboson-2023” уралдаан



Инновац, технологи дамжуулалтын төвөөс Механик тээврийн сургуультай хамтран “MUST Roboscon-2023” ШУТИС-ийн аварга шалгаруулах тэмцээнийг 2023 оны 5 дугаар сарын 16-ны өдөр зохион байгууллаа. Тэмцээнд Механик тээврийн сургуулийн “НТЛ”, “Pro Mech”, ШУТИС-Коосэн технологийн коллежийн “Ган робот”, Эрчим хүчний сургуулийн “Эрчим”, Мэдээлэл, холбооны технологийн сургуулийн “High Tech” зэрэг багууд өрсөлдөв. Тус тэмцээн нь ШУТИС-ийн багуудыг үндэсний аварга шалгаруулах тэмцээнд бэлтгэх сорилго бөгөөд оюутан залуус бэлтгэл хугацаанд өөрсдийн хийж бүтээсэн роботоороо ур чадвараа сорисноос Механик тэврийн сургуулийн “НТЛ” баг нийт хожлын дүнгээр тэргүүн байр эзлэв. ШУТИС-Коосэн технологийн коллежийн залуусын “Ган робот” тэмцээний 2 дугаар байранд шалгарсан бол гуравдугаар байранд Механик тээврийн сургуулийн “ProMech” баг, тусгай байруудад Эрчим хүчний сургуулийн “Эрчим”, Мэдээлэл холбооны технологийн сургуулийн “High Tech” багууд шалгарлаа. Тэмцээнийг олон улсын дүрмийн дагуу зассан талбайд зохион байгуулж, багууд тус талбайд үндэсний тэмцээний бэлтгэлээ үргэлжлүүлэн явуулах бөгөөд тэмцээнд оролцсон багуудад робот хөгжүүлэлтийн зардал олгов.

- **ICIED-2023 Олон улсын эрдэм шинжилгээний хурал**

“Монголын инновацын 7 хоног”-ийн арга хэмжээний хүрээнд “ICIED-2023” буюу “Инновац ба энтрепренершипийн хөгжил” олон улсын эрдэм шинжилгээний 9 дэх удаагийн хурлыг хамтран 2023 оны 5 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулав. Олон улсын хуралд БШУЯ-ны ШУТ, инновацын бодлогын хэрэгжилтийг хангах газрын дарга Д.Баттогтох, ШУТИС-ийн Эрдэм шинжилгээ, технологийн асуудал хариуцсан дэд захирал Д.Цолмонбаатар, Азийн Бүтээмжийн Байгууллага (АРО)-ын Олон улсын хөтөлбөрийн зохицуулагч Асайтамби Маникам, Бангладеш улсын Аж үйлдвэрийн яам, Камбож улсын Аж үйлдвэр, шинжлэх ухаан, технологи, инновацын яам, Индонез улсын Хоршоолол, ЖДҮ-ийн яам, Лаосын БНУ-ын Худалдаа, Аж үйлдвэрийн Яам, Пакистан Улсын Азад Жамму ба Кашмирын их сургууль, БНХАУ, БНСУ, Тайланд улсын бүтээмжийн төвүүдийн төлөөллүүд зэрэг дэлхийн 19 орны 30 гаруй гадаадын зочид, дотоодын эрдэмтэд, судлаачид, профессор, багш нар, ахисан түвшний оюутнууд, мэргэжилтнүүд зэрэг 100 гаруй төлөөлөгчид оролцлоо.



“Инновацын түншлэл-2023” форум



Инновацын соёлыг түгээх, харилцан мэдлэг туршлага солилцох, түншлэлийн бэхжүүлэх "Инновацын түншлэл-2023" форумыг зохион байгуулагч талуудтай хамтран Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхимд 2023 оны 6 дугаар сарын 5-ны өдөр зохион байгуулав. Тус арга хэмжээний үеэр төр, шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн салбарынхан хамтын ажиллагааны зорилт, шийдэл, боломжуудын талаар хэлэлцэж, аж ахуй нэгж байгууллагууд төр, эрдэм шинжилгээ, үйлдвэрийн хамтын ажиллагааны сайн туршлагуудаа хуваалцлаа. Форумд их сургуулийн эрдэмтэд судалгаа хөгжүүлэлтийнхээ үр дүнг үндэсний брэнд болгон хөгжүүлсэн туршлага (Бүүвэй кашмер)-ын сайн жишээг оролцогчдод танилцуулав.



ИХ СУРГУУЛЬ ТӨЛӨӨЛӨН ОРОЛЦСОН АРГА ХЭМЖЭЭ

- “Шинжлэх ухаан, технологи, инновацыг орон нутагт дэлгэрүүлэх” арга хэмжээ



Шинжлэх ухаан, технологи, инновацын ололт амжилтыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, орон нутагт тулгамдаж буй асуудлыг шинжлэх ухаанд тулгуурлан шийдвэрлэх аяны хүрээнд “Шинжлэх ухаан, технологи инновацыг орон нутагт нутагшуулья” аяны 6 дахь удаагийн арга хэмжээ 2023 оны 3 сарын 28,29-ний өдрүүдэд Говь-Алтай аймагт зохион байгуулагдлаа. ИТДТөв нь арга хэмжээнд оролцох багш, судлаачдыг зохион байгуулж оролцууллаа. Багш, судлаачид “Бүс нутгийн хөгжилд инновац, технологийн үзүүлэх нөлөө” эрдэм шинжилгээний бага хуралд оролцож, инновацын бүтээгдэхүүний үзэсгэлэнд бүтээлээ танилцуулав.

- “ABU Robocon-2023” үндэсний аварга шалгаруулах тэмцээн

Ази номхон далайн оюутан залуусын техник сэтгэлгээ, инженерчлэлийн ур чадварын талбар болох “ABU Robocon” олон улсын тэмцээнд улсаа төлөөлөн оролцох багаа шалгаруулах зорилготой үндэсний аварга шалгаруулах “ABU Robocon – 2023” тэмцээн 2023 оны 5 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулагдаж ШУТИС-иас 4 баг оролцлоо. ИТДТөв нь ШУТИС-ийн багуудад робот хөгжүүлэлтийн зардал олгож, үйл ажиллагааны дэмжлэг үзүүлэн ажилласан бөгөөд Эрчим хүчний сургуулийн “Эрчим”, Механик, тээврийн сургуулийн “НТЛ”, “ProMech”, ШУТИС-Коосэн технологийн коллежийн “Ган робот” гэсэн 4 баг оролцов. Тэмцээний хагас шигшээ шатанд ШУТИС-ийн 3 баг шалгаран үлдэж, улмаар шигшээ тоглолтонд Механик тээврийн сургуулийн 2 баг шалгарсан өндөр амжилтыг үзүүлэв. Шигшээ тоглолтын дүнд “ProMech” баг ялагчаар тодорч 2023 оны 8 дугаар сарын 27-нд Камбож улсад зохион байгуулагдах олон улсын тэмцээнд эх орноо төлөөлж оролцох эрхийг авлаа. Тэмцээнд ивээн тэтгэгчээр НТЛ ХХК хамтран ажиллав.





“Монголын инновацийн 7 хоног-2023”

2015 оноос хойш зохион байгуулагдсан “Монголын инновацийн 7 хоног” арга хэмжээ 2023 онд 9 жилдээ зохион байгуулагдлаа. Тус арга хэмжээ нь өргөн хүрээний оролцогч талуудыг хамардаг бөгөөд Инновац, технологи дамжуулалтын төв нь их сургуулийн хэмжээнд арга хэмжээ зохион байгуулахаас гадна бусад арга хэмжээнүүдэд их сургуулиа төлөөлөн оролцож инновацийн экосистемийн хамтын ажиллагаагаа өргөжүүлж ажиллав. “Монголын инновацийн 7 хоног-2023” нь нийт 15 багц арга хэмжээний хүрээнд 2023 оны 5 дугаар сарын 10-наас эхлэн зохион байгуулагдаж үндсэн үйл ажиллагаа 6 сарын 5-11-ний өдрүүдэд болж өнгөрлөө.

“Монголын инновацийн 7 хоног - 2023” арга хэмжээний хөтөлбөр

06.05	06.06	06.07	06.08	06.09	06.10	06.11
<ul style="list-style-type: none"> “Инновацийн түншлэл” форум “Inclusive Society/Design Thinking” семинар Энтрепренер Судлаачдын “Эрдэм Хакатон” Дэм Дэй 	<ul style="list-style-type: none"> “DX Cup Mongolia 2023” тэмцээний Дэм Дэй Их сургуулиудын инноваци, шинэ технологийн танилцуулга, уулзалт INNOWeek Stage 	<ul style="list-style-type: none"> “Corporate social responsibility for Innovation” форум Ахлах ангийн сурагчдад зориулсан STEM воркшоп 	<ul style="list-style-type: none"> ICT Mindgolia Forum-2023 Agri Showcase Tour STEM воркшоп Best Paper Awards-2023 INNOWeek Stage 	<ul style="list-style-type: none"> ICT expo STEM воркшоп 	<ul style="list-style-type: none"> ICT expo Startup Showcase 	<ul style="list-style-type: none"> ICT expo

МОНГОЛЫН ИННОВАЦИЙН 7 ХОНОГ

ЕРӨНХИЙ ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:

МОНГОЛЫН ИННОВАЦИЙН 7 ХОНОГ

INNO WEEK 2023

ict expo '23

mindgolia

06.05 - 06.12

ХАМТРАГЧ БАЙГУУЛАГА:

- ICT & Ed Tech экспо -2023




“Монголын инновацын 7 хоног-2023” арга хэмжээний хүрээнд зохион байгуулагдсан “ICT экспо -2023” үзэсгэлэнд их сургуулийн сургалт, судалгааны үр дүнг боловсролын салбарын технологи, инновацыг танилцуулах “EdTech” үзэсгэлэнгийн талбайд зохион байгуулав. 2023 оны 6 дугаар сарын -11-ний өдрүүдэд Үндэсний соёл амралтын хүрээлэнд зохиогдсон тус үзэсгэлэн арга хэмжээнд оюутны старт-ап санаачилгууд, сургалт, судалгааны лабораториуд, төсөл хөтөлбөрүүдээ танилцуулаа.

3.17. ОЮУНЫ ӨМЧИЙН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЭЛ

Тайлант хугацаанд ИТДТөвөөс их сургуулийн оюуны өмчийн асуудлаар холбогдох хуулиуд, түүнийг хэрэгжүүлэгч агентлаг Оюуны өмчийн газрын журам, “ШУТИС-ийн Барааны тэмдэг ашиглах журам”, “ШУТИС-ийн Технологи дамжуулах журам”-ын хүрээнд үйл ажиллагаа явууллаа.



Мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх ажлын хүрээнд багш судлаачдад патентын болон зохиогчийн эрхийн мэдээллийн сангийн хайлтын тусалцаа, техник өмнөх түвшний хайлт, оюуны өмчийн мэдүүлэг боловсруулах, мэдүүлэхтэй холбоотой үйл ажиллагаа, оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах асуудал зэрэгт зөвлөн тусалж ажиллав.



ШУТИС-ийн Барааны тэмдгийн ашиглалт:

“ШУТИС-ийн Барааны тэмдэг ашиглах журам”-ын дагуу багш, судлаачдын ном, сурах бичиг, бүтээгдэхүүнд барааны тэмдэг ашиглах зөвшөөрлийг маягтын дагуу олгож, холбогдох харилцааны талаар зөвлөгөө өгч ажиллав. Нийт 25 маягтад хамаарах 1200 орчим бүтээгдэхүүнд барааны тэмдэг ашиглах зөвшөөрөл олголоо.

Барааны тэмдэг ашиглах хүсэлт гаргасан “Исоорс” ХХК-тай хамтран ажиллаж барааны тэмдэг ашиглах лицензийн гэрээ байгуулав. Гэрээ нь барааны тэмдгийн бараа, үйлчилгээний олон улсын ангиллын (nice classification) “16” дугаар ангиллын дагуу бүтээгдэхүүн үйлдвэрлэх эрхийг тус компанид 1 жилийн хугацаагаар олголоо.



3.18. СУДАЛГААНЫ ТӨВҮҮДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА


ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГААНЫ ТӨВҮҮДИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

ШУТИС-ийн хэмжээнд 2022-2023 оны хичээлийн жилд нийт эрдэм шинжилгээ, судалгааны 41 төв үйл ажиллагаа явуулж байгаагаас БАС-7 төв, БухС-1 төв, МХТС-1 төв, ҮТС-5 төв, ХШУС-3 төв, ГУУС-11 төв, ДаТС-1 төв, МехТС-5 төв, ЭХС-7 төвтэй байна 2023 оны 05 сарын 02-ны өдрийн А/147 дугаар тушаалаар Механик тээврийн сургуулийг түшиглэн эрдэм шинжилгээ, судалгааны “Металлурги, дэвшилтэт технологийн судалгааны төв”, “Машин үйлдвэрлэлийн инновацын төв” шинээр байгуулагдан үйл ажиллагаа эрхэлж байна.

Тайлант хугацаанд эрдэм шинжилгээ, судалгааны төвүүдийн үйл ажиллагааг ангилан авч үзвэл “Төсөл, гэрээт ажил хэрэгжүүлсэн байдал”- 186, “Шинэ технологи, аргачлал боловсруулах, инноваци дамжуулалтыг хөгжүүлсэн байдал” - 48, “Эрдэм шинжилгээний хурал, семинар, арга хэмжээ зохион байгуулсан байдал” - 118, “Оюуны өмчийн менежментийн үйл ажиллагаа” - 13, бусад ажил -106 үйл ажиллагаа явуулж, арга хэмжээ зохион байгуулж ажилласан байна.



Төвүүдийн үйл ажиллагааны тоон үзүүлэлт /бүрэлдэхүүн сургуулиар/



ТӨВҮҮДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭ, ШИМТЭЛ ТӨВЛӨРҮҮЛЭЛТ

2022-2023 оны хичээлийн жилд эрдэм шинжилгээ, судалгааны төвүүдийн үйл ажиллагааны тайлангаар нийт 203,573,698.94 төгрөг төвлөрүүлснээс ШУТИС-ийн судалгааг дэмжих дансанд 102164349.5 төгрөгийн шимтгэлийг төвлөрүүлсэн байна.

Эрдэм шинжилгээ, судалгааны төвүүдийн ШУТИС-д шимтгэл төвлөрүүлсэн байдал, үр дүн

№	БС	Төвийн нэр	Захирал	Шимтгэл төвлөрүүлсэн байдал	Үнэлгээ



1	БАС	Геотехникийн судалгааны төв	С.Нямдорж	812,500	90
2		Зураг төсөл, оношилгооны Реконстракшн төв	Я.Дүйнхэржав	8,710,625	90
3		Барилгын дэвшилтэт материал, бүтээцийн судалгааны төв	Д.Сүнжидмаа	1,282,000	70
4		Барилгын эрчим хүч хэмнэлтийн сургалт судалгааны төв	Б.Мөнхбаяр	2,621,401.85	90
5		Зураг төсөл судалгааны төв	Д.Өлзийсүрэн	2,355,000	68
6		Autodesk-ийн эрх бүхий сургалтын төв	Н.Саранчимэг	665,000	80
7		Усны барилга байгууламжийн судалгаа, хөгжлийн төв	Н.Насанбаяр	2,100,000	80
8	БуХС	Жижиг дунд үйлдвэрлэлийн сургалт, судалгааны төв	Л.Оюунцэцэг	1,000,000	75
9	МХТС	Мэдээлэл Холбооны технологийн сургалтын төв	Б.Энхтөгс	0	
10	ҮТС	Шим тэжээл судлалын төв	С.Баянжаргал	2,028,500	100
11		Арьс ширний сургалт, судалгаа инновацийн LEATHUB төв	Л.Удвал	60,060	100
12		Хувцас судлалын төв	М.Баяр	2,393,195	95
13		SHIMA SEIKI сургалтын төв	Д.Энхтуяа	1,606,566.87	100
14		Хүнсний судалгаа, инновацийн нээлттэй төв	Э.Энхцэцэг	52,469.5	90
15	ХШУС	Материал судлалын төв	Г.Саран	0	70
16		Үл эвдэх сорилын төв	Б.Түмэндэмбэрэл	1,710,740	75
17		Суурь судалгааны төв	Б.Очирбат	375,000	90
18	ГУУС	Газрын тосны сургалт, судалгаа, мэдээллийн төв	А.Баасанжаргал	33,000	24
19		Технологийн эрдэс судлал, инновацийн төв	С.Жаргалан	3,305,545	82
20		Эрдэс боловсруулалт техник технологийн судалгааны төв	Г.Ганбилэг	0	37



21		Геофизикийн сургалт, үйлдвэрлэл, судалгааны төв	Т.Бямбасүрэн	4,798,500	72
22		Геологийн шинжлэх ухааны төв	Б.Мөнхцэнгэл	0	72
23		Тээлгээний сургалт судалгааны төв	Л.Пүрэв	20,313,500	82
24		Эрдэс баялгийн судалгаа, геомэдээллийн сургалтын төв	Б.Алтанзул	7,271,250	85
25		Стратиграфи, палеонтологийн судалгааны төв	Г.Сэрсмаа	567,491.25	76
26		Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалт судалгааны төв	К.Хавалболат	16,021,430	87
27		Антарктид судлалын төв	А.Баасанжаргал	0	15
28		ШУТИС, Нагояа Их Сургуулийн хамтарсан хээрийн судалгааны төв	А.Лодойданзан	1,152,725	69
29	ДаТС	Барилгын материалын судалгааны төв	Д.Оюунбилэг	2,724,783	100
30	МехТС	Металлын сорилт, туршилт, эрдэм шинжилгээний төв	Ц.Мөнхтуяа	7,917,800	90
31		Техник технологийн туршилт судалгааны төв	Г.Чимэд-Очир	0	85
32		Соёлын өвийн хадгалалт, хамгаалалт сургалт судалгааны төв	Ж.Хашбат	0	70
33		Металлурги, дэвшилтэт технологийн судалгааны төв	М.Дэлгэрмаа	0	шинээр нээгдсэн
34		Машин үйлдвэрлэлийн инновацын төв	Г.Оюунбат	0	шинээр нээгдсэн
35	ЭХС	Зуухны туршилт, судалгааны төв	А.Түмэнбаяр	945,267	90
36		Үйлдвэрлэлийн процессын автоматжуулалт, туршилт судалгааны төв	Ч.Нацагдорж	0	80



37	Эрчим хүчний хэмнэлтийн судалгааны төв	Д.Содномдорж	0	90
38	Хөргүүрийн технологийн судалгаа, сургалт, үйлдвэрлэлийн төв	Ч.Мангалжалав	1,900,000	0
39	Дулааны хэрэглээний дэвшилтэт техник, технологийн судалгааны төв	П.Бямбацогт	1,800,000	85
40	Эрчим хүчний эх үүсвэр, хүрээлэн буй орчны судалгааны төв	Х.Энхжаргал	1,320,000	0
41	Эрчим хүчний тоон технологийн төв	Б.Бат-Эрдэнэ	4,320,000	90
НИЙТ /ШУТИС/			102,164,349.5	82.98

Жич. Эрчим хүчний сургуулийн Эрчим хүчний эх үүсвэр, хүрээлэн буй орчны судалгааны төв, Хөргүүрийн технологийн судалгаа, сургалт, үйлдвэрлэлийн төв”-үүд тайлангаа өгөөгүйгээс үнэлгээ ороогүй болно

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГААНЫ ТӨВҮҮДИЙН 2020-2021, 2021-2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АТТЕСТАТЧИЛЛЫН ҮР ДҮН

Инновац, технологи дамжуулалтын төвөөс ШУТИС-ийн эрдэм шинжилгээ, судалгааны нийтлэг журмын 6.3 хэсэгт заасны дагуу их сургуулийн хэмжээнд 46 эрдэм шинжилгээ, судалгааны төвүүдийн 2020-2021, 2021-2022 оны хичээлийн жилийн үйл ажиллагааг 2023 оны 04 сарын 25-26-ны өдрүүдэд Эрдэм шинжилгээ, технологийн дэд зөвлөлөөр хэлэлцүүлэн, нийт үнэлгээний дүнг үндэслэн үйл ажиллагааг нь үргэлжлүүлэх болон татан буулгах тухай саналыг ШУТИС-ийн Захирлын зөвлөлд танилцуулан шийдвэрлүүлээ.

2020-2021, 2021-2022 оны хичээлийн жилд ШУТИС-ийн 10 бүрэлдэхүүн сургуулийн харьяанд нийт 46 эрдэм шинжилгээ, судалгааны төв үйл ажиллагаа явуулсан байгаагаас эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхэлж байгаа 16 төв, зөвхөн сургалт явуулж байгаа 4 төв, сургалт судалгаа хослуулан үйл ажиллагаа явуулж байгаа 26 төв 2 жилийн үйл ажиллагаагаа танилцуулав.

2020-2022 оны төвүүдийн үйл ажиллагаанд бүрэлдэхүүн сургууль, Инновац, технологи дамжуулалтын төв, Эрдэм шинжилгээ, технологийн дэд зөвлөлөөс нийт үйл ажиллагаагаа тайлагнасан 46 эрдэм шинжилгээ, судалгааны төвөөс 39 төвийн үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэх, гэрчилгээг сунгах, 7 судалгааны төвийг татан буулгахаар санал гарсан байна.

Тайланд өгсөн үнэлгээ

№	Харгалзах оноо	Үнэлэгдсэн байдал	Төвийн тоо	Шийдвэр
---	----------------	-------------------	------------	---------



1	70-99	Үйл ажиллагаа нь тодорхой үр дүнд хүрсэн	31	Төвийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх, гэрчилгээг сунгах
2	51-69	Үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай	8	Төвийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх, гэрчилгээг сунгах
3	0-50	Үйл ажиллагаа үр дүнгүй	7	Татан буулгах

ТӨВҮҮДИЙН АТТЕСТАТЧИЛЛЫН ТАЙЛАН, ДҮГНЭЛТ

ШУТИС-ийн захирлын 2023 оны 05-р сарын 23-ний өдрийн А-186 дугаар тушаалын дагуу Эрдэм шинжилгээ, судалгааны төвийн талаар зарим арга хэмжээг авч ажиллав. Үүнд

1. ШУТИС-ийн Эрдэм шинжилгээ, судалгааны төвийн нийтлэг журмын 2.4-т заасны дагуу Үйл ажиллагааны тайлангаа дүгнүүлж, “хангалттай” үнэлгээ авсан 39 төв, шинээр байгуулагдан үйл ажиллагаа эрхэлж байгаа 2 төв, нийт 41 эрдэм шинжилгээ, судалгааны төвийн бүртгэлийн гэрчилгээг 2 жилийн хугацаатайгаар сунгаж шинэчилсэн бүртгэлийн гэрчилгээ олгов.



2. “Үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай” дүгнэлт авсан нэр бүхий 8 эрдэм шинжилгээ, судалгааны төвүүдийн үйл ажиллагааг сайжруулахыг эрдэм шинжилгээ, судалгааны төвүүдийн захирлууд, дэмжлэг үзүүлж ажиллахыг бүрэлдэхүүн сургуулиудын захирлуудад албан бичгээр үүрэг даалгавар өгөв.



3. Их сургуульд өндөр хувь нэмэр оруулан бусад төвүүддээ манлайлан ажилласан нэр бүхий 5 эрдэм шинжилгээ, судалгааны төвүүдийн үйл ажиллагаанд зориулж тус бүрт 1.0 сая төгрөгийн судалгааны дэмжлэгийг олгов.

4. Тайлангийн дүгнэлт хэлэлцүүлгээр хангалтгүй үнэлгээ авсан болон татан буулгах хүсэлт ирүүлсэн нэр бүхийн 7 эрдэм шинжилгээ, судалгааны төвүүдийг 2023 оны 6 сарын 30-ны өдрөөс татан буулгах шийдвэр гаргав.

Хүснэгт 3.6 Татан буулгах Эрдэм шинжилгээ судалгааны төвүүдийн жагсаалт

№	Бүрэлдэхүүн сургууль	Судалгааны төвийн нэр	Төвийн захирал	Үнэлгээ, тайлбар
1	Барилга, архитектурын сургууль	Барилга, замын технологи, эдийн засаг, төсвийн нормчлолын судалгааны төв	С.Ганболд	Хангалтгүй 37.50
2		Усны судалгааны төв	Д.Басандорж	Хангалтгүй 35.68
3		Авто замын сургалт судалгааны төв	С.Амарбуян	Хангалтгүй 11.30
4	Геологи, уул уурхайн сургууль	Уул уурхайн төсөл, судалгааны төв	С.Цэдэндорж	Хангалтгүй 15.50
5		Уурхайн инженерүүдэд мэргэшлийн зэрэг олгох сургалтын төв	Ц.Нанзад	Хангалтгүй 10.00
6	Бизнесийн ахисан түвшний сургууль	Манлайлал энтрепрёнер төв	Э.Ганбат	Хангалтгүй 4.25
7	Хэрэглээний шинжлэх ухааны сургууль	Систем судалгааны төв	Б.Очирбат	Үүсгэн байгуулагчийн хүсэлтээр

ТӨВҮҮДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2020-2021, 2021-2022 оны тайлангийн дүгнэлтээр ШУТИС-ийн Захирлын 2023 оны 05 сарын 23-ны өдрийн А/186 дугаар тушаалын дагуу Эрдэм шинжилгээ, судалгааны төвүүдийн талаар дараах арга хэмжээг авч ажиллаж байна.



1. Төвүүдийн захирлуудыг үргэлжлүүлэн ажиллуулах болон өөрчлөх талаар бүрэлдэхүүн сургуулийн саналын дагуу нийт 39 судалгааны төвийн 4 төвийн захирлыг шинээр томилж төвийн захирлыг батласан тушаалыг батлуулав.

2. Тайлангийн дүгнэлтээр үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай гэж дүгнэгдсэн 8 судалгааны төвийн үйл ажиллагааг холбогдох бүрэлдэхүүн сургуулийн зүгээс эрчимжүүлэх, холбогдох дэмжлэг, зохион байгуулалтын арга хэмжээний талаарх төлөвлөгөөг боловсруулан батлуулж ажиллах

3. ШУТИС-ийн бодлогоор байгуулагдсан, тусгай чиг үүрэг хэрэгжүүлэх “Мэдээлэл холбооны технологийн сургалтын төв”, “Антарктид судлалын төв” сургалт, судалгааны төвүүдийн үйл ажиллагаа, түүнийг дүгнэх шалгуур үзүүлэлтийг онцгойлон авч үзэн дэмжлэг үзүүлэх, Эрдэм шинжилгээ, судалгааны төвийн нийтлэг журамд холбогдох өөрчлөлт оруулах

4. Эрдэм шинжилгээ, судалгааны төвүүдийн захирлуудтай гэрээг шинэчлэн байгуулж, холбогдох дүрэм журмыг мөрдөн ажиллах

5. Эрдэм шинжилгээ, судалгааны төвүүдэд жил бүр үйл ажиллагааны болон санхүүгийн дотоод аудит хийж үр дүнг мэдээлж байх арга хэмжээнүүдийг авч ажиллахаар төлөвлөн ажиллаж байна.

3.19. ИННОВАЦЫН ТҮНШЛЭЛ, ХАМТЫН АЖИЛЛАГАА ГЭРЭЭ, ХЭЛЭЛЦЭЭР

“ШУТИС-2030 Стратеги төлөвлөгөө”-ний Инновац, технологи арилжаалалт тэргүүлэх чиглэлд тусгагдсан инновацын хамтын ажиллагаа, түншлэлийг өргөжүүлэх зорилтын хүрээнд Төр, их сургууль, аж үйлдвэрийн инновацын хамтын ажиллагааг өргөжүүлэх санаачилга гарган ажиллалаа. Инновац, Технологи дамжуулалтын төвөөс 2022-2023 оны хичээлийн жилд туршилт зүгшрүүлэлт, инновацын хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлд БШУЯам, Шинжлэх ухааны паркийн захиргаа, Улаанбаатар хөгжлийн корпораци ХК, Эм Си Эс групп, МАК ХХК, Талын метал нунтаг ХХК, Inno Hub, M-Star хамтын оффис, Жайка Монгол ОУБ, Кэй Эс Мэд ин Монголиа ХХК, Хэнтий аймгийн ЗДТГ, ШУТСан зэрэг байгууллагуудтай идэвхтэй хамтран ажиллаж байна.

Мөн тус хичээлийн жилд дараах байгууллагуудтай гэрээ, санамж бичгүүдийг байгуулж, хамтран ажиллах төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажиллаж байна.

- ШУТИС-Талын металл нунтаг ХХК хоорондын санамж бичиг (2022.11.08)
- ШУТИС-УБ хөгжлийн корпораци хоорондын санамж бичиг (2023.02.06)
- БНСУ-ын Конгжү үндэсний их сургуулийн Чонан кампус дахь Инженерийн сургууль – Талын металл нунтаг ХХК – ШУТИС хоорондын хамтран ажиллах санамж бичиг (2023.03.29)
- Өвөрмонголын АҮИС-ШУТИС хамтарсан ГДТ байгуулах гэрээ / 2023.05.25/
- БШУЯ-с ШУТИС-ИТДТөвд хурдасгуур хөтөлбөр хэрэгжүүлэх, бойжуулах эрх олгох гэрээ (2023.06.10)







Гэрээнд гарын үсэг зурах үеийн фото зургаас



ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ГАДААД ХАРИЛЦАА,
ХАМТЫН АЖИЛЛАГАА




ДӨРӨВ. ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

4.1. ГАДААДЫН ЗОЧИД ТӨЛӨӨЛӨГЧИД

Гадаад хамтын ажиллагаа, нийгмийн түншлэлийг өргөжүүлэх замаар өөрийн сургуулийн сургалтын чанар, материаллаг баазыг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд 2022-2023 оны хичээлийн жилд гадаад, дотоодын байгууллагын 380 гаруй зочид, төлөөлөгчдийг хүлээн авч, хамтын ажиллагааны талаар хурал, семинар, уулзалтуудыг зохион байгуулан ажиллаа.

Гадаадын томоохон зочид төлөөлөгчид

- Чех Улсын Боловсрол, залуучууд, спортын яамны Дэд сайд Ярослав Миллер
- ОХУ-ын шинжлэх ухаан, дээд боловсролын яамны Дэд сайд Могилевский Константин Ильич
- Чех Улсын Шадар сайд бөгөөд Хөдөлмөр, нийгмийн хэргийн Сайд Мариан Юречка
- ХБНГУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ёорн Розенбэрг
- Чех Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ян Выгопил
- БНАСАУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд О Сын Хо





4.2. ГАДААД ТОМИЛОЛТ, МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭЛТ

2022-2023 оны хичээлийн жилд ОХУ, БНХАУ, БНСУ, Япон, Тайвань, Индонези, Камбожи, Вьетнам, Малайз, Сингапур, Тайланд, БНЭУ, ӨАБНУ, Австрали, Австри, ХБНГУ, Франц, Швед, Испани, Итали, Чех, Польш, Турк, Эстони, Азербайжан, Узбекстан, Киргизстан, Казакстан зэрэг 28 улсын их, дээд сургууль, судалгааны байгууллагууд дээр зохион байгуулагдсан ОУ-ын эрдэм шинжилгээний хурал, төслийн сургалт, семинар, мэргэжил дээшлүүлэх болон зэргийн бус сургалт, солилцооны хөтөлбөр, олон улсын үзэсгэлэн, тэмцээнд нийт 289 багш, ажилтан зохион байгуулагч талын болон хамтарсан төсөл, хөтөлбөрийн зардлаар томилогдон оролцлоо.



Гадаад томилолтын тоо сургуулиар



Гадаад томилолт чиглэлээр



4.3. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ, САНАМЖ БИЧИГ

2022-2023 оны хичээлийн жилд гадаад, дотоодын болон олон улсын нийт 59 их дээд сургууль, үйлдвэр аж ахуйн нэгж, байгууллагатай хамтын ажиллагааны санамж бичиг, гэрээг шинээр байгууллаа. Үүнээс дотоодын 28 байгууллагатай нийгмийн түншлэлийн хүрээнд хамтын ажиллагааны гэрээ, санамж бичгүүдийг шинээр байгуулан ажиллаж байна.

Шинээр хамтын ажиллагааны гэрээ, санамж бичиг байгуулсан гадаадын их дээд сургууль, ОУ-ын болон дотоодын байгууллагууд


Хүснэгт 4.1



д/д	Сургууль, байгууллагын нэр	Улс	Гэрээний ангилал
1	The University of Queensland	Австрали	санамж бичиг
2	The University of New South Wales	Австрали	санамж бичиг
3	Macquarie University	Австрали	санамж бичиг
4	University of Canberra	Австрали	санамж бичиг
5	Siberian State University of Telecommunications and Information Science	ОХУ	гэрээ
6	Российский Государственный Геологоразведочный Университет им. Серго Орд.	ОХУ	гэрээ
7	Иркутский областной художественный колледж им. И.Л. Копылова	ОХУ	санамж бичиг
8	Иркутское региональное отделение Общероссийской общественной организации «Союз Дизайнеров России»	ОХУ	санамж бичиг
9	Национальный исследовательский университет «МЭИ»	ОХУ	санамж бичиг
10	Toraighyrov University	Казакстан	санамж бичиг
11	Korea National Open University	БНСУ	гэрээ
12	Joongbu University	БНСУ	санамж бичиг
13	Kongju National University	БНСУ	гэрээ
14	Cheongju University	БНСУ	санамж бичиг
15	Samwon Millennia Co.	БНСУ	санамж бичиг
16	Kunsan National University	БНСУ	гэрээ
17	Jinie Edu Tech Co., Ltd	БНСУ	санамж бичиг
18	Korea Institute of Civil Engineering and Building Technology	БНСУ	санамж бичиг
19	XI'AN University of architecture and technology	БНХАУ	санамж бичиг
20	Henan Polytechnic University	БНХАУ	санамж бичиг
21	China Zhengzhou Electric Power College	БНХАУ	санамж бичиг
22	Baotou Light Industry Vocational Technical College	БНХАУ	санамж бичиг
23	Inner Mongolia University of Technology	БНХАУ	гэрээ
24	Liaoning University	БНХАУ	гэрээ
25	Nanjing University	БНХАУ	гэрээ
26	Kyoto Institute of Tehcnology	Япон	гэрээ
27	Sanko group	Япон	гэрээ
28	Japan Universities Consortium for Higher Education Development Prpject Mongolia Twinning Program	Япон	гэрээ
29	UNESCO chair office	НҮБ	гэрээ
30	Bixter Training DK APS	Дани	санамж бичиг
31	Trakia University- Stara Zagora	Болгар	санамж бичиг
32	Зүүнбаян төмөр зам ХХК	Монгол	санамж бичиг
33	Талын металл нунтаг ХХК	Монгол	санамж бичиг



34	Бээү технологи ХХК	Монгол	гэрээ
35	Нэг бүс нэг зам ОУ-ын Хөгжлийн судалгааны академи	Монгол	санамж бичиг
36	Нийслэлийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	Монгол	санамж бичиг
37	Аддиктологи, зан үйл сэтгэл заслын төв	Монгол	санамж бичиг
38	“Хилийн чанад дахь монголчуудын зөвлөл” ТББ	Монгол	санамж бичиг
39	“Улаанбаатар хотын хөгжлийн корпораци” ХК	Монгол	санамж бичиг
40	MCS Групп ХХК	Монгол	санамж бичиг
41	Novotel Hotels & Resorts	Монгол	гэрээ
42	“Наран Ижий Заяа” ТББ	Монгол	санамж бичиг
43	“Монголын маркшейдерийн холбоо” ТББ	Монгол	санамж бичиг
44	Сумитомо Корпораци	Монгол	шинэчилсэн гэрээ
45	“Жи энд Ди Девелопмент” ХХК-ийн “Мика Монгол” сургалтын төв	Монгол	гэрээ
46	Улаанбаатар хотын хөгжлийн корпораци ХК	Монгол	санамж бичиг
47	Оюу толгой ХХК-тай хийсэн хандивын гэрээ	Монгол	хандивын гэрээ
48	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	Монгол	санамж бичиг
49	Монфүжи ХХК	Монгол	гэрээ
50	“Эйч Ар Клуб” ТББ	Монгол	санамж бичиг
51	Хэнтий аймгийн ЗДТГ	Монгол	санамж бичиг
52	Шинжлэх ухааны академи	Монгол	санамж бичиг
53	МАК ХХК	Монгол	санамж бичиг
54	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ	Монгол	гэрээ
55	3 улсын зам тээврийн гэрээ	Монгол	санамж бичиг
56	Манлайлагч ХН менежерүүдин клуб HR CLUB	Монгол	санамж бичиг
57	Бадрах Энержи ХХК	Монгол	санамж бичиг
58	MSDI Consulting ХХК	Монгол	санамж бичиг
59	Өв үндэс ХХК	Монгол	санамж бичиг





Мөн дээр дурдсанаас гадна Монгол дахь гадаадын ОУ-ын байгууллагууд, төлөөлөгчийн газрууд, гадаадын ЭСЯ-дуудтай идэвхтэй хамтран ажиллаж байна. Тухайлбал: Дээд боловсролыг хөгжүүлэх “1000 инженер” төслийн хүрээнд Японы ОУ-ын ЖАЙКА, Мэдээллийн технологийн сургалт, судалгааны ажлыг хөгжүүлэхэд БНСУ-ын ОУ-ын КОЙКА, дээд боловсролын чиглэлээр ОУ-ын ЮНЕСКО байгууллагатай хамтран ажиллаж сургалт судалгааны чиглэлээр тодорхой төслүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

4.4. ГАДААДЫН МЭРГЭЖИЛТЭН, БАГШ ЗОЧИН ПРОФЕССОР

2022-2023 оны хичээлийн жилд гадаадын их дээд сургууль, сайн дурын болон олон улсын байгууллагаас нийт 13 багш, мэргэжилтэн ШУТИС-д ирж ажиллаад байна.


ШУТИС-д ажиллаж байгаа гадаадын мэргэжилтэн, багш нар

Хүснэгт 4.2


Харьяалагдах гадаадын байгууллага, төсөл	Ажиллаж буй сургууль	Тоо
БНСУ-ын WITHN байгууллагын мэргэжилтэн	ҮТС	1
ХА-ны шугамаар (АНУ)	ДаТС	2
АНУ-ын Төрийн Департаментээс англи хэлний багш	ГХС	1
БНХАУ-ын Күнзийн институт хятад хэлний багш	ГХС	1
БНСУ-ын Конжүгийн их сургуультай хамтарсан “Соёлын биет өвийг хадгалах, хамгаалах, мэргэжилтний ур чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийн (1 зочин профессор, 3 багш, 1 судлаач)	MeTC	3
	БУХС	2
БНСУ-ын Агаарын чанарын байгууллагын мэргэжилтэн багш	БАС	1
ОХУ-ын Якутын М.К. Аммосовын нэрэмжит Зүүн хойд Холбооны их сургуулийн мэргэжилтэн багш	ЭХС	1
Японы JCA байгууллагын сайн дурын мэргэжилтэн багш	Коосэн ТС	1
Нийт		13

4.5. ОЮУТАН СОЛИЛЦОО, ГАДААД ОЮУТАН

2022-2023 оны хичээлийн жилд ОХУ, БНХАУ, БНСУ, АНУ, Казакстан, Турк зэрэг улсаас ШУТИС-д нийт 147 гадаад оюутан суралцаж байна. Үүнээс бакалаврын хөтөлбөрт 2, магистрантурын хөтөлбөрт 53, докторантурын хөтөлбөрт 92 оюутан тус тус суралцаж байна.



Зураг 4.2. Гадаад оюутны тоо улс орноор




	БАС	БУХС	БАТС	ГУУС	МехТС	МХТС	ҮТС	ХШҮС	ЭХС	ГХС	НБТ
■ Гадаад оюутнууд бүрэлдэхүүн сургуулиар	11	4	33	14	1	23	24	5	4	4	24

Зураг 4.3. Гадаад оюутны тоо (бүрэлдэхүүн сургууль, төв)

2022-2023 оны хичээлийн жилд Япон, БНСУ, Тайланд, Камбожи зэрэг улсуудад зохион байгуулагдсан ОУ-ын уралдаан тэмцэн, дадлага, оюутан солилцооны хөтөлбөрт ШУТИС-иас нийт 49 оюутан оролцлоо.

4.6. ГАДААДЫН ТЭТГЭЛГҮҮД

Японы Санко-Сеики групп, Японы Сүмитомо корпораци, Японы Мицүбиши корпораци, Тоёота-ШУТИС сан зэрэг гадаадын байгууллага, сангийн 74,7 сая төгрөгийн тэтгэлгийг ШУТИС-ийн 56 оюутанд олгоод байна.



4.7. ГАДААДЫН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

Гадаадын байгууллагуудтай хийсэн хамтын ажиллагааны хүрээнд ШУТИС дээр дараах томоохон төслүүд хэрэгжээд байна.

Үүнд:

- ШУТИС-ийн “Цахилгаан хөдөлгүүрийн автомат удирдлагын лаборатори”-ыг шинэчлэх Чех улсын ЗГ-аас санхүүжүүлсэн төсөл **125 сая төгрөг**



- Японы Санко Сейко группийн хөрөнгө оруулалтай инновац, гарааны компани үйл ажиллагааг дэмжих “MUST-SANKOU HUB CENTER” хамтын оффис төсөл **50 сая төгрөг**





- “Оюу толгой ХХК - Рио Тинто” компани хөрөнгө оруулалтай Геотехникийн туршилт, судалгааны лабораторийн төсөл **366 мянган ам.доллар**



- Нийслэлийн гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас нийгмийн халамж, хүүхэд хамгааллын шинэ арга зүйг нэвтрүүлэх, нийгмийн ажилтныг мэргэшүүлэх, нийгмийн ажилтан бэлтгэх, чадавхжуулах төсөл **22 сая төгрөг**



ТАВДУГААР БҮЛЭГ

ОЮУТНЫ ХӨГЖИЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

ТАВ. ОЮУТНЫ ХӨГЖИЛ, СОЁЛ, ҮЙЛЧИЛГЭЭ

5.1. Сургалт, судалгаа

Бид суралцагчдад зориулсан сургалт, судалгаа, хувь хүний хөгжлийн ажлуудыг элсэгч, суралцагч, төгсөгч гэсэн гурван хэсгээр тасралтгүй системтэйгээр зохион байгуулж байна.

Элсэгчдэд зориулсан “Оюутны хөгжил” хөтөлбөрийг ажлын төлөвлөгөөний дагуу хүргэсэн бол суралцагч нийт оюутнуудад клубийн системээр дамжуулан сургалт судалгааны ажлуудыг амжилттай зохион байгуулж байна. Мөн төгсөгч оюутнуудад зөөлөн ур чадвар- ажил эрхлэлтэд чиглүүлэх цуврал модуль сургалтыг зохион байгууллаа. Эдгээр сургалт үйл ажиллагааг цахим болон танхимаар хүргэх нь өмнөх жилүүдийн үйл ажиллагааны үр дүнд харагдсан гэж үзэж байна.

Элсэгч шинэ оюутнууддаа “ сургалтуудыг хүргэсэн. **Үүнд:**

- Танд тусалъя- Чиглүүлэгч оюутан
- “Бүрэлдэхүүн сургуулиудын шинэ оюутны нэгдсэн уулзалт” арга хэмжээ
- “Амжилттай суралцах” тухай лекц танхим
- “Хувь хүний ёс зүй, төлөвшил” лекц цахимаар
- “Эрүүл зөв хооллолт” цахим, танхимаар хүргэсэн.

“Танд тусалъя- чиглүүлэгч оюутан арга хэмжээнд

Хичээлийн жилийн 0 дугаар 7 хоногт 5 клубийн 35 оюутан ажилласан. Хятад хэлний клуб, Энергетик клуб, Багшийн туслах оюутан клуб, ЗУЗ клуб, Архитектур клубийн оюутнууд ажилласан. Ажиллахын өмнө оюутнуудад ажлын заавар, зөвлөмж өгч, нэгдсэн жигд футболкоор ханган ажиллуулдаг.



Бүрэлдэхүүн сургуулиуд шинэ оюутны хөгжил хөтөлбөрт тусгагдсан “Бүрэлдэхүүн сургуулиудын шинэ оюутны нэгдсэн уулзалт” арга хэмжээг сургуулиуд тус бүртгээ шинэ оюутнууддаа хүргэх арга хэмжээг зохион байгуулдаг. Тус арга хэмжээнд Сургууль тус бүрийн танилцуулга, ОХСҮА-наас оюутны үйлчилгээний талаар, ШУТТНСан



танилцуулга, ШУТИС-ийн музей, зарим лабораториудтай танилцуулах ажлууд хийгддэг. Тус арга хэмжээнд нийт 2044 оюутан хамрагдсан.

Бүрэлдэхүүн сургууль тус бүрийн шинэ оюутны тоо

Д/д	Сургууль	Хамрагдсан оюутны тоо
1	БАС	150
2	ГУУС	136
3	ГХС	25
4	БуХС	105
5	МехТС	400
6	МХТС	672
7	ҮТС	211
8	ХШУС	72
9	ЭХС	150
10	Өмнөговь аймаг дахь ТДС	65
11	Өвлийн анхны элсэгч оюутнуудад	103
	Нийт	2044

“Бүрэлдэхүүн сургуулиудын шинэ оюутны нэгдсэн уулзалт”



Амжилттай суралцах нь лекц

Амжилттай суралцах нь лекцийг сургууль бүр өөрсдийн шилдэг багш нараас урьж сургалтуудыг зохион байгуулж шинэ оюутнуудад оюутны амьдрал, амжилттай суралцахад хэрхэн юуг анхаарах, өөрийгөө хэрхэн хөгжүүлэх зэрэг хэрэгтэй чухал мэдээллүүдийг хүргэв.



**Ахлах багш, Доктор (PhD)
Б.Энхжаргал**

БАС- 200 оюутан,
ГУУС -121 оюутан,
ҮТС-72 оюутан
ХШУС-72 оюутан
МехТС-400 оюутан

“Харилцаа ёс зүй төлөвшил сургалт” лекц

Тус сургалтыг сургуулийн вебд байршуулан зөвлөх багш нараар дамжуулан хүргэсэн. Уг бичлэгийг 4300 хүн үзсэн байдаг. Түүний 1200 гаран нь 2022 оны үзэлт байна.



“Эрүүл зөв хоололт сургалт”

ШУТИС-ийн оюутны 4 байранд байранд амьдарч буй нэгдүгээр курсийн оюутнуудад “Зөв зохистой хооллолт” клубийн 1-4 р курсийн 25 оюутан Өглөөний цай, хоол хийх сургалтыг 7 төрлийн хоолны технологийг зааж зохион байгуулсан. Сургалтад нийт 60 гаруй оюутан хамрагдсан. Сургалт болон хоолны бичлэгийг тусгайлан НБТ-ийн мэргэжлийн хүмүүсээр хоолны лабораторид бичүүлж ШУТИС-ийн веб сайт Оюутан линк байршуулсан.

Өглөөний цайны сургалт





ШУТИС-ийн нэгдүгээр курсийн оюутны гол туслагч зөвлөх багш байдаг тул багш нартаа зориулсан сургалт, семинар зохион байгуулав.

Сургалт, семинараар дараах мэдээлэл, сургалтыг хүргэсэн. Үүнд:

- “Сургалтын үйл ажиллагаа, зөвлөх багшид тавигдах шаардлагатай асуудлууд” сэдвээр СБЗГ-ын дарга, доктор (Ph.D), дэд профессор Д.Гэрэлт-Од
- “Сургалтын систем, оюутанд сургалтын үйл ажиллагааг тасралтгүй чанартай хүргэхэд багшийн үүрэг” сэдвээр БХБА-ны дарга Д.Батдорж
- “Их сургуулийн оюутантай хэрхэн ажиллах оюутанд үзүүлж буй үйлчилгээ, түүнд багшийн оролцоо чухал болох нь” сэдвээр ШУТИС-ийн ОСҮА-ны ахлах мэргэжилтэн, доктор (Ph.D), дэд профессор Д.Цогзолмаа
- “Ёс зүй ба сургуулийн орчин” сэдвээр БуХС-ийн ХУС-ын эрхлэгч, доктор (Ph.D), дэд профессор Ц.Батцэрэн
- “ШУТИС дахь ёс зүйн асуудлууд” сэдвээр БуХС-ийн ХУС-ын ахлах багш Э.Энхцолмон
- “Багш хүний имиж бүрдүүлэлт, хувцаслалт” сэдвээр ҮТС-ийн Хувцас судлалын профессорын багийн дэд профессор, доктор (Ph.D), дэд профессор Д.Буйан-Дэлгэр нар уншлаа.



Сургалтын төгсгөлд багш нар 3 асуудлын хүрээнд 6 баг болж ажиллав. Багш нараас гарсан санал хүсэлтийг харилцан ярилцаж, шийдвэрлэх асуудлуудын талаар холбогдох удирдлагад хүргэхээр тогтов.




Сургалтад нийт 60 гаран багш хамрагдсан. Сургалтад бүтэн суусан багш нартаа багламж олгов.

Эрүүл мэнд, нөхөн үржихүйн сургалт

ШУТИС-ийн I, II курсийн оюутнуудад түүн дотор оюутны байранд эцэг эхийн хяналтаас хол бие даан амьдарч буй оюутнуудад хүргэх зорилгоор "Нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол" олгох сургалтыг зохион байгуулав. Сургалтыг ШУТИС-ийн оюутны V байрны оюутнуудад хавар намрын улиралд зохион байгуулж, бичлэгийг оюутны байрны группүүдээр хүргэн ажиллав. Сургалтыг нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол судлаач багш Х.Баярсайхан заалаа. Байрны оюутнууд сонирхсон асуултаа асууж цаашид зөвлөгөө авч байхаар холбоо тогтоосон маш сайн үр дүнтэй сургалт боллоо.



Сэтгэцийн эрүүл мэнддээ анхаарал хандуулах нь сургалт



Сэтгэцийн эрүүл мэнддээ анхаарал хандуулах нь сургалтыг танхим болон цахим хэлбэрээр зохион байгуулав. Сургалтад нь 200 гаран оюутан хамрагдсан. Сургалтыг Билиг сэтгэл судлалын төвийг үүсгэн байгуулагч Э.Амина уншиж, оюутнуудтай чөлөөт ярилцлага хийв. Сургалтын бичлэг хийж холбогдох группүүдээр хүргэх ажлыг сэтгэл зүйн клуб хариуцан ажиллав.

Багийн ажиллагааны сургалт



ШУТИС-ийн оюутны холбооны тэргүүн, Оюутны зөвлөлийн дарга, клубийн ахлагч, гишүүдэд багийн ажиллагааг хөгжүүлэх хамтран ажиллахад чиглэсэн сургалтыг MSDI ProHR консалтинг компани зөвлөх Б.Анхцэцэг хичээлийн VIII байр хурлын танхимд оров. Сургалтад нийт 90 орчим клубийн болон оюутны холбооны ахлагч, гишүүд оролцлоо.



Төлөвлөгөө, тайлан бичих төсөв боловсруулахад чадваржуулах сургалт

Тус сургалтыг ШУТИС-ийн клуб, оюутны холбоо, оюутны зөвлөлийн удирдлага, идэвхтэн гишүүдэд зориулан зохион байгууллаа. Сургалтыг ГХС-ийн Ази судлалын салбарын ахлах багш Б.Сонинцэцэг бичиг баримт боловсруулах стандарт,



алдаг хаана их гаргаж байна. Түүнийгээ хэрхэн засах зэрэгт зөвлөгөө мэдээлэл өгч ажиллав. Сургалтад клубүүдийн 73 оюутан, Оюутны холбооноос 2 оюутан нийт 75 оюутан хамрагдлаа. Б.Сонинцэцэг багш намрын улирлын клубүүдийн тайланд дүн шинжилгээ, засвар хийж, зөвлөгөө өгч ажиллав.

Харилцаа ба хандлага, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт



Тус ажлын хүрээнд ажлын төлөвлөгөө боловсруулсан ба ШУТИС-ийн клубийн нэгдсэн зөвлөлөөс хэв журам сахиулах Соёмбо клубтэй хамтран зохион байгуулдаг “Хотын соёл” аяны хүрээнд хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг намрын улиралд Монголын түүхийн хичээлээр дамжуулан “Хотын соёл” аяны арга хэмжээг 2022 оны 10 дугаар сарын 3-28-ны хооронд зохион байгуулсан. Нийт 2100 гаран оюутанд хүргэсэн.

Хаврын улиралд ШУТИС-ийн нэгдүгээр курсийн оюутнуудад хэв журам сахиулах Соёмбо клубийн пэйж хуудсаар дамжуулан нийт 920 гаруй оюутанд хүргэсэн. БАС-ийн оюутнуудад “Харилцаа хандлага, түүнд тулгамдаж буй асуудал” сэдвээр АШУҮИС-ийн харилцааны тэнхимийн профессор, доктор С.Наранчимэг, “Хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх” нь сургалтыг ДХИС-ийн ахлах мэргэжилтэн доктор, дэд профессор Б.Алтанзул нар уншив. Сургалтанд нийт 280 оюутанд танхимаар хамрагдсан. Цахим бичлэгийг сургуулийн удирдлагад хүргүүлэн бусад оюутанд хүргэхээр ажиллав.



"Харилцаа хамтын ажиллагаа, хандлага" сэдвийн хүрээнд сургалт

Оюутны байранд амьдардаг оюутнууд болон тэнд ажилладаг байрны эрхлэгч, ажилчдад 2023 оны 05 сарын 06, 07-нд, 06 сарын 07-нд "Харилцаа хамтын ажиллагаа, хандлага" сэдвийн хүрээнд сургалт явууллаа. Сургалтыг БУХС-ийн НА хөтөлбөрийн дэд профессор, доктор Б.Болормаа оюутнуудтай ярилцаж, судалгаа авч ажиллав.

Байрны эрхлэгч, ажилчдад Б.Болормаа болон ГХТА-ны дарга доктор Т.Ууганбаяр их сургуулийн хамтын ажиллагаа, түншлэлийн талаар мэдээлэл өгч ажиллав. Сургалтад нийт 118 оюутан, 26 ажилтан хамрагдлаа.



Цаашид бид оюутны байрны оюутнуудад чиглэсэн үйл ажиллагааг нийгмийн салбарын багш нартайгаа хамтран ажиллаж байхаар болсон ба Б.Болормаа багш 2023-2024 оны хичээлийн жилд оюутны III байрны оюутнуудтай долоо хоногт 1 удаа уулзаж ажиллаж байхаар тохирсон болно.

“Архи, тамхи, мансууруулах бодисын хор хөнөөлийг ойлгуулах нь” сэдэвт сургалтыг оюутны I байрны оюутнуудад 2022 оны 10 дугаар сарын 10 ЭМЯ-тай хамтран судлаач доктор Ч.Лхагвасүрэн багшаар уншуулсан нийт 110 оюутан хамрагдсан.


“Авлига”-ийн тухай сургалт

АТГ-аас сургалт явуулж Соёмбо клуб нь 5 гишүүний бүрэлдэхүүнтэй баг гарган сургалтад хамрагдсан. Тус багийн гишүүдээр хавар, намрын улиралд нийт 400 гаруй оюутан залууст авлигын анхан шатны ойлголт, үүсэх шалтгаан, хор хөнөөл, түүнээс урьдчилан сэргийлэх тухай мэдээлэл түгээсэн.



Эрдэм шинжилгээний хуралд бэлтгэх нь сургалт

Оюутны эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оюутнуудыг бэлтгэл сургалтуудыг оюутны үйлчилгээний хуанлид тусгасан цаг хугацаанд ШУТИС-ийн сайт болон оюутны группүүдэд байршуулан мэдээллийг 4 удаагийн цуврал лекцийг цахимаар хүргэсэн.



ШУТИС-ийн төгсөх курсийн оюутнууддаа зориулсан сургалт

ШУТИС-ийг төгсөж буй оюутнуудад “Ажил эрхлэлтэд чиглүүлэх” модуль сургалтын БАТЛАМЖ гардуулах арга хэмжээ 2023 оны 01 дүгээр сарын 19-нд боллоо. Батламж гардуулах арга хэмжээнд хамтран ажиллагч MSDI Pro HR консалтинг компани дэд захирал А.Амар, зөвлөх Б.Анхцэцэг, БУХС-ийн Технологийн менежментийн салбарын ахлах багш, “Алтан гадас” клубийн тэргүүн Ц.Энхбаатар, БАС-ийн СЧА-ны



дарга М.Сугар, ОСҮА-ны ахлах мэргэжилтэн Д.Цогзолмаа нар оролцлоо.

Батламжийг ШУТИС-ийн 2022-2023 оны хичээлийн жилийн намрын улиралд төгсөгчдөөс “Ажил эрхлэлтэд чиглүүлэх” 10 модуль сургалтад хамрагдсан 138 оюутнаас сургалтыг бүрэн судалж, шаардлага хангасан 39 оюутны төлөөлөлд гардууллаа.

2022-2023 оны хаврын улиралд (2023 оны 03 дугаар сарын 10-5 дугаар сарын 10 хүртэл) 20 цагийн 10 удаагийн сургалт, үйл ажиллагааг амжилттай зохион байгууллаа. Сургалтанд хамрагдсан 146 оюутнаас шаардлага хангасан 45 төгсөх оюутанд сургалтын БАТЛАМЖ гардууллаа.



Тус арга хэмжээнд ШУТИС-ийн СБХА-ны дарга, доктор М.Эрдэнэтуяа, ОХСҮА-ны ахлах мэргэжилтэн доктор, дэд профессор Д., БУХС-ийн менежментийн салбарын профессор, “Алтангадас” клубийн тэргүүн Ц.Энхбаатар, MSDI-Pro HR аутсорсинг консалтинг компани дэд захирал А.Амар бусад байгууллагын төлөөлөл оролцож оюутнууддаа баяр хүргэн үг хэлж батламжийг гардууллаа.



Оролцсон байгууллагууд төгсөх оюутнуудад зориулсан хөтөлбөрөө танилцуулж сонирхсон оюутнуудаа бүртгэж амжилттай ажиллав.

5.2. Эрдэм, шинжилгээ судалгааны ажил

ШУТИС-ийн оюутнуудын дунд зохион байгуулах “Эрдмийн XXII чуулган” нь шилдэг өгүүлэл шалгаруулах, шилдэг бүтээл шалгаруулах 2 төрлөөр явагдсан.

I. “Эрдмийн XXII чуулган” шилдэг өгүүлэл шалгаруулах нээлтийн арга хэмжээнд Эрдэм шинжилгээ, технологийн газрын захирал доктор (Ph.D), профессор Д.Цолмонбаатар, Санхүү, төлөвлөлтийн газрын захирал доктор (Ph.D), дэд профессор Л.Баяр-Эрдэнэ болон комиссын гишүүд оролцлоо.



Хурлын үйл ажиллагаанд зочин илтгэгчээр ҮТС-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор (Ph.D), дэд профессор М.Пүрэвжав “Судалгаа бол амьдрал” сэдвээр



сонирхолтой илтгэл тавьж, судлаач оюутнуудад илтгэл тавьж, өөрийн судалгааны ажил, үр дүнгээ танилцуулж оролцоо.

“Эрдмийн XXII чуулган” шилдэг өгүүлэл шалгаруулах хурлыг 2 үе шаттай, 4 салбар хуралдаанаар зохион байгуулсан.



“Эрдмийн XXII чуулган” шилдэг өгүүлэл шалгаруулах комиссын салбар зөвлөлийн гишүүдийн шүүснээр дараах илтгэлүүд шагналт байрыг эзэллээ.

Техник, технологийн салбар хуралдааны илтгэлүүдээс



ТЭРГҮҮН БАЙРАНД

БАС-ийн Гүүрийн барилга, IV курсийн оюутан Н.Солонго “УЛААНБААТАР ХОТЫН АРСЛАНТАЙ ГҮҮРИЙГ ШИНЭЧЛЭН БАРИХ ТӨСЛИЙН СУДАЛГАА” сэдвээр Удирдсан багш: С.Хаснавч, /Инженерийн байгууламжийн салбарын дэд профессор, доктор (PhD), дэд профессор/

ДЭД БАЙРАНД

ГУУС-ийн Геотехникийн III курсийн оюутан Б.Содном, Г.Баттулга, Б.Амаржаргал нар “БАРТОНЫ Q ҮЗҮҮЛЭЛТИЙГ МАШИН СУРГАЛТААР ҮНЭЛЭХ” сэдвээр

Удирдсан багш: Б.Ганзориг /Уурхайн технологийн салбарын эрхлэгч, доктор (Ph.D)/

ГУТГААР БАЙРАНД

ЭЦДС-ийн Мэдээллийн технологи – II, III курсийн оюутан А.Жаргалмаа, Г.Солонго нар “IOT ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН ЗАЙНААС УДИРДДАГ ХАЛААЛТЫН СИСТЕМИЙН ХӨГЖҮҮЛЭЛТ” сэдвээр Удирдсан багш: А.Түвшинжаргал / ЭЦДС-ийн ЭХМТ-ийн тэнхимийн дэд профессор/

Байгалийн ухаан, экологийн салбар хуралдааны илтгэлүүдээс:

ТЭРГҮҮН БАЙРАНД

ХШУС-ийн Химийн Инженерчлэл, IV курсийн оюутан Б.Отгонзул “ҮНЭТ МЕТАЛЛ РТ-ЫГ ШИНГЭЭХ ЧАДВАРТАЙ ШИНЭ МАТЕРИАЛЫН СИНТЕЗИЙН СУДАЛГАА”

Удирдсан багш: Б.Өлзийдэлгэр /Химийн Инженерчлэлийн салбарын ахлах багш, Доктор (Ph.D)/

ДЭД БАЙРАНД

БАС-ийн Халаалт агаар сэлгэлт, IV курсийн оюутан М.Амьдарь, Б.Өсөхбаяр, Х.Гомбодорж “БАРИЛГЫН ДУУ ТУСГААРЛАЛТ, ДУУ ЧИМЭЭНИЙ БОХИРДЛЫН СУДАЛГАА” Удирдсан багш: Ц.Уранцэцэг /БАС-ийн Хүрээлэн буй орчны инженерийн салбарын дэд профессор, доктор (PhD)/

ГУТГААР БАЙРАНД

ҮТС-ийн Хунсний чанар аюулгүй байдал IV курсийн оюутан Э.Чингүүн “ХАРМАГ ЖИМСНИЙ ДАРС ИСГЭХ МИКРОБИОЛОГИЙН СУДАЛГААНЫ ҮР ДҮН” Удирдсан багш: С.Дэлгэрмаа /доктор (Ph.D), профессор), Х.Мөнхзаяа (доктор (Ph.D), дэд профессор/

Нийгэм, хүмүүнлэг, дизайны салбар хуралдааны илтгэлүүдээс

ТЭРГҮҮН БАЙРАНД

БАС-ийн Архитектур, II курсийн оюутан Ш.Төгсжаргал, Ө.Дагийсүрэн, Ч.Бумдэлгэрэх, Б.Үржинханд нар “УЛААНБААТАР ХОТЫН МУБИС-ЫН АВТОБУСНЫ БУУДЛЫГ ХЭРЭГЛЭГЧИЙН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГАД ҮНДЭСЛЭН САЙЖРУУЛАН ТӨЛӨВЛӨХ СУДАЛГАА” сэдвээр Удирдсан багш: Э.Болорцэцэг /Архитектурын салбарын багш/

ДЭД БАЙРАНД

ҮТС-ийн Үйлдвэрлэлийн дизайн V курсийн оюутан Б.Цацрал “МОНГОЛ ХЭВ ШИНЖ БҮХИЙ МОДОН ТОГЛООМЫН ШИЙДЭЛ” сэдвээр Удирдсан багш: Б. Дэлгэрцэцэг / (доктор (Ph.D), дэд профессор)/

ГУТГААР БАЙРАНД

МХТС-ийн Мэдээллийн технологи IV курсийн оюутан “Д.Дүүрэнжаргал, Г.Есүй-Үжин Э.Мөнхжин Н.Дугаржав нар “ХИЙМЭЛ ОЮУН УХААНЫ ТУСЛАМЖТАЙ ДОХИОНЫ ХЭЛ ХӨРВҮҮЛЭХ СИСТЕМИЙН СУДАЛГАА” сэдвээр Удирдсан багш: Г.Мөнхбат /Мэдээллийн технологийн салбарын багш/

Эдийн засаг, менежментийн салбар хуралдааны илтгэлүүдээс

ТЭРГҮҮН БАЙРАНД

МХТС-ийн Хиймэл оюун ухаан III курсийн оюутан Н.Сүхтөмөр “БИЗНЕСТ ЗОРИУЛСАН ЧАТБОТООР УДИРДУУЛСАН ERP СИСТЕМ” сэдвээр Удирдсан багш:



Г.Ганчимэг /Компьютерын ухааны салбарын дэд профессор, Доктор (Ph.D), дэд профессор /

ДЭД БАЙРАНД

М.Мөнхзаяа “НЯГТЛАН БОДОГЧДЫН EMPLOYEE WELL-BEING БУЮУ САЙН САЙХАН БАЙДЛЫН СУДАЛГАА” сэдвээр Удирдсан багш: Т.Төгөлдөр /Санхүү эдийн засгийн их сургууль/

ГУТГААР БАЙРАНД

А.Номинтуул, Б.Номин-Эрдэнэ “16-20 НАСНЫ ЗАЛУУСЫН ЦАГИЙН АЖИЛ ХИЙХ БОЛОМЖ” сэдвээр Удирдсан багш: Э.Цолмон /Санхүү эдийн засгийн их сургууль/ нар тус тус шалгарч өргөмжлөлөө гардан авлаа.





“Эрдмийн XXII чуулган” шилдэг өгүүлэл шалгаруулах уралдааны шагналын сан Тэргүүн байр 800 000 төгрөг, Дэд байр 500 000 төгрөг, Гутгаар байр 300 000 төгрөгөөр тус тус шагнаан урамшууллаа.

Энэ жилийн хурлын онцлог үйл ажиллагаа нь ШУТИС хүний нөөцийн мэргэжилтэн бэлтгэсний 25 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдсан “ЭРДМИЙН XXII ЧУУЛГАН”, “ЭРДМИЙН ШУВУУ” цомын төлөөх эдийн засаг менежментийн салбар хуралдаанд оролцсон шилдэг оюутнуудад ивээн тэтгэгч байгууллагаар оролцсон “Залуу судлаачдыг дэмжих сан”, “MLC Business School”, “АПУ ХК”, “INVESCORE” ББСБ, “Зөв тэмүүлэл-Хөгжлийн түлхүүр” ТББ байгууллагууд байр эзлүүлэн шагнаж урамшууллаа.

№	Оюутан	Сэдэв	Сургууль	Удирдагч багш
ТЭРГҮҮН БАЙР				
1	Н.Сүхтөмөр	Бизнес зориулсан чатботоор удирдуулсан ERP систем	ШУТИС. МХТС	док (Ph.D)., дэд проф. Г.Ганчимэг
ДЭД БАЙР				
2	М. Мөнхзаяа	Нягтлан бодогчдын Employee Well-Being буюу сайн сайхан байдлын судалгаа	Санхүү эдийн засгийн их сургууль	Магистр Т. Төгөлдөр
3	Н.Хашчулуун Б.Амарзаяа Ө.Сансармаа	Автомашинны эргэдэг зогсоолын системийг нэвтрүүлэх боломжийн судалгаа	ШУТИС. МТС	док (Ph.D)., дэд проф. С.Уянга
ГУТГААР БАЙР				
4	Ө.Намуун, Б.Есүй	Дээд боловсролын салбарт хиймэл оюун ухааны хэрэглээ	ШУТИС. БүХС	Магистр Г.Цолмон
5	А.Номинтуул Б.Номин- Эрдэнэ	16-20 насны залуусын цагийн ажил хийх боломж	Санхүү эдийн засгийн их сургууль	Магистр Э.Цовоо
ТУСГАЙ БАЙР				
6	Д.Цэцэг	Манлайллын онол, хандлагын үечилсэн судалгаа	ШУТИС. БүХС	Магистр Л.Цэрэнчимэд
7	Б.Мөнх- Ундрал	Ажлын байрны стрессийн судалгаа	ШУТИС. БүХС	Магистр Д.Ариунжаргал
8	Т.Ууганцэцэг	Хүний нөөцийн бүрдүүлэлт, сонгон шалгаруулалтын процессыг зураглах нь	ШУТИС. БүХС	Магистр Л.Цэрэнчимэд
9	Б.Сувдбилэг	Сошиал медиа маркетинг	ИЗОИС, СЭЭС	Магистр Д.Элбэгзаяа
10	Ч.Март	Нарийн сүхайтын нүүрсний уурхайн орон нутагт үзүүлэх нийгэм эдийн засгийн нөлөөлөл	ШУТИС. ГУУС	Магистр С.Лхаахүү



ШИЛДЭГ УДИРДАГЧ БАГШААР:


Техник, технологийн салбараас БАС-ийн Инженерийн байгууламжийн салбарын дэд профессор, доктор (PhD), дэд профессор С.Хаснавч

Байгалийн ухаан, экологийн салбараас ХШҮС-ийн Химийн инженерчлэлийн салбарын ахлах багш, доктор (Ph.D) Б.Өлзийдэлгэр

Нийгэм, хүмүүнлэг, дизайны салбараас БАС-ийн Архитектурын салбарын багш Э.Болорцэцэг

Эдийн засаг, менежментийн салбараас МХТС-ийн Компьютерын ухааны салбарын дэд профессор, Доктор (Ph.D), дэд профессор Г.Ганчимэг нар шалгарлаа.






Илтгэл хэлэлцүүлсэн оюутнуудын илтгэлийг эмхэтгэн ШУТИС-ийн ЭШ-ний эмхэтгэлийг №8/314 тусгай дугаарт хэвлэв. Шилдэг бүтээлүүдийн танилцуулгыг дугааргүйгээр хэвлэн гаргаж ШУТИС-ийн веб сайтыг оюутан линк-д цахимаар байршуулж нийтийн хүртээл болгов.

ШУТИС-ийн оюутны “ЭРДМИЙН XXII ЧУУЛГАН”-ны шилдэг бүтээлийн уралдааны талаар

Шилдэг бүтээлийн танилцуулга 2023 оны 04 дүгээр сарын 28-нд хичээлийн VIII байр 12 давхарт 11:00-15:00 цагт нээлттэй явагдлаа.



Оюутнуудын бүтээлийг шүүн тунгаах шүүгчийн бүрэлдэхүүн бүрэн бүрэлдэхүүнээр 11:00-15:00 цаг хүртэл тасралтгүй бүтээлүүдтэй танилцаж тус бүр зөвлөгөө өгч, зарим нэг тодруулга хийж, цаашид анхаарах асуудлуудыг нь хэлж нягт нямбай ажиллалаа.



Шилдэг бүтээл шалгаруулах комиссын бүрэлдэхүүнд:

Комиссын дарга:

Н.Эрдэнэхүү (Сургалт, цахим шилжилтийн газрын захирал, доктор (Ph.D), профессор)



Комиссын нарийн бичгийн дарга:

Д. (Оюутны соёл, үйлчилгээний албаны ахлах мэргэжилтэн, доктор (Ph.D), дэд профессор)

Оюутны шилдэг бүтээлийг шалгаруулах зөвлөл.

Ч.Оюунжаргал (Барилга, архитектурын сургуулийн Инженерийн зурагзүйн тэнхимийн дэд профессор, доктор (PhD))

Ж.Алимаа (Мэдээлэл, холбооны технологийн сургуулийн Компьютерын ухааны салбарын дэд профессор, доктор(Ph.D), профессор)

Д.Гэрэлт-Од (Геологи, уул уурхайн сургуулийн Эрдэс боловсруулалт, инженерчлэлийн салбарын профессор, доктор (Ph.D), дэд профессор)

Р.Бадмаанямбуу (Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн Хөнгөн үйлдвэрийн технологийн инженерчлэлийн салбарын ахлах багш, доктор (Ph.D))

Д.Батсүх (Механик, тээврийн сургуулийн Механик, мехатроникийн тэнхимийн ахлах багш)

Б.Жигжид (Барилга, архитектурын сургуулийн Архитектурын салбарын профессор, доктор (Ph.D))

Д.Энхбаяр (Геологи, уул уурхайн сургуулийн Геологи гидрогеологийн салбарын эрхлэгч, доктор (Ph.D)) нар ажиллаж шилдэг бүтээлүүдийг тодрууллаа.

д/д	Бүтээлийн нэр	Оюутны овог нэр	Сургууль, анги, курс	Удирдсан багш
	ТЭРГҮҮН БАЙР			
1.	БОРТГОНД МОДЛОГ УРГАМЛЫН ҮРИЙГ ТАРИХ ХАГАС АВТОМАТ ШУГАМЫН ХИЙЦ, ЗОХИОН БҮТЭЭЛТ	С.Баярт, А.Алтанбагана	ҮТС-ийн ХҮМГТ-4	Д.Пүрэвмагнай Хөнгөн үйлдвэрлэлийн технологи, инженерчлэлийн салбарын ахлах багш
	ДЭД БАЙРАНД			
1.	УЛААНБААТАР ХОТЫН МУБИС-ИЙН АВТОБУСНЫ БУУДЛЫГ ХЭРЭГЛЭГЧИЙН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГАД ҮНДЭСЛЭН САЙЖРУУЛАН ТӨЛӨВЛӨХ СУДАЛГАА	Ш.Төгсжаргал, Ө.Дагийсүрэн, Ч.Бумдэлгэрэх, Б.Үржинханд	Архитектур, II курс	Э.Болорцэцэг, Архитектурын салбарын багш,
	ГУТГААР БАЙРАНД			
1.	ХАЯГДАЛ ХУВАНЦАР ХАЙЛУУЛАХ МАШИНЫ ХИЙЦИЙН ШИЙДЭЛ	И.Дөлгөөн, Б.Энэрэл	ДаТС-ҮМ-3	Ц.Баярмаа (багш)
2.	ХӨЛДӨӨЖ ХАТААСАН ХООЛНУУД	З. Саруултуяа, А.Дуламсүрэн	ХҮҮТ III	С.Сэржмядаг Ахлах багш, Док (Ph.D) Г.Долгорсүрэн

**ШИЛДЭГ УДИРДАГЧ БАГШААР:**

1. ҮТС-ийн Хөнгөн үйлдвэрлэлийн технологи, инженерчлэлийн салбарын ахлах багш Д.Пүрэвмагнай
2. МХТС-ийн Компьютерын ухааны салбарын дэд профессор, Доктор (Ph.D) Ж.Алимаа нар шалгарч Батламж, мөнгөн шагналаар шагнууллаа.





Англи хэлний олимпиад

2022 оны 11 сарын 7-21-ний хооронд Англи хэлний 28-р олимпиадыг “ENGINEERING ENGLISH = SUSTAINABLE FUTURE LIFE” уриа дор ГХС-ийн англи хэлний тэнхимтэй хамтран амжилттай зохион баайгууллаа. Энэхүү олимпиад нь оюутны англи хэлний ур чадварыг хөгжүүлэх, тэдний англи хэл сурах хүсэл сонирхлыг өрнүүлэх, ирээдүйн ажлын байранд англи хэлний ур чадвараа хэрэглэх дадал чадвар суулгах зорилготой үзүүлэн илтгэл, хэлэлцүүлэг, ажлын байрны англи хэлний шалгалт, видео зэрэг сонирхолтой агуулгын хүрээнд амжилттай явагдлаа.

2022-2023 хичээлийн жилийн намрын улиралд ШУТИС-ийн бакалаврын хөтөлбөрт тусгагдсан Харилцааны англи хэл (SCE102), Шинжлэх ухаан технологийн англи хэл (S.EST210), Бизнес менежментийн англи хэл (S.EBM210), Инженерийн англи хэл II (S.EGE 250), Инженерийн англи хэл III (S.EGE350), Тусгай зориулалтын англи хэл (S.ESP310) хичээлийг судалж буй 2600 оюутан ганцаарчилсан болон багийн төрлөөр 3 шаттай тэмцээнд амжилттай оролцлоо. Төгсгөлийн шатанд 64 оюутан бусдыгаа манлайлан I-IV байр эзэлсэн.

Үүнд: S.CE102 хичээлээр: 1-р байр – ҮТС-ийн баг, 2-р байр – БАС-ийн баг, 3-р байр – MeTC-ийн баг, Тусгай байр - Өмнөговь аймаг дахь мэдээлэл холбоо технологийн сургуулийн баг, S.EST 210 хичээлээр: 1-р байр – ГУУС-ийн I баг, 2-р байр – БАС-ийн баг, 3-р байр – ЭХС-ийн баг, Тусгай байр - ГУУС -ийн II баг, S.ESP 310 хичээлээр: 1-р байр – MeTC-ийн баг, 2-р байр – ҮТС-ийн баг, 3-р байр – БАС-ийн баг, Тусгай байр – МХТС -ийн баг шалгарлаа. Тэргүүн байр эзэлсэн оюутнууддаа кредитийн урамшуулал олгов.



Монгол хэл бичгийн олимпиад

ГХС-ийн Ази судлалын салбар, ОХСҮА-тай хамтран, ШУТИС-ийн оюутнуудын дунд жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг Ж.Бямбадоржийн нэрэмжит “Үндэсний бичгийн олимпиад”-ыг 2023 оны 3 сарын 15-25-ны хооронд 2 үе шаттайгаар амжилттай зохион байгууллаа.

Энэхүү олимпиад нь “Үндэсний бичгийн үндэсний хөтөлбөр III”-ыг хэрэгжүүлэх, монголчуудын оюуны соёлын давтагдашгүй өв - үндэсний бичгийг оюутан, залуучуудад эзэмшүүлэх, хэрэглээний орчин нөхцөлийг бий болгох, хамгаалах, судлах, сурталчлах, өвлүүлэх зорилготой.





Энэ удаагийн олимпиадыг АСС-ын монгол хэлний багш Д.Дуламсүрэн Б.Сонинцэцэг, Б.Дэлгэрмаа, Н.Мөнхжаргал, С.Баасанжаргал нар зохион байгуулав. Идэвх санаачилгатай ажилласан Ази судлалын багш доктор Б.Дэлгэрмаа үндэсний бичгийг түгээн дэлгэрүүлэгч багшаар шалгарав.



Олимпиадын I шатыг III/18 -нд цахимаар зохион байгуулсан бөгөөд нийт 180 гаруй оюутан оролцож, үндэсний бичгийн онолын мэдлэгээ сорьсноос 61 оюутан II шатанд шалгарав. II шатыг III/25-нд зохион байгуулж, оролцогчдын үндэсний бичгийн унших, зөв бичих чадварыг сорилоо.

Олимпиадад байр эзэлсэн оюутнууд:

I байр	Ц.Мөнх-Үйлс	B222870044	БАС
II байр	Б.Энхтөр	B221330018	БХУС
III байр	О.Милха	B222920002	БАС
IV байр	Э.Энхжин	B222660616	ӨмТДС

Клубүүдийн үйл ажиллагаа

ШУТИС-ийн оюутны сайн дурын, мэргэжлийн, урлагийн клубүүд 2022-2023 оны хичээлийн жилийн жилд тасралтгүйгээр үйл ажиллагаагаа явуулж олон талт үйл ажиллагааг ОХСҮА-тай хамтран зохион байгуулан ажиллалаа. Клубүүдийн үйл ажиллагаа тайлангийн явцад дурдагдаад явсан ч тусгайлан клубүүд хийсэн ажилаа намрын улирал хаврын улиралд тус бүр тайлангаа тавьж хэлэлцүүлэн үнэлгээ дүгнэлт авч явдаг Намрын улирлын тайлан хэлэлцэх хуралд нийт 39 клуб тайлангаа хэлэлцүүлсэн. Хаврын улиралд нийт 32 клуб тайлан хэлэлцүүлээ. Тайлан хэлэлцэх хурлуудад мэргэжлийн багш нараас төлөөлөл болгон ажиллуулдаг намрын улирлын тайлан хэлэлцэх хуралд МХТС-ийн Компьютерын ухааны салбарын дэд профессор, Доктор (Ph.D), дэд профессор, spesh ship клубийн зөвлөх багш Г.Ганчимэг ажилласан бол хаврын улиралд ГУУС-ийн геодези салбарын ахлах багш, Доктор (Ph.D), “Геодези” клубийн зөвлөх багш Г. Өлзийсайхан нар үнэлгээ дүгнэлт өгч, санал хүсэлтийг нь сонсож ажилласан. Клубүүдийн үйл ажиллагаа жигдэрч клубийн ахлагч, гишүүдийн



төлөөлөл өөрсдийн хийсэн, санаачилсан бүхий л үйл ажиллагаагаа нээлттэй танилцуулж хариуцлагатай ажиллаж байна. Клубүүд үйл ажиллагаагаа тогтвортой, саадгүй явуулахад тулгамдаж буй гол асуудал ялангуяа мэргэжлийн клубүүд өрөөгүй, өрөөний асуудал хүндрэлтэй байгааг, “Оюутны хөгжил” танхим хичээлийн VIII байр В-1 тоот танхимд байрладаг. Тус танхимд сургалт, үйл ажиллагаа явуулахад таазан дээгүүр нь бохирын хоолойн усны дуу чимээ их гардаг асуудал хүндрэлтэй байгааг дурьдлаа, Хэв журам сахиулах “Соёмбо” клуб оюутны байранд оюутнууд хэв журмын зөрчил гаргах нь багассан харин орчны тохижилт, үйлчилгээнд анхаарах шаардлагатай байна гэж дүгнэсэн байна.



Клубүүдийн үйл ажиллагаа оюутны нэгдэл, хүсэл сонирхол санаачилгад тулгуурлан явагддаг тул тэр бүр их зүйл шаардаад байдаггүй, аливаа асуудал тулгарсан ч өөрсдөө түүнийгээ мэдлэг чадвар, хүсэл тэмүүлэл, багийн ажиллагаагаараа даван туулдгаараа давуу талтай байгаа нь тайлангийн явцад харагдаж байлаа.

Урлагийн клубийн үйл ажиллагаа

ОХСҮА-ны соёл, урлаг хариуцсан мэргэжилтэн Ц. Болдбаатар нь урлагийн клубүүдийг хариуцан ажилласан бөгөөд хичээлийн жилийн нээлт, хаалт, эрдэм шинжилгээний хурал, эрдмийн зэрэг цол олгох, бүрэлдэхүүн сургуулиудын болон ШУТИС-ийн нэгдсэн томоохон арга хэмжээнүүдийн хөтөлбөр боловсруулж хөтлөгч, дуучнаар ажилласан.

2022-2023 оны хичээлийн жилд 22 үйл ажиллагаанд хөтлөгчөөр ажилласан.

2022-2023 оны хичээлийн жилд :

- Чөлөөт бүжиг-25 оюутан
- Хос-Уянга-15 оюутан
- Дуулаач-15 оюутан
- MUST Comedy- 20 оюутан
- Морин хуур-2 оюутан

Клубүүд үйл ажиллагаа явуулсан. Цэнгээнт бүжгийн Хос-Уянга хамтлагийн багшаар бүжгийн спортын мастер Б.Төрболд багштай гэрээ байгуулан ажилласан.

Сургуулийн нэгдсэн, олон нийтийн, урлаг соёлын нийт 10 гаруй арга хэмжээнд тус клубүүдийн оюутнуудыг идэвхтэй хамруулж ажилласан.



- Цэнгээнт бүжгийн Хос-Уянга хамтлаг нь 2022 оны улсын аварга шалгаруулах тэмцээнд алт медаль
- Их британи улсад зохион байгуулагдсан цэнгээнт бүжгийн тэмцээнд **латин пермийн** төрөлд дэлхийн аварга болсон.
- Монголын оюутны урлагийн их наадамд амжилт гарган алтан медалийн эзэд болсон
- Мөн чөлөөт бүжгийн клуб гаднын байгууллуудтай хамтран ажиллаж улсын тэмцээнүүдэд амжилт гарган ажиллаж байна.
- Чингэлтэй дүүргийн улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран тоон гарын үсэг олгох ажлыг зохион байгуулсан. Улсын бүртгэлийн ажилчдын гарын үсэг олгох байршилд орчныг бүрдүүлэн, ШУТИС-ийн цахим хуудас, пэйж

2022 оны шилдэг клубүүдээ шалгаруулав



ШУТИС-ийн шилдэг мэргэжлийн, сайн дурын, урлагийн клубүүдэд АКАДЕМИЧ



Х.ЭНХЖАРГАЛЫН нэрэмжит шагнал гардуулах ёслолын ажиллагаа 2022 оны 12 дугаар сарын 28 нд боллоо. Тус арга хэмжээнд Академич, Х.Энхжаргал болон ОХСҮА-ны дарга Н.Санчирбаатар тэргүүтэй төлөөлөл оролцоо.



Шилдэг оюутнуудад хандан Академич Х.Энхжаргал ШУТИС-д 1980 оноос хойш багшаар ажиллаж эхэлсэн ба сүүлийн 9 жил ШУТИС-ийн Сургалт эрхэлсэн проректорын албан тушаал хашиж байсан. Энэ хугацаандаа оюутнуудын бүтээлч сэтгэлгээ, багийн ажиллагааг олон талаас нь дэмжин оюутны албатайгаа хамтран ажиллаж өөрийн нэрэмжит шагналаа 3 дахь жилдээ шилдэг клубийн оюутнууд та бүхэндээ гардуулж буйд талархаж байгаагаа илэрхийллээ.

Мэргэжлийн шилдэг **“HIGH-TECH”** клуб

Сайн дурын шилдэг клуб **“БАГШИЙН ТУСЛАХ ОЮУТАН”** клуб

Урлагийн шилдэг клуб **“ХОС УЯНГА”** клубүүдэд шагналыг гардууллаа.



Шилдэг клубүүдийн өргөмжлөлийг МехТС-ийн мэргэжлийн Pro Mesh клубийн багш, оюутнууд өөрсдийн гараар хийж бүтээснээрээ онцлог байлаа. Pro Mesh клубийн зөвлөх багш нар, оюутнууддаа талархал илэрхийлье.



ШУТИС-ийн Клубүүдийн нэгдсэн зөвлөлийн (КНЗ) ахлагчаар ажиллаж байсан О.Сансармаа 2023-2024 оны намрын улиралд 3,5 жилээр сургуулиа төгсөж Австрали улсын Сидней хотын Технологийн Их Сургуульд Наношинжлэх ухаан инженерчлэл мэргэжлээрээ 100% -ийн тэтгэлгээр магистрт үргэлжлүүлэн суралцах урилга авсан тул КНЗ-ийн ахлагчийн ажлаа дараагийн ахлагчдаа хүлээлгэн өглөө.

Бид КНЗ-ийн ахлагчийг сонгохдоо тухайн оюутан аль нэг клубийн ахлагчийн ажлыг ямар хэмжээнд хийсэн ажлын үр дүн, идэвх санаачилгыг нь харж, ажлын тайланг нь сонсож дүгнэсний дараа санал солилцож байж сонголтоо хийдэг уламжлалын дагуу БАС-ийн СИ-III курсийн оюутан Д. Жамсранг томиллоо. Д.Жамсран нь мэтгэлцээний “Empowerment” клубийн ахлагчаар ажиллаж байсан болно.

КНЗ-ийн ахлагчийн ажил хүлээлцэх арга хэмжээнд ОХСҮА-ны ахлах мэргэжилтэн доктор, дэд профессор Д. болон мэргэжилтэн, СТА, урлагийн клубүүдийн зөвлөх багш Ц.Болдбаатар нар байлцаж цаашид хэрхэн хамтран ажиллах, хариуцлагатай байх, багийн ажиллагааг хөгжүүлэх гээд олон талаар зөвлөгөө өгч санал солилцоод, клубүүдийн тайлангийн эмхэтгэлүүдийг танилцууллаа.



О.Сансармаа ажлаа хүлээлгэн өгөхдөө дараагийн ахлагч Д.Жамсранд ажлын төлөвлөгөө, хувийн зохион байгуулалт, хариуцлага, хамтын ажиллагаа, санаачилга маш чухал байдаг шүү гээд тэмдэглэлийн дэвтэр, өөрийн хайртай балаа дурсгал болгон өглөө.



О.Сансармаад КНЗ-ийн ажлыг санаачилгатай, идэвхтэй сайн хийсэнд нь талархал илэрхийлж ОХСҮА-наас талархлын бичиг, дурсгалын зүйл гардуулав. Бид Дэлхийд үнэлэгдэх үнэ цэнтэй төгсөгчийг бэлтгэж байгаадаа

баяртай байна.

Клубийн оюутнууд ШУТИС-ийг төлөөлөн олон төрлийн үйл ажиллагаа, хурал чуулга уулзалт орж ажилласан танилцуулга.

“Монголын ирээдүй залуучуудын оролцоо” чуулга

1000 хүний оролцоотой “Монголын ирээдүй, Залуусын оролцоо” анхдугаар чуулганд оролцсон. НҮБ-ын Эдийн засаг нийгмийн зөвлөл (UN ECOSOC)-д тусгай зөвлөлдөх статустай HWPL энх тайвны ОУТББ нь IPYG нийгэмлэгийн сайн дурын залуустай хамтран иргэний нийгэм, боловсрол, хууль зэрэг салбар бүрийн төлөөлөл, сайн дурынхныг хамарсан 1000 хүний оролцоотой “Монголын ирээдүй, Залуусын оролцоо” анхдугаар чуулганыг 4-р сарын 8-нд Corporate Hotel & Convention Centre-ийн концертын танхимд амжилттай зохион байгуулагдсан.



Энэхүү чуулганы үеэр залуучуудын ухамсар, хандлагыг дээшлүүлж, тэдний нийгэм дэх бодит оролцоог нэмэгдүүлэх арга замууд болон дэлхий дахинд аюулгүй, амар тайван нийгмийг цогцлооход чухал үр нөлөөтэй “Дайныг зогсоож, энх тайвныг тогтоох тунхаглал (DPCW)”-ын хүрээнд хэрэгжиж буй энх тайвны соёлыг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааны ач холбогдлыг танилцуулсан байна.

Инноваци технологийн төвтэй танилцсан өдөрлөг

Гарааны компани, энтрепренер залуусыг хөгжүүлж бойжуулах, залуучуудыг таатай ажлын орчноор хангах зэрэг зорилготой Инноваци технологийн төвтэй мэргэжлийн клуб, сайн дурын клуб, урлагийн клубүүдийг 2023.03.10-нд тус төвийн ажилтан Болороор удирдуулан танилцсан.

Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн оюутнуудын өөрсдийн мэргэжил, сонирхлоороо нийлсэн залуучуудын үнэт оюунлаг санаа, хүч хөдөлмөрийг үнэлэх хувийн болон төрийн байгууллагуудтай төгсөгч нар болон суралцаж байх хугацаандаа өөрийн хувийн бизнестэй болох зэрэг олон олон боломжийн хажуугаар багаараа хамтран өрөө байгууламж түрээслэх боломж хөнгөлөлтийг олж авсан.



Бусдад хүртээмжтэй байлгах талаас цахим хаяг дээрээ бичлэг хийн байршуулсан ба мэргэжлийн камераар танилцуулга яриа, өрөөнүүдийн үнийн мэдээлэл ямар ямар хөтөлбөр хэзээ болдог болон дөнгөж шинээр эхэлж буй байгууллагуудын үйл ажиллагаа, хэрхэн өөрөө бизнес эхлэх талаар мэдлэгийг ирж амжаагүй гишүүд ахлагч нартаа түгээсэн.

“Монгол оюутны үнэт өв” цахим бичлэг

ТӨБИС-ийн хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулсан оюутны үнэт зүйлийн судалгааг хийсэн. Ажлын хүрээнд “Монгол оюутны үнэт өв” цахим бичлэг, сургуулиудын танилцуулга видео контентыг лаборатори, хийсэн энэ ажилд клубийн оюутнууд оролцов.

Монгол хүн болж мэндэлснээрээ өв соёлоо цаашид хувь хүн хэрхэн үргэлжлүүлэх, гэр бүл төлөвлөлт, улс төрийн талаар Зөв зохистой хооллолтын клубийн гишүүн, Э.Л.Ч мэтгэлцээний клубийн ахлагч Ганхүү, Хитонен япон хэлний клубийн ахлагч Дөлгөөн, Клубийн Нэгдсэн Зөвлөлийн тэргүүн О.Сансармаа нар оролцсон билээ.

МОНГОЛ ОЮУТНЫ ҮНЭТ ӨВ 4



Монгол улсын одоогийн нийгэмд залуучууд гадаад улс уруу суралцахаар явах, Монгол улсдаа мэргэжлээрээ ажиллавал бага цалинтай ажилд орохгүйн тулд гадаад оронд хар ажил хийх, үүнийгээ дагаад гэр бүл төлөвлөлт хоцрох, эдийн засагтаа итгэхгүй байх цаашлаад Монгол хүний үнэт өвөө алдах зэрэг асуудлууд хаалга тогшиж



байгаа тул аль болох эергээр ирээдүйгээ төсөөлөн өөрсдийн үзэл бодлоо хуваалцсан ярилцлага болсон.

Клубүүдийн нэгдсэн зөвлөлөөс санаачлан шилдэг төгсөгчийн цуврал лекцийг зохион байгуулсан.


Үүний гол зорилго нь ШУТИС-ийн клубүүдийн ахлагч, гишүүд нь ихэнхдээ ШУТИС-ийн шилдэг төгсөгчид байдаг. Тэд төгсөөд шууд ажлын байртай болсон, гадаадад тэтгэлгээр суралцсан мөн хувийн бизнесээ эхлүүлсэн, нийгмийн байр сууриа эрт олж авсан төгсөгчид байдаг. Тиймээс мэргэжлийн болон сайн дурын, урлагийн клубүүдийн төгсөгч нараас суралцах хугацаандаа хувь хүний төлөвшил, цаг хугацааны хуваарилалтаа хэрхэн хийж, тэргүүлдэг, өргөн цар хүрээтэй сэтгэдэг талаар нь ярилцлага авч нийт оюутнууддаа цахимаар хүргэн ажиллах эхний бичлэгийг хийсэн цаашид уламжлан болгон зохион байгуулах стандартыг бүрдүүлсэн.

Эхний зочноор ШУТИС-ийн шилдэг төгсөгч, МХТС-ийн ССС клубийн гишүүн, төгсөгч З.Гантүшиг оролцлоо.



Мөн НБТ-өөр цахим контент бичүүлж тус бичлэгийг хөдөө орон нутгийн тур аялалд ирсэн багш нарт хуулан өгч явуулах зэргээр сурталчилгааг хийв.





5.3. Оюутны тэтгэлэг, урамшуулал, хөнгөлөлт

Төр болон нийгмийн үйлчилгээнд оюутныг хамруулсан байдал Сан, тэтгэлэг хөтөлбөрт хамрагдсан байдал

№	Тэтгэлгийн нэр	Тэтгэлэг авсан оюутны тоо	Нийт тэтгэлгийн хэмжээ /төгрөг/
1	Захирлын нэрэмжит тэтгэлэг	52	79,584,000



2	Голомт банкны тэтгэлэг	9	9,000,000
3	Оюутолгой ХХК-ийн дотоодын тэтгэлэг	10	47,240,000
4	Эрдэнэс таван толгой ХХК-ийн тэтгэлэг	25	25,000,000
5	Кредитийн урамшуулал	271	57,908,640
	Нийт	367	218,732,640

Захирлын нэрэмжит тэтгэлэг “Шилдэг элсэгч” оюутан

“ШУТИС-ийн суралцагчдад тэтгэлэг, кредитийн урамшуулал олгох журмын”-ын дагуу оюутны амжилт, амьдралын боломж бололцоо буюу санхүүгийн дэмжлэг зайлшгүй авах шаардлагатай 2022-2023 оны хичээлийн жилд шинээр элсэгч 11 оюутанд 30 кредитийн хөнгөлөлт буюу 45 сая 545 мянга 280 төгрөгийн хөнгөлөлтийг тус тус олгов.

“ШУТИС-ийн Ректорын нэрэмжит тэтгэлэг”-т хамрагдсан “Шилдэг элсэгч” оюутны нэрс:

Хүснэгт 6.2

д/д	Сургууль	Мэргэжил	Овог	Нэр	Кредит
1	Барилга, архитектурын сургууль	УСНЫ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ	ШИНЭБАЯР	ДӨЛГӨӨН	30
2	Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль	МАРКЕТИНГИЙН МЕНЕЖМЕНТ	ЧИРЧМАА	ДАШНЯМ	30
3	Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль	АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ	БААТАРМАА	ЦЭРЭНДОЛГОР	30
4	Гадаад хэлний сургууль	ГАДААД ХЭЛНИЙ ОРЧУУЛГА /ХЯТАД ХЭЛ/	НОМИНЧУЛУУН	МАРАЛМИЧИД	30
5	Үйлдвэрлэлийн технологийн сургууль	ХЭВЛЭЛИЙН ГРАФИК ДИЗАЙН	ӨЛЗИЙЖАРГАЛ	ТҮШИГ	30
6	Механик тээврийн сургууль	МЕХАНИК ИНЖЕНЕРЧЛЭЛ /2+2/	ДАШДАВАА	ДАШДЭМБЭРЭЛ	30
7	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ	БАТБАЯР	МӨНХ-ОРГИЛ	30
8	Эрчим хүчний сургууль	СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧ (Хамтарсан)	ЭНХБАЯР	АЗЖАРГАЛ	30
9	Дархан-уул аймаг дах Технологийн сургууль	УУЛ, УУРХАЙН АШИГЛАЛТЫН ТЕХНОЛОГИ	БАТХУЯГ	БАТМӨНХ	30
10	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	ХИЙМЭЛ ОЮУН УХААН	БЯМБАСҮРЭН	ЭНХЗУЛ	30
11	Геологи, уул уурхайн сургууль	УУЛ УУРХАЙН АШИГЛАЛТЫН	БАТБААТАР	ТЭНГИС	30



		ТЕХНОЛОГИ /хамтарсан/			
--	--	--------------------------	--	--	--

Захирлын нэрэмжит тэтгэлэг “Суралцагч” оюутан

Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн хамгийн нэр хүндтэй тэтгэлэг болох “Захирлын нэрэмжит тэтгэлэг” гардуулах ёслолын ажиллагаа 2023 оны 06-р сарын 02-ны өдөр боллоо.

Тэтгэлэг гардуулах ёслолын ажиллагаанд ШУТИС-ийн захирал доктор (Ph.D), профессор Т.Намнан оролцож 2022-2023 оны хичээлийн жилийн шилдэг суралцагч оюутнуудад хандан үг хэлж “Захирлын нэрэмжит тэтгэлэг”-ийг гардууллаа.

Сурлага, эрдэм шинжилгээ, урлаг, спорт, олон нийтийн идэвх оролцоо, мэргэжлийн ур чадвараараа сургуулийнхаа оюутнуудыг манлайлсан шилдэг 9 оюутан тус бүрд 30 кредитийн сургалтын төлбөрийн хөнгөлөлт үзүүлж дурсгалын зүйлээр шагнав.



Шилдэг суралцагч оюутнууд

“ШУТИС-ийн Ректорын нэрэмжит тэтгэлэг”-т хамрагдсан “Шилдэг суралцагч” оюутны нэрс:

д/д	Сургууль	Мэргэжил	Овог	Нэр	Кредит
1	Барилга, архитектурын сургууль	АВТОЗАМЫН БАРИЛГА	СУГАРЖАВ	СУМЪЯАБАЗАР	30
2	Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль	НИЙГМИЙН АЖИЛ	НАСАНБАТ	БАЙГАЛЬЗУЛ	30
3	Геологи, уул уурхайн сургууль	АШИГТ МАЛТМАЛЫН БАЯЖУУЛАЛТЫН ТЕХНОЛОГИ	ЦЭНДОО	ХАЖИДМАА	30



4	Гадаад хэлний сургууль	ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙН ОРЧУУЛГА /АНГЛИ ХЭЛ/	БАЛДАН-ОСОР	ЦОЛМОН	30
5	Дархан-Уул аймагдах технологийн сургууль	УУЛ УУРХАЙН АШИГЛАЛТЫН ТЕХНОЛОГИ	БАТБААТАР	АМАРТҮВШИН	30
6	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	АВТОМАТЖУУЛАЛТЫН СИСТЕМ	ОТГОНБАТ	ОТГОНБИЛЭГ	30
7	Хэрэглээний шинжлэх ухааны сургууль	НАНОШИНЖЛЭХ УХААН, ИНЖЕНЕРЧЛЭЛ	ОДБАЯР	САНСАРМАА	30
8	Эрчим хүчний сургууль	СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧ	БАТМӨНХ	МӨНГӨНШАГАЙ	30
9	Геологи, уул уурхайн сургууль	ГАЗРЫН ТОСНЫ ИНЖЕНЕР	ГАНБААТАР	ӨСӨХБАЯР	30

“Эрдэнэс тавантолгой” хк оюутнуудад Сургалтын тэтгэлгийн батламж гардууллаа.



“Эрдэнэс Тавантолгой” ХК нийгмийн хариуцлагын хүрээнд Оюутны тэтгэлэгт хөтөлбөрийг 2013 оноос жил бүр зарлаж ирсэн. 2022-2023 оны хичээлийн жилд сургалтын төлбөрийн тэтгэлэгт хамрагдсан 90 оюутан өнөөдөр /2022.11.23/ батламжаа гардан авлаа. Тус компани нь 2013 оноос Өмнөговь аймгийн харьяат оюутнуудад тэтгэлэг олгож эхэлсэн бол 2019 оны хичээлийн жилээс тэтгэлэгт хөтөлбөрөө үндэсний хэмжээнд зарлан, хэрэгжүүлж байна. Энэ хугацаанд нийт

436 оюутанд 436 сая төгрөгийн сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлээд байна.



Оюутнуудад батламж гардуулах ёслолын ажиллагаанд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Захиргаа, удирдлагын газрын дарга Н.Анун, Гадаад харилцаа, хамтын ажиллагааны албаны дарга Т. Гүнжээ Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Оюутны хөгжил, соёл үйлчилгээний албаны мэргэжилтэн Г.Анударь болон бусад албаны төлөөллүүд оролцов.



Тэтгэлэгт шалгарсан оюутнуудыг төлөөлж ШУТИС-ийн Механик, тээврийн сургуулийн “Авто инженер”-ийн 3 дугаар курсийн оюутан А. Бямба-Очир өөрийн сэтгэгдэл, туршлагыг хуваалцав.

2022-2023 оны хичээлийн жилд Шинжлэх ухаан, технологийн их сургуулиас 25 оюутан тэтгэлэгт хөтөлбөрт шалгарчээ

Нийтийн тэвэрээр зорчих хөнгөлөлтөд хамруулсан байдал

Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/740 дүгээр захирамж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 6/21 тогтоолоор батлагдсан “Цахим карт олгох, цэнэглэх, ашиглахад баримтлах журам”, Нийслэлийн Боловсролын газрын даргын 2021 оны 09 дүгээр сарын 1-ий өдөр батлагдсан “Их, дээд сургуулийн оюутанд нийтийн тээврийн цахим төлбөрийн карт олгох, сунгах ажлыг зохион байгуулах удирдамж”-ын дагуу 2021-2022 оны намрын улиралд 4148 оюутан оюутны автобусны хөнгөлөлттэй картаар зорчиж байна.

2022-2023 оны хичээлийн жилд нийтийн тээврийн хөнгөлөлтийн карт захиалсан оюутны тоо

№	Сургууль	Шинээр карт захиалсан оюутны тоо
1	Барилга, архитектурын сургууль	315
2	Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль	279
3	Геологи, уул уурхайн сургууль	201
4	Механик тээврийн сургууль	200
5	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	579
6	Үйлдвэрлэлийн технологийн сургууль	218
7	Хэрэглээний шинжлэх ухааны сургууль	66
8	Эрчим хүчний сургууль	305
9	Гадаад хэлний сургууль	41
10	Коосен- Технологийн коллеж	8
	ДҮН	2212

Төгсөгч оюутны анкет

Хичээлийн жилийн намар, хаврын улиралд төгсөгч оюутан “Төгсөгч оюутан анкет”-ийг бөглөдөг. Ингэснээр ажил олгогч, боловсон хүчнээ хайж байгаа байгууллагуудтай холбож өгөх, төгсөгч оюутнуудыг мэргэжлийн дагуу ажлын байранд зуучлах ажлыг зохион байгуулж байна.

2022-2023 оны хичээлийн жилд Төгсөгч оюутны анкет бөглөсөн оюутны тоо

№	Сургууль	2023 оны 01 сар	2023 оны 06 сар	Нийт
1	БАС	147	180	327



2	БаТС	31	35	66
3	БуХС	106	117	223
4	ГУУС	113	158	271
5	МехТС	171	187	358
6	МХТС	119	194	313
7	ҮТС	291	303	594
8	ХШУС	74	92	166
9	ЭХС	279	323	602
10	ГХС	34	46	80
11	ДаТС	72	106	178
	ДҮН	1437	1741	3178

5.4. НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭ

2022-2023 оны намрын улирлын төгсөлтийн үйл ажиллагаа

Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн бакалаврын 89, магистрын 51 дэх удаагийн төгсөлтийн ёслолын ажиллагаа, эрдмийн баяр 1 дүгээр сарын 25-ны өдөр ёслол төгөлдөр зохион байгуулагдлаа. ШУТИС-ийн бакалаврын 89, магистрын 51 дэх удаагийн төгсөлтөөр докторын зэрэгтэй 8, магистрын зэргийн дипломтой 239, бакалаврын зэргийн дипломтой 678 төгсөгч төгссөнөөс



онцлох

дипломтой 24, нийт 918 төгсөгч их сургуулиа амжилттай төгсөж байна. БНХАУ-ын Шанхайн ШУТИС-тай хамтарсан дулааны инженер 2+2 хөтөлбөрөөр 11, Биоинженерчлэл 2+2 хөтөлбөрөөр 2, Хойд хятадын эрчим хүчний сургуультай хамтарсан сэргээгдэх эрчим 2+2 хөтөлбөрөөр 7, цахилгаан хангамж хөтөлбөрөөр 17, БНСУ-тай хамтарсан системийн аюулгүй байдал 2+2 хөтөлбөрөөр 2 төгсөгч гадаадын их, дээд сургуультай хамтарсан бакалаврын хөтөлбөрөөр тус тус хос дипломтой төгслөө.

2022-2023 оны намрын улирлын Бакалаврын “Шилдэг төгсөгч” оюутны нэрс

д/д	Сургууль	Мэргэжил	Овог	Нэр	Голч
1	Барилга, Архитектурын сургууль	АРХИТЕКТУР	ЦЭЦХҮҮ	ХОСЦЭЦЭГ	3.75
2	Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль	САНХҮҮГИЙН МЕНЕЖМЕНТ	СҮХБААТАР	БАДАМХАНД	3.66
3	Геологи, уул уурхайн сургууль	УУЛ УУРХАЙН АШИГЛАЛТЫН ТЕХНОЛОГИ	ӨЛЗИЙБАЯР	АВАРЗЭД	3.34
4	Гадаад хэлний сургууль	ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙН	ТҮВШИНБАЯР	ХҮСЛЭН	3.85



		ОРЧУУЛГА /АНГЛИ ХЭЛ/			
5	Дарханы технологийн сургууль	ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ	ҮНЭНЖАРГАЛ	ТЭГШЗАЯА	3.74
6	Механик, тээврийн сургууль	ҮЙЛДВЭРЛЭЛИЙН МЕХАНИКЖУУЛАЛТ	МӨНХДАЛАЙН	БАЯНЗУЛ	3.76
7	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	КОМПЬЮТЕРЫН УХААН	БАТБААТАР	РЭНЧИНСҮРЭН	3.78
8	Үйлдвэрлэлийн технологийн сургууль	ГРАФИК ДИЗАЙН	АМГАЛАНБАТ	ГАНГААМАА	3.68
9	Эрчим хүчний сургууль	ЦАХИЛГААН ХАНГАМЖ	КУАНДАГ	БЭРЭКБОЛ	3.62
10	“Эрдэнэт цогцолбор” дээд сургууль	ЦАХИЛГААН СИСТЕМИЙН АВТОМАТЖУУЛАЛТ	ЭНЭБИШ	ДОЛГОРМАА	3.47
11	Хэрэглээний шинжлэх ухааны сургууль	ҮЙЛДВЭРИЙН ЭКОЛОГИЙН ИНЖЕНЕР	ЦЭРЭННАДМИД	БАТ-ЭРДЭНЭ	3.31

**2022-2023 оны намрын улирлын Бакалаврын
“Тэргүүний төгсөгч” оюутны нэрс**

Д/д	Сургууль	Мэргэжил	Овог	Нэр	Амжилт
1	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	СИСТЕМИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ	ЗОЛЗАЯА	ГАНТҮШИГ	С.С.С клубийн шилдэг бүтээгч. -“SIST STF” мэдээллийн аюулгүй байдлын тэмцээн Тэргүүн байр
2	Үйлдвэрлэлийн технологийн сургууль	ХООЛ, ҮЙЛДВЭРЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЕХНОЛОГИ	ЦООДОЛ	ОХИНОО	“Хос уянга” бүжгийн хамтлагийн гишүүн. -Цэнгээнт бүжгийн улсын аварга шалгаруулах тэмцээн - Тэргүүн байр. Олон улсын бүжгийн спортын тэмцээнд Монгол улсаа төлөөлөн оролцоно.
3	Механик, тээврийн сургууль	МАШИНЫ, ЭЛЕКТРОНИК СИСТЕМ	БАТБОЛД	НЯМДОРЖ	PROMECH клубийн гишүүн -2019,2020,2021 оны Робокон тэмцээний шагналт байр -NCN машинаар бүтээсэн ШУТИС-ийн брэнд бүтээгдэхүүний санаачлагч

“ШУТИС-ийн магистрын ШИЛДЭГ ТӨГСӨГЧ”

Хүснэгт 6.8

Д/д	Сургууль	Мэргэжил	Овог	Нэр	Голч
1	Үйлдвэрлэлийн технологийн сургууль	Хоол зүй,шим судлал	ТӨГӨЛДӨР	БЭРХЭЭДЭЙ	3.88

2022-2023 оны хаврын улирлын төгсөлтийн үйл ажиллагаа



Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2022-2023 оны хичээлийн жилийн хаврын улирлын бакалаврын 90, магистрын 52 дахь удаагийн төгсөлт 2023 оны 6 дугаар сарын 15-ны өдөр Соёлын төв өргөөнд ёслол төгөлдөр зохион байгуулагдлаа. Энэ удаагийн төгсөлтөөр 12 доктор, 249 магистр, 1242 бакалавр, онцлох дипломтой 90 оюутан тус тус төгсөн гарч байна.



Төгсөлтийн ёслолын арга хэмжээнд ШУТИС-ийн захирал доктор (Ph.D), профессор Т.Намнан болон газрын захирлууд, бүрэлдэхүүн сургуулийн захирал, эрдэмтэн багш, төгсөгчид оролцов. Төгсөлтийн арга хэмжээг ШУТИС-ийн захирал доктор (PhD), профессор Т.Намнан нээж үг хэллээ.

Докторын зэргийг амжилттай хамгаалсан төгсөгчдийг төлөөлөн Геологи, уул уурхайн сургуулийг техникийн ухааны докторын зэргийг амжилттай хамгаалсан Дармаагийн Сурмаажав, Магистрын шилдэг төгсөгчдийг төлөөлөн Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн хүнсний сүлжээний хөргөлтийн систем мэргэжлээр төгсөгч Хосбаярын Ундрэм, бакалаврын шилдэг төгсөгчдийг төлөөлж Мэдээлэл, холбооны технологийн сургуулийг автоматжуулалтын систем хөтөлбөрөөр төгсөгч Отгонбатын Отгонбилэг, Барилга, архитектурын сургуулийг архитектур хөтөлбөрөөр төгсөгч Ууганбаярын Гоомарал нар эрдэмтэн багш нар, гэр бүл, найз нөхөд ,зочид төлөөлөгчдөдөө хандан баяр, талархлын үг хэлэв.

2022-2023 оны хаврын улирлын Бакалаврын “Шилдэг төгсөгч” оюутны нэрс

д/д	Сургууль	Мэргэжил	Овог	Нэр	Голч
1	Барилга, Архитектурын сургууль	АРХИТЕКТУР	УУГАНБАЯР	ГООМАРАЛ	3.92
2	Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль	МАРКЕТИНГИЙН МЕНЕЖМЕНТ	ӨЛЗИЙБИЛЭГТ	НАМУУН	3.54
3	Геологи, уул уурхайн сургууль	УУЛ УУРХАЙН АШИГЛАЛТЫН ТЕХНОЛОГИ	РАГЧАА	БАДМААРАГ	3.59
4	Гадаад хэлний сургууль	ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙН ОРЧУУЛГА /АНГЛИ ХЭЛ/	ОРГИЛЧУЛУУН	НАРАНЦЭЦЭГ	3.85
5	Дарханы технологийн сургууль	ПРОГРАММ ХАНГАМЖ	ЛХАГВАДОРЖ	УНДРАХ	3.21
6	Механик, тээврийн сургууль	МАШИНЫ ЭЛЕКТРОН СИСТЕМ	БААСАНЖАРГАЛ	БУЯНДОРЖ	3.45



7	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	КОМПЬЮТЕРИЙН УХААН	БАТЧУЛУУН	МӨНХ-ОРГИЛ	3.43
8	Үйлдвэрлэлийн технологийн сургууль	ИНТЕРЬЕР ДИЗАЙН	АМГАЛАНБААТАР	ЦОЛМОН	3.82
9	Эрчим хүчний сургууль	ЦАХИЛГААН СИСТЕМИЙН АВТОМАТЖУУЛАЛТ	ЛХАГВАСҮРЭН	НОМИН	3.94
10	“Эрдэнэт цогцолбор” дээд сургууль	МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ	БАТБААТАР	ГАНБАТ	3.51
11	Хэрэглээний шинжлэх ухааны сургууль	ХИМИЙН ИНЖЕНЕРЧЛЭЛ	ОТГОНЖАРГАЛ	ТЭМҮҮЛЭН	3.76

**2022-2023 оны хаврын улирлын Бакалаврын
“Тэргүүний төгсөгч” оюутны нэрс**

Д/д	Сургууль	Мэргэжил	Овог	Нэр	Амжилт
1	Барилга архитектурын сургууль	АРХИТЕКТУР	БАТЦЭНГЭЛ	ЛУВСАНЖАМБ А	“Хос уянга” бүжгийн хамтлагийн гишүүн. -2022 Цэнгээнт бүжгийн улсын аварга шалгаруулах тэмцээн - Тэргүүн байр. Олон улсын бүжгийн спортын тэмцээнд Монгол улсаа төлөөлөн оролцож дэлхийн аварга-2022 болсон.
2	Эрчим хүчний сургууль	ЦАХИЛГААН СИСТЕМ	ШИЖИРБААТАР	ӨНӨБОЛД	ШУТИС-ийн ОХ-ны
3	Үйлдвэрлэлийн технологийн сургууль	ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЕХНОЛОГИ	ЦОЛМОНБААТАР	ЖАРГАЛДАЛАЙ	Зөв, зохистой хооллолтын клубийн идэвхтэн гишүүн. Клубийн үйл ажиллагаанд тасралтгүй манлайлан оролцож, удирдан зохион байгуулж байна.



4	Эрчим хүчний сургууль	ЦАХИЛГААН ХАНГАМЖ	БАТСУУРЬ	САНЧИРМАА	ШУТИС-SHARKS багийн холбон тоглогч, 2022-2023 оны Оюутны лигийн Сагсан бөмбөгийн тэмцээн Мөнгөн медаль
5	Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль	САНХҮҮГИЙН МЕНЕЖМЕНТ	ЧУЛУУНЦЭЦЭГ	ХАЛИУН	ШУТИС-SHARKS багийн холбон тоглогч, 2022-2023 оны Оюутны лигийн Сагсан бөмбөгийн тэмцээн Мөнгөн медаль

“ШУТИС-ийн магистрын ШИЛДЭГ ТӨГСӨГЧ”

Д/д	Сургууль	Мэргэжил	Овог	Нэр	Голч
1	Үйлдвэрлэлийн технологийн сургууль	ХҮНСНИЙ СҮЛЖЭЭНИЙ ХӨРГӨЛТИЙН СИСТЕМ	ХОСБЯАР	УНДРАМ	3.81

2022-2023 оны хичээлийн жилийн “Ажлын байрны үзэсгэлэн яармаг” өдөрлөг



Жил бүр уламжлал болон зохион байгуулагддаг “Ажлын байрны үзэсгэлэн яармаг-2023” өнгөрөгч лхагва гаригт буюу 2023 оны 04 дүгээр сарын 26-ний өдөр зохион байгуулагддаг. Өдөрлөгийг ШУТИС-ийн суралцагч болон төгсөгчдийг ажлын байранд зуучлах, хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл зөвлөгөө хүргэх, ажил олгогчийн зүгээс хүний нөөцийн бодлого, аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг таниулах, төгсөгчдийн талаар нарийвчилсан мэдээлэл авах, сонгон шалгаруулалт хийх, ШУТИС болон байгууллага хоорондын

хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилготой зэрэг олон талт үйл ажиллагааг нэг дор зохион байгуулснаараа онцлогтой байлаа.

Уг өдөрлөгт Оюутны хөгжил, соёл үйлчилгээний албатай хамтран ажилладаг. Монголиа Талент Нэтворк (Worki) ХХК болон инженер технологи, банк санхүү, ОУ-ын сайн дурын ТББ, хүнсний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд оролцлоо



Мөн 458 оюутан онлайнар анкет бөглөсөн ба ажил олгогч байгууллагуудад танилцуулан, ажлын байрны захиалгын дагуу мэргэжлийн чиглэлээр оюутнуудын



мэдээллийг өгсөн болно. Тус өдөрлөгт 890 нээлттэй ажлын байр зарлагдаж 109 оюутныг цагийн болон байнгын ажлын байраар хангагдах боломж бүрдлээ.

№	Сургууль	Анкет бөглөсөн оюутны тоо
1	Барилга, архитектурын сургууль	98
2	Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль	54
3	Гадаад хэлний сургууль	10
4	Геологи, уул уурхайн сургууль	51
5	Механик, тээврийн сургууль	46
6	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	62
7	Үйлдвэрлэлийн технологийн сургууль	43
8	Хэрэглээний шинжлэх ухааны сургууль	19
9	Эрчим хүчний сургууль	75
	Нийт	458

Ерөнхий сайд Л. Оюун-Эрдэнэ “Оюутны эрхийн өдөр”- өөр ШУТИС-ийн оюутнуудтай уулзлаа



Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ “Оюутны эрхийн өдөр”- өөр ШУТИС-ийн оюутнуудтай уулзаж буй “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг оюутан, залуучуудад танилцуулах анхны уулзалтаа ШУТИС-иас эхлүүлээ. Өнөөдөр “Олон улсын оюутны эрхийн өдөр” бөгөөд инженер, технологийн салбарын оюутнуудын уулзалтад

Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан болон ШУТИС-ийн эрдэмтэн, судлаач, багш нар оролцов.

Засгийн газрын тэргүүн боловсролын салбарт онцгой анхаарч, багш, оюутнуудын санал хүсэлтийг сонсохоор хүрэлцэн ирсэнд ШУТИС-ийн захирал Т.Намнан талархал илэрхийлсэн. Тэр бээр, “Манай сургууль улс орны эдийн засгийн хөгжил, аж үйлдвэржилтийн бодлогыг авч явах эрдэмтэн судлаачдыг бэлтгэн гаргах, энэ чиглэлд өндөр үр дүнтэй судалгаа, шинжилгээний бүтээл боловсруулан ажиллах үүрэгтэй. Тиймээс чанартай боловсон хүчин бэлтгэхийн төлөө ажиллаж байна.” гэв. ШУТИС нь 11 бүрэлдэхүүн сургууль, Орхон, Өмнөговь аймагт харьяа сургуультай бөгөөд өнөөдрийн байдлаар 16 мянга гаруй оюутан суралцаж байна. “Коосэн” технологийн коллеж, гурван ахлах сургууль, нэг цэцэрлэгтэй аж.



Ерөнхий сайдад хандаж санал, хүсэлтээ илэрхийлсэн багш, оюутнуудын хувьд их, дээд сургуулиудыг хотоос нүүлгэх, оюутны кампус байгуулах, олон улсын жишигт нийцсэн дотуур байртай болох, багш, оюутнуудын хамтарч боловсруулсан төсөлд гарааны санхүүжилт олгох, ажлын байрны тоог нэмэгдүүлэх талаар ярьж байлаа. Мөн авто замын түгжрэлийг бууруулах хүрээнд оюутнуудын хичээл эхлэх, тарах цагийн хуваарьт өөрчлөлт оруулах, элсэгчдийн тоо жил ирэх тусам буурч байгаа газрын тос, хөнгөн үйлдвэрлэлийн салбарыг бодлогоор дэмжих, сургалтын төлбөрийн зарцуулалтыг ил тод болгох, эх орондоо ажиллаж амьдрах таатай нөхцөлийг залууст бүрдүүлж өгөх зэрэг асуудлыг хөндөж байв. Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ тэдний саналыг сонсож, нээлттэй ярилцав. Мөн уулзалтаар яригдсан тодорхой асуудлуудыг Засгийн газарт танилцуулах, багш, оюутнуудын дэвшүүлсэн саналыг судалж ажиллахыг салбарын сайд Л.Энх-Амгаланд үүрэг болголоо.

“Тусгаар тогтнолыг бэхжүүлэхэд оюутан залуусын ёс суртахууны манлайлал” оюутан цэргийн чуулга уулзалт зохион байгуулагдлаа



Батлан хамгаалахын яам, Монгол цэргийн нэгдсэн холбоо, Үндэсний батлан хамгаалахын их сургууль, Монголын Оюутны холбоо болон Шинжлэх ухаан, технологийн их сургууль хамтран 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр “Тусгаар тогтнолыг бэхжүүлэхэд оюутан залуусын ёс суртахууны манлайлал” оюутан цэрэг чуулга уулзалт зохион байгуулагдлаа.



Чуулга уулзалтын нээлтэд МУ-ын Ерөнхийлөгчийн Эрүүл мэнд, спортын зөвлөх Т. Мөнхсайхан, Батлан Хамгаалах яамны дэд сайд Б.Баярмагнай, “Оюутан-цэрэг” сургалтын ерөнхий зохицуулагч Ардын багш Г. Мягмаржав, ҮБХИС-ийн захирал П.Жаргалан, ШУТИС-ийн захирал Т. Намнан, Монголын Оюутны Холбооны Ерөнхийлөгч Г.Анударь болон бусад албаны төлөөлөл болон их, дээд сургуулиудын оюутан цэргүүд оролцлоо.



Мөн чуулга уулзалтын хүрээнд их, дээд сургуулийн оюутан цэргүүдийн дунд зохион байгуулсан буухиа тэмцээний шагналыг гардуулав.


- Тэргүүн байр- Монгол Улсын Их Сургуулийн баг тамирчид
- Дэд байр- Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн баг тамирчид
- Гутгаар байр- Их засаг их сургуулийн баг тамирчид

Нийслэлийн цэргийн штаб болон Монголын Оюутны холбооны шагналаар 13 оюутан цэргийг шагнаж урамшуулав.

Чуулга уулзалтаар Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигийг хэрэгжүүлэн “Оюутан цэргүүд мансууруулах бодис, архидан согтууруулах явдлыг таслан зогсоохыг үлгэрлэн манлайлъя” уриалгыг хэлэлцэн баталлаа.

Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ШУТИС-ийн профессор, багш, оюутнуудтай уулзлаа

Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургуулийн профессор, багш, оюутнуудтай 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр уулзалт хийлээ. Уулзалтын үеэр МУ-ын Их Хурлын дарга Г.Занданшатар “D-Parliament” цахим системийн талаар танилцуулж, хэрэглээ, ач холбогдлын тухай мэдээлэл өгсөн юм.





У ИХ-ын дарга Г.Занданшатар уулзалтын эхэнд хууль тогтоох үйл хэрэгт олон нийтийн санал бодлыг тусгах, иргэдийн эрх ашигт нийцсэн бодлого, шийдвэрийг гаргахад тэдний дуу хоолойг хүргэх, ард олны засаглах эрхийг хангахад веб, аппликейшн хосолсон “D-Parliament” платформын зорилго оршиж байгаа бөгөөд дэлхий нийтийн чиг хандлага хувьсан өөрчлөгдөж, нийгмийн шинэ хэв журам дэлгэрсэн өнөө цагт технологийн дэвшлийг ашиглан ардчиллыг илүү төгөлдөршүүлэхэд залуусын оролцоо, манлайлал чухал гэдгийг онцлон тэмдэглэв.

Уулзалтын дараа МУ-ын Их Хурлын дарга Г.Занданшатар ШУТИС-ийн захирал Т.Намнан, бүрэлдэхүүн сургуулийн удирдлагууд их сургуулийн сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын чиглэлээр хэрэгжүүлж буй ажлуудаа танилцуулсан юм.

АНУ-ын ЭСЯ-тай хамтран “Америкт суралцагчаа” хөтөлбөр сурталчилгааны өдөрлөг зохион байгуулагдлаа

АНУ-ын Засгийн газрын санхүүжилттэй хэрэгждэг бакалаврын оюутнуудад зориулсан Глобал ЮГРАД, SUSI хөтөлбөрүүдийг танилцуулах өдөрлөгийг АНУ-ын ЭСЯ-тай хамтран 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр ШУТИС-ийн хичээлийн VIII байрны 12 давхарт зохион байгууллаа. Уг өдөрлөгөөр оюутнуудад доорх мэдээллийг хүргэв.



- Бакалаврын 1, 2, 3-р курсийн оюутнуудад зориулсан нэг семестрийн, бүрэн тэтгэлэгт [Глобал UGRAD хөтөлбөр](#)
- Бакалаврын 1, 2, 3-р курсийн эмэгтэй оюутнуудад зориулсан 5-6 долоо хоногийн зуны, бүрэн тэтгэлэгт [Манлайллын SUSI хөтөлбөр](#)
- Залуу мэргэжилтнүүдэд зориулсан АНУ-д магистрын зэрэг эзэмшээд ирэх боломжийг олгодог, бүрэн тэтгэлэгт [Фулбрайтын Оюутны хөтөлбөр](#)
- Америкт суралцах сонирхолтой сурагч нарт үнэ төлбөргүй зөвлөгөө өгдөг Америкийн боловсролын зөвлөгөөний төв болох [EducationUSA хөтөлбөр](#)
- Англи хэл сурах үнэ төлбөргүй [онлайн хичээлүүд](#)
- Америкт суралцах зорилготой иргэдэд зориулсан F-1 визний танилцуулга, г.м

Төгсөгч оюутныг мөшгөх судалгаа

БШУЯ-ны гаргасан ДБ мэдээний загварт тохируулж зарим өөрчлөлтийг оруулж нэгтгэлийг өөрчилсөн байна. ДБУМС-д тухайн судалгааг оруулж, түүнээс ДБ35, ДБ36 гаргаж ажиллаж байна. *Дээд боловсролын сургалтын өмчийн бүх хэлбэрийн байгууллага нь жил бүрийн 2 сарын 25, 7 сарын 25, -ны дотор Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад дээд боловсролын удирдлагын мэдээллийн системд шивэн илгээх болон маягтаар ирүүлнэ/* мэдээллийг ДБУМС-д оруулахаар ДБ35, ДБ36 статистик мэдээ гаргаж байна.



График 6.1 2021-2022 хичээлийн жилийн Төгсөгч оюутны мөшгөх судалгааны үр дүн



“Оюутан цэрэг” мэргэжил олгох сургалт

МУ-ын Ерөнхийлөгчийг 2013 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 92 дугаар зарлиг “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, 2014 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн ЗГ-ын 2014 оны 40 дүгээр тогтоол “Оюутан цэрэг хөтөлбөр”, БХЯ, БСШУ-ны сайдын 2014 оны 3 дугаар сарын 05-ны өдрийн хамтарсан А/49, А/56 дугаар тушаал “МУ-ын их дээд, сургууль, коллежид суралцаж байгаа оюутан залуусыг суралцах хугацаанд нь цэргийн сургалтад хамруулж цэргийн алба хаалгах журам”, 2014 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн “Оюутан цэрэг” хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн.

Мөн ЗГ-ын 2017 оны 32 дугаар тогтоол “Оюутан цэрэг”-т цэргийн мэргэжил олгох сургалтын журам шинэчлэгдэн батлагдаж энэхүү журмын дагуу оюутан цэрэгт хамрагдах хүсэлтэй оюутны судалгааг гаргаж шаардлага хангасан оюутнуудыг Оюутан цэрэг хөтөлбөрт хамруулдаг.

ШУТИС-ийн хувьд жил ирэх тусам Оюутан цэрэг хөтөлбөрт хамрагдах оюутны тоо нэмэгдэж байна.

2020,2021 онуудад ковид цар тахалтай холбоотойгоор оюутан цэрэг хөтөлбөр хэрэгжээгүй. 2022-2023 оны хичээлийн жилд “Оюутан цэрэг” мэргэжил олгох сургалтад ШУТИС-аас 345 оюутан хамрагдсан байна.

Хүснэгт 6.13

№	Сургууль	“Оюутан цэрэг” мэргэжил олгох сургалтад хамрагдсан оюутны тоо /2023 он/
1	Барилга, архитектурын сургууль	49
2	Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль	17
3	Гадаад хэлний сургууль	1
4	Геологи, уул уурхайн сургууль	35
5	Механик, тээврийн сургууль	38
6	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	142
7	Үйлдвэрлэлийн технологийн сургууль	12
8	Хэрэглээний шинжлэх ухааны сургууль	2



9	Эрчим хүчний сургууль	49
	Нийт	345

Эрүүл мэндийн даатгал

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3-т оюутан, суралцагчдын эрүүл мэндийн даатгалд хамруулах ажлыг сургуулийн захиргаа хариуцан зохион байгуулна гэж заасны дагуу тус хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс 19 насанд хүрсэн бүх суралцагчид сарын 5500, жилийн 66000 төгрөгийн эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөх үүрэгтэй. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн салбар болон бүрэлдэхүүн сургуулийн суралцагчдын шимтгэл төлөлтийн хувийг дор харуулав.

Хүснэгт 6.14

№	Сургуулийн нэр	ЭМД-ийн шимтгэл хувиараа төлөх оюутны тоо	Он	12 сараар шимтгэл төлсөн оюутны тоо	Огт төлөөгүй	Төлөлтийн хувь
1	Барилга, Архитектурын сургууль	1720	2022	1002	357	58.20%
2	Бизнесийн удирдлага хүмүүнлэгийн сургууль	748	2022	452	128	60.40%
3	Геологи, уул уурхайн сургууль	1029	2022	609	178	59.10%
4	Гадаад хэлний сургууль	143	2022	95	18	66.40%
5	Дархан-уул аймаг дахь Технологийн сургууль	684	2022	461	103	67.30%
6	Механик тээврийн сургууль	798	2022	449	152	56.20%
7	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	1742	2022	988	270	56.70%
8	Өмнөговь аймаг дахь технологийн сургууль	33	2022	30	1	90.90%
9	Үйлдвэрлэлийн технологийн их сургууль	940	2022	564	156	60%
10	Хэрэглээний Шинжлэх Ухааны Сургууль	185	2022	110	21	59.40%
11	Эрчим хүчний сургууль	1309	2022	755	242	57.70%
12	Эрдэнэт Цогцолбор Дээд сургууль	494	2022	124	338	25.10%

Хотын соёл аян

“Хотын соёл” аяны арга хэмжээг намар, хаврын улиралд тогтмол зохион байгуулж байна. Аяны арга хэмжээг ЦЕГ, НЗДТГ, БУХС-ийн ХУС-ийн багш нар, “Соёмбо” клуб болон КНЗ хамтран зохион байгуулан ажиллав.

Тус аяны арга хэмжээ намар, хаврын улиралд 3-4 долоо хоногийн хугацаанд үргэлжиллээ. Энэ хугацаанд баруун гарын дүрэм мөрдөх 7 хоног, “Хотын соёл, стандарт”, “Гэмт хэрэг хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх” сургалтын 7 хоног, ёс зүйн 7 хоног, харилцаа хандлагын 7 хоногууд үргэлжлэн явагдлаа.




“Ёс зүйн долоо хоног” – ийн хүрээнд 2022 оныг БШУЯ-наас ёс зүйн жил болгосонтой уялдуулан соёлч, ёс зүйн зөв үйлдлийг хэвшүүлэх бичлэгүүдийг “WIZZ” клубийн оюутнууд Ариун цэврийн өрөөний соёл, Номын сангийн соёл, Vare-ны зохистой хэрэглээ, ШУТИС-ийн өлгүүрүүдийн байршил, соёл гэх 4 сэдвийн дор 4 бичлэг бэлтгэн оюутнуудад хүргэсэн.

Хаврын улиралд Соёмбо клуб Оюутан эргүүл, Орчны соёл (баруун гарын дүрэм), Харилцаа хандлагын долоо хоногоор тус тус зохион байгуулан ажилласан. Энэ хугацаанд Хичээлийн I. II. Номын сангийн байрны гадна орчин орох, гарах гарцын тэмдэглэгээ мөн шатаар өгсөх, уруудах тэмдгийг тогтоож зөв боловсон зорчих зэрэг асуудлуудад хяналт тавьж ажилласан. ШУТИС-ийн хичээлийн II байр freezond 2023 оны 03 сарын 18-ний өдрөөс 22-ний өдрүүдэд багш, ажилчид, оюутан залуус сэтгэлийн үгээ бичих талархлаа илэрхийлэх самбар байрлуулав.



Намрын улиралд хотын соёл аяны хүрээнд оюутнуудаас тулгамдаж буй асуудлын талаар судалгаа хувцасны өлгүүрийн асуудал хөндөгдсөн. Үүнээс үүдэн хувцасны өлгүүрийн байршлын зургийг оюутнуудад танилцуулан судалгаа авахад нийт 330 санал ирсэнээс 7.1 хувь нь хувцсаа өлгүүлдэг, 21.4 хувь нь төөрөөд өлгүүлж чаддаггүй, 14.3 хувь нь хичээлийн хоёр дугаар байранд хувцсаа өлгүүлдэг, 42.9 хувь нь мэдэхгүй, 14.3 хувь нь хичээлийн номын сангийн өлгүүрт дамжин өлгүүлдэг гэх судалгаа ирсэн. Үүнээс үзвэл шинэ оюутнуудад хичээлийн байруудаа төөрөхгүйгээр олох мөн хувцсаа тогтмол өлгүүлэх зэрэг олон давуу талтай болохоор харагдаж байна.




Өлгүүрийн байршил мэдэх эсэх судалгаа

2023 оны хаврын улиралд хувцасны өлгүүрийн палан зургийг хаана ямар байршилд байршуулах болон загвар газрын зургийг Whizz клубийн гишүүн Анхбаяраар хийлгэсэн бөгөөд хоёр хэмжээст зургийг гурван хэмжээст болгон хэвлэх ажлыг High tech клубийн ахлагч З.Дэлгэр клубийн гишүүдийн хамтаар гурван хэмжээст принтерээр үсэг бүрийг тус тусад нь хэвлэн нааж, үнэ өртгийн хувьд хямд зардал гарган хийлээ.



Хичээлийн I,II,VIII,Номын сан-ийн товч зураг



Хичээлийн II, VIII, Номын сангийн хувцасны өлгүүрүүдэд шинэ хичээлийн жил эхлэхэд нааж тогтоохоор бэлтгэсэн болно.

ШУТИС-ийн Хотын соёл аяны арга хэмжээг НЗДТГ-аас улсын хэмжээнд сайн туршлага болгосон.

НЗДТГ-аас Хотын стандартын анхдугаар зөвлөгөөнийг 2022 оны 11 сарын 11 нд зохион байгуулсан. Тус зөвлөгөөнд ШУТИС-ийн Хотын соёл аяны арга хэмжээг сайн туршлага болгон илтгэл тавих хүсэлт ирүүлсний дагуу ОХСҮА-ны ахлах мэргэжилтэн доктор, дэд профессор Д. илтгэл тавьж бусад Их, Дээд, ЕБС-дад туршлагаа хуваалцлаа. Тус арга хэмжээнд ШУТИС-ийн холбогдох албан хаагчид оролцлоо.



“ШУТИС-ТУР” мэргэжил сурталчлах арга хэмжээг зохион байгуулав

Тус аянд хөдөө орон нутгийн Ховд, Хэнтий, Сэлэнгэ аймгийн нийт 200 гаруй сурагчид хамрагдсан. Улаанбаатар хотын Эрдмийн өргөө цогцолбор сургууль, 40-р сургууль, Оюуны ундраа цогцолбор сургуулийн 190 гаруй сурагчдад сургууль, хөтөлбөр, элсэлтийн талаарх мэдээллүүд өгч номын сан, музей зэргийг үзүүлэв тус аяныг СБХА болон оюутны “Соёмбо” клубтэй хамтран зохион байгуулав.



Клубийн оюутнууд мэргэжил сурталчлах ажлыг ажлын төлөвлөгөөндөө тусгасны дагуу тогтмол тус ажлыг зохион байгуулдаг. Энэ удаад сайн дурын БТОК-ийн зохион байгуулсан ажлыг танилцуулъя. Үүнд Өсвөрийн зохион бүтээгчдийн лаборатори ахлах сургууль дээр очиж өөрсдийн мэргэжлийг сурталчлахаас гадна яагаад ШУТИС-г сонгох хэрэгтэй талаар илтгэл тавьсан. Элсэлтийн ерөнхий шалгалтад хэрхэн бэлдэх талаар зөвлөгөө өгсөн.

Монголын инновацийн 7 хоногийн хүрээнд “Хүүхэд залуучуудын боловсрол ба ёс зүйн хандлага: инновацийн чиг баримжаатай хөгжлийн асуудал” сэдэвт уулзалт Уулзалт семинарыг 2023 оны 6-р сарын 9-ний өдөр ШУТИС-ийн “Хурлын танхим”-д зохион байгуулав.

Тус уулзалт семинарын зорилго нь: Орчин үеийн боловсрол, шинжлэх ухаан технологи, инновацийн хөгжлийн чиг хандлага, олон улсын туршлагаас суралцах, дунд ба дээд боловсролын залгамж холбоог хангах, хүүхдийн номын сангуудын үйл ажиллагааг сурталчлан таниулах, ЕБС болон Их сургууль, байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд түлхэц үзүүлэх зорилготойгоор зохион байгууллаа. Тус арга хэмжээг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газар, Боловсрол шинжлэх ухааны яам, Шинжлэх ухаан технологийн их сургууль, “Нобелийн шагналтнууд” хүүхдийн номын сан, Монголын инновацийн холбоо ТББ хамтран зохион байгуулав.

Уулзалт семинарт Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг БЕГ-ийн захирал доктор Н.Нямдорж, ШУТИС-ийн СБХА-ны дарга доктор М.Эрдэнэтуяа, БЕГ-ийн Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, үнэлгээний хөгжлийн газрын дарга Д.Даваасүрэн, мэргэжилтэн Н.Оюунбат, ерөнхий боловсролын 82 сургуулийн төлөөллөөс захирал, менежер 30, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч 35, багш 17 оролцоо.



Уулзалт семинарыг нээж Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг БЕГ-ийн захирал доктор Н.Нямдорж үг хэллээ. Тэрээр бид аливаа асуудлыг цаасан дээр бичээд яриад явдгаас яг ингээд хийж мэдээлэл солилцох нь чухал юмаа. Иймд энэхүү арга хэмжээг нийгмийн инновац, түншлэл, хамтын ажиллагааны суурь болгон ЕБС, Их сургууль, Төр хувийн хэвшлийн байгууллагуудыг хамруулан зохион байгуулж буйдаа баяртай байгаагаа илэрхийллээ. Мөн ШУТИС-ийн СБХА-ны дарга доктор М.Эрдэнетуяа нийт оролцогчдод хандан хамтын ажиллагаагаар ирээдүйн шилдэг боловсон хүчнийг бий болгох үйл ажиллагаанд хамтран ажиллая хэмээн уриаллаа.



Уулзалт семинар хөтөлбөрийн дагуу 4 илтгэгч илтгэлээ тавьж асуулт хариултын зарчмаар явагдлаа. Үүнд

- *Английн хатан хааны сургуулийн захирал асан, боловсролын зөвлөх, доктор (PhD), профессор Грэм Хьюиттын “XXI зууны хүүхэд залуучуудын боловсрол, ЕБС-ийн хөгжлийн турилгаа” сэдэвт илтгэл.*
- *ШУТИС-ийн профессор, Монголын инновацийн холбооны гүйцэтгэх захирал, доктор (ScD), профессор Л.Оюунцэцэг Мэдлэгийн эдийн засаг, Аж үйлдвэрийн ҮҮ хувьсгал: Дээд боловсрол, хөдөлмөрийн зах зээлийн чиг хандлага сэдвээр.*



ШУТИС-ийн Сургалтын бодлого, хөтөлбөрийн албаны дарга, доктор (PhD), М. Эрдэнэтуяа ШУТИС-ийн сургалтын бодлого, үйл ажиллагаа: Сургалтын хөтөлбөр баоюутны үйлчилгээг сэдвээр - “Нобелийн шагналтнууд” хүүхдийн номын сангийн үүсгэн байгуулагч, захирал, магистр Б. Батцэцэг Хүүхдийн номын сангийн үйл ажиллагаа: Зарим туршилага сэдвээр тус тус илтгэлээ.



Уулзалт семинарын төгсгөлд ЕБС-ийн төлөөллийг ШУТИС-ийн ЭШ инновацийн төв байранд НБТ, КООСЕН ТК, Шинжлэх ухааны музей үзүүлж сургуулиа танилцуулан холбоо тогтоон цаашид хамтран ажиллах боломжуудаа ярилцлаа. Зарим сургуулийн захирлууд багш, сурагчдадаа музей үзүүлэх эхний захиалга өглөө. Ирэх хичээлийн жилээс ажлын төлөвлөгөөндөө тусгаж хамтран ажиллахаар болж байна.



Дашрамд хэлэхэд энэхүү арга хэмжээг БЕГ-аас жил бүр уламжлал болгон зохион байгуулах нь зүйтэй юм гэдэг саналыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газар тавилаа. Инноуацийн 7 хоногийг ч цаг хугацааг наашлуулан зохион байгуулах зэрэг олон асуудлууд яригдсан болно. Энэ жилийн хувьд инновацийн 7 хоногийн цаг хугацаатай уях гээд их оройтож зохион байгуулагдсан болно.



ШУТИС-ийн хувь тус арга хэмжээнд оролцсон сургуулийн захирал, төлөөлүүдтэй холбоо тогтоож хамтын ажиллагаагаа хөгжүүлэх зарим боломжийг бүрдүүллээ.

Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн 2022-2023 оны хичээлийн шинэ жилийн нээлтийн ёслолын ажиллагаа

Эрдэм номын баярын өдөр дээд боловсролын салбарын хөгжлийг манлайлан түүчээлсэн Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн 2022-2023 оны шинэ хичээлийн жилийн нээлтийн ёслолын ажиллагаа боллоо.

Нээлтийн ёслолын ажиллагаанд БШУЯ-ны ШУТБИХХЗГ-ын дарга, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн дарга Д.Баттогтох, ШУТИС-ийн захирал Т.Намнан, ШУТС-ийн захирал Д.Одгэрэл, ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулийн захирлууд болон бусад албаны төлөөлөгчид оролцсон.



Хичээлийн шинэ жилийг нээж ШУТИС-ийн захирал Т.Намнан шинээр элсэн суралцаж байгаа оюутан залууст баяр хүргэж сургалтын өндөр амжилт хүсээд, ШУТИС-ийн эрдмийн хамт олны өнгөрсөн хичээлийн жилд хийж гүйцэтгэсэн олон арван ололт амжилтуудыг дурдаж, профессор багш, зочид төлөөлөгчид, эцэг эхчүүд, оюутан, суралцагч, залууст хичээлийн шинэ жилийн баяр мэнд хүргэсэн.

“Өнгөрсөн хичээлийн жилд 3

хөтөлбөрийг АНУ-ын ACBSP (Accreditation council for business schools & programs) магадлан итгэмжлэлийн байгууллагаар магадлан итгэмжлүүлснээр олон улсад бакалаврын 10 мэргэжил, магистрын 12 мэргэжлийг магадлан итгэмжлүүлж дэлхийн боловсролын салбарт ШУТИС хүлээн зөвшөөрөгдлөө. Цахим сургалтын системээ хөгжүүлж дэвшилтэт технологиудыг сургалтад идэвхтэй хэрэглэж, их сургуулийн элсэлт, төгсөлтийн үйл ажиллагаа, шинэ элсэгчдийн хуваарь сонголтыг улсын



хэмжээнд цахим хэлбэрээр анх удаа зохион байгууллаа. Монгол улсын Төрийн өмчийн их сургуулиудын хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд харилцан кредит солилцох, их сургуулийн элсэлтийн шалгалтын олон улсын агуулга, үнэлгээг (SAT г.м.) нэвтрүүлэх, их сургуулиуд оюутнаа өөрсдөө үнэлж элсүүлдэг байх тогтолцоог бүрдүүлэх, эрдэм шинжилгээ, судалгааны нээлттэй лаборатори байгуулах, хөгжүүлэх, нэгдсэн сүлжээ бий болгох талаар

тодорхой ажлуудыг хийж хэрэгжүүлж эхлээд байна.

Нээлтийн үйл ажиллагааны үеэр Чингис Хааны эш хөргийг залах МУ-ын Ерөнхийлөгчийн зарлигийг танилцуулж, Чингис хааны эш хөргийг залах ёслол боллоо.





ШУТИС-ийн 2022-2023 оны хичээлийн жилд элссэн шилдэг элсэгчдийн төлөөлөлд “ШУТИС-ийн Захирлын нэрэмжит тэтгэлэг”-ийн батламж гардуулсан юм.



1. МТС-ийн Механик инженер хамтарсан мэргэжлээр элсэгч Д.Дашдэмбэрэл
2. МХТС-ийн Мэдээллийн технологи мэргэжлээр элсэгч Б.Мөнх-Оргил
3. ЭХС-ийн Экологийн Технологи мэргэжлээр элсэгч А.Сумьяасүрэн
4. БАС-ийн Барилгын инженерчлэл мэргэжлээр элсэгч Б.Хулан
5. МХТС-ийн Программ Хангамжийн Инженерчлэл мэргэжлээр элсэгч И.Энхтөгөлдөр

ШУТИС-ийн элсэгч оюутнууд “Оюутны тангараг” өргөж, хичээлийн шинэ жилийн анхны хонх цохисноор нээлтийн үйл ажиллагаа өндөрлөсөн юм.

MUST OPEN MIC-2023



ШУТИС-ийн дуулаачийн клубээс зохион байгуулсан “MUST Open Mic-2023” боллоо. Оюутнуудын авьяасыг дэмжих, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилготой “MUST Open Mic-2023” урлагийн аль ч төрлөөр оролцох боломжтой, авьяастай хэн бүхний өмнө нээлттэй. “MUST Open Mic-2023”-д ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулийн 23 оюутан өөрийн авьяас, чадвараа бусдад таниулан дууны төрлөөр оролцлоо. “MUST Open mic-2023”-д оролцсон, хүрэлцэн ирж сургуулиа, анги хамт

олноо дэмжсэн оюутан та бүхэнд сурлагын өндөр амжилт хүсье. Тус арга хэмжээ уламжлал болон хавар, намрын хичээлийн улирал зохион байгуулагддаг онцлогтой.

Сонгодог хөгжмийн өдөрлөг-2023

Оюутны хөгжил, соёл, үйлчилгээний алба, БуХС-ийн хүмүүнлэгийн салбар хамтран 2023 оны 05 дүгээр сарын 02-нд ШУТИС-ийн Урлаг танхимд соёл судлалын хичээл үзэж буй ШУТИС, МУИС-ийн оюутнуудын дунд сонгодог хөгжмийн өдөрлөгийг зохион байгуулсан.



Тус өдөрлөг нь 2002 оноос эхлэн ШУТИС-ийн нийт бүрэлдэхүүн сургуулийн оюутнуудын дунд явагдсаар өдгөө 21 дахь удаагаа зохиогдож байна. Энэ хугацаанд 3100 гаруй оюутнууд оролцож авьяас чадвараа сорин амжилттай зохион байгуулагджээ. Тэмцээнийг нээж БуХС-ийн хүмүүнлэгийн ухааны салбарын эрхлэгч, доктор, дэд профессор Ц.Батцэрэн, чанарын менежер, соёл судлалын багш доктор, дэд профессор Д.Наранцацрал нар мэндчилгээ дэвшүүлсэн юм



Мөн БуХС-ийн хүмүүнлэгийн ухааны салбарын ахлах багш, биет бус соёлын өвлөн уламжлагч доктор А.Ариунболд МАУД Нарийн сайхан хээр, Эр бор харцага дуугаар мэндчилгээ дэвшүүлэв.

Энэ удаагийн “Сонгодог хөгжмийн өдөрлөг-2023”-т Улсын дуурь бүжгийн эрдмийн театр дэмжин оролцон сонгодог уран бүтээлүүдийг ШУТИС-ийн оюутан залуус, хүрэлцэн ирсэн зочдоод толилуулсан юм

Тус тэмцээний зорилго нь ШУТИС-ийн оюутнуудад соёл, урлагийн мэдлэг олгох, хөгжмийн боловсролыг дээшлүүлэх, сургуулиас зохион байгуулж буй үйл ажиллагаанд улам идэвхтэй оролцоход оршино.

21 дахь удаагийн “Сонгодог хөгжим-2023” тэмцээнд 1-р байранд МУИС, 2-р байранд ШУТИС баг амжилттай оролцон өргөмжлөл дурсгалын зүйлээр шагнууллаа.



Тэмцээнд оролцогч оюутнууд Дэлхийн болон Монголын сонгодог хөгжмийн зохиолчдын уран бүтээлээс сонсон, өөрсдийн оюуны ур чадвараа сорин өрсөлдөж, ШУТИС-ийн ОХСҮА-ны мэргэжилтэн МУСТА Ц.Болдбаатар ая дуугаа өргөн, хөтлөн явууллаа.



- I шат Дэлхийн сонгодог хөгжим
- II шат Монголын сонгодог хөгжим

21 дахь удаагийн “Сонгодог хөгжим-2022” тэмцээний шүүгчээр ШУТИС, БУХС, Чанарын менежер, доктор, дэд профессор Д.Наранцацрал, УДБЭТ-ын менежер Н.Отгонжаргал, ОХСҮА-ны ахлах мэргэжилтэн, доктор, дэд профессор Д., МУИС, ШУС, Философийн тэнхимийн дэд профессор, соёл судлалын багш, доктор Б.Дэлгэрмаа нар ажиллалаа.



Оюутны хавар-2023

Оюутны дуу бүжгийн “ШУТИС-ийн залуус” чуулга
Урлагийн клубүүдийн тайлан тоглолт

Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн урлагийн клубүүдийн “Оюутны хавар-2023” тайлан тоглолт 2023 оны 5-р сарын 10-нд амжилттай болж өнгөрлөө.



Энэхүү тоглолт нь жил бүр уламжлал болон зохион байгуулагдах бөгөөд цаашид байнгын үйл ажиллагаатай ШУТИС-ийн дэргэдэх чуулгыг байгуулах зорилготой юм. Энэ удаагийн Оюутны хавар тайлан тоглолт эх орны сэдэвтэй уран бүтээлүүд эгшиглэсэн онцлогтой болж өнгөрлөө.

Энэ удаагийн тоглолтод дуулаачийн клуб, хөтлөгчийн клуб, цэнгээнт бүжгийн клуб, чөлөөт бүжгийн клуб, морин хуурын клуб, амьд хөгжмийн клуб, MUST

Comedy клубийн авьяаслаг оюутан залуус оролцон юм.




5.5. Бусад

Хурлын танхимд зохиогдсон үйл ажиллагааны тайлан 9-бсар



№	Үйл, төрөл, ажиллагааны	Хаанаас зохион байгуулсан, үйл ажиллагааг ангилбал	Удаа	Цаг
1	Лекц		39	95
2	Хурал	ШУТИС-ийн хэмжээний	14	32
		Бүрэлдэхүүн сургуулиудын	27	64
		Оюутны зөвлөл, багш	6	14
		Хамтарсан	12	42
		Эрдэм шинжилгээний	5	30
		Гадны байгууллагын	5	16
3	Уулзалт, ярилцлага	Бүрэлдэхүүн сургуулиудын	47	104
		Оюутны зөвлөл, багш	4	10
		Бусад	7	18
4	Чуулган	Эрдэм шинжилгээний	7	24
		Оюутны зөвлөл	15	95
5	Уралдаан		4	20
6	Тэмцээн	Танин мэдэхүйн	9	22
		Бусад	3	12
7	Урлагийн арга хэмжээ	Урлаг наадам	16	192
		Бүжиг	5	30
		Кино	-	-
8	Баяр ёслол	Хичээлийн жилийн нээлт	1	8
		Эрдмийн баяр	2	16
		Диплом гардуулалт	2	18
		Өдөрлөг	4	32
		Хөдөлмөр алдар	1	10
9	Бэлтгэл	Бүжиг	7	21
		Дуу	17	48
		Уралдаан тэмцээн	1	6
		Тоглолтын	18	252
10	Бусад арга хэмжээ		10	30
11	Сургалтууд		12	24
12	Клубын ажиллагаа		41	170
	Бүгд		341	1455

АРГА ХЭМЖЭЭН ХАРЬЦУУЛСАН ГРАФИК



	Лекц	Хурал	Уулзалт, ярилцлага, хичээл	Чуулган	Тэмцээн	Урлагийн арга хэмжээ	Баяр ёслол	Бэлтгэл	Бусад арга хэмжээ	Сургалтууд	Клубын ажиллагаа
Удаа	39	69	58	22	12	20	44	45	10	12	41
Цаг	95	198	132	119	34	224	337	321	30	24	170




8-р байрны хурлын танхимд зохиогдсон үйл ажиллагааны тайлан


9-бсар

№	Үйл, ажиллагааны төрөл	Хаанаас зохион байгуулсан , үйл ажиллагааг ангилбал	Удаа	Цаг
1	Лекц		10	20
2	Хурал	ШУТИС-ийн хэмжээний	11	22
		Бүрэлдэхүүн сургуулиудын	6	14
		Хамтарсан	3	12
		Эрдэм шинжилгээний	5	18
		Гадны байгууллагын	3	16
3	Уулзалт, ярилцлага	Бүрэлдэхүүн сургуулиудын	9	18
		Оюутны зөвлөл, багш	1	3
		Бусад	5	11
		Ярилцлага	-	-
		Өдөрлөг	3	15
4	Бусад арга хэмжээ		4	8
5	Сургалтууд		9	27
	Бүгд		69	184

АРГА ХЭМЖЭЭН ХАРЬЦУУЛСАН ГРАФИК




	Лекц	Хурал	Уулзалт, ярилцлага, хичээл	Бусад арга хэмжээ	Сургалтууд
Удаа	10	28	18	4	9
Цаг	20	82	47	8	27





ШУТИС-ийн веб сайтын Оюутан хэсгийн шинэчлэл

Алба нэгж салбар сургууль	IC card хэвлэсэн
ГХС	2
КООСЕН	4
МТС	40
БАТС	43
ҮТС	87
БУХС	25
Захиргаа	8
Нийт	209



Оюутан болон багш ажилдагсдын IC картын хэвлэх ажил



ЗУРГААДУГААР БҮЛЭГ

НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ



ЗУРГАА. НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

6.1. ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН НОМЫН САН

ШУТИС-ийн Шинжлэх ухаан, технологийн номын сан /ШУТНС/ нь 2022-2023оны хичээлийн жилд номын сангийн орчин нөхцөлийг сайжруулах, дахин төлөвлөх уншигчдын тав тухтай орчин бүрдүүлэх, профессор багш, судлаачдад хандсан шинэлэг үйлчилгээг нэвтрүүлэх, номын санч, үйлчилгээний ажилчдын мэргэжил, мэдлэгийг дээшлүүлэхэд анхаарч сургуулийн удирдлага, бүрэлдэхүүн сургууль, төрийн болон хувийн хэвшлийн дотоод, гадаадын байгууллагуудтай хамтран ажиллалаа.

ШУТИС-д ISO 21001:2018 стандарт нэвтрүүлсэн, номын сангийн үйлчилгээний программ өөрчлөгдсөнтэй холбогдуулан тус хичээлийн жилд каталогич, номзүйчийн ажлын байрыг нэмэгдүүлэх, ажлын байрны тодорхойлолт, тайлан мэдээ, бичиг хэрэг хөтлөх үйл ажиллагааг шинэчлэх ажлуудыг амжилттай хийлээ.

Номын сангийн техник хангамжийг шинэчлэх, орчин нөхцөлийг дахин төлөвлөх ажлын хүрээнд төсөл боловсруулан захиргаа, бүрэлдэхүүн сургууль, гадны байгууллагуудтай танилцуулж ажиллалаа. МУИС-тай хамтран гурван төслийг амжилттай хийж тодорхой үр дүнд хүрч байна. ҮТС-ийн дизайны оюутнуудын төгсөлтний ажлыг номын сангийн уншлагын танхим, нэгжүүдийн интерьер зургийг хийлгэсэн. Мөн Голомт банкнаас нийгмийн хариуцлагын хүрээнд 460 мкв бүхий оюутны уншлагын танхимыг тохижуулах төсөл хэрэгжүүлж эхэлж байна. Орчин нөхцөлийг сайжруулах ажлын хүрээнд номын санч, үйлчилгээний ажилтнуудын хувцас солих өрөөг тохижуулан, коридор, уншлагын танхимуудын гэрэлтүүлгийг сайжруулан 100 лед гэрэл суурилуулсан. Эрдэм шинжилгээний уншлагын танхимыг ШУТИС-ийн захиргаа, ЭШТГ, МехТС, ҮТС-тай хамтран академич Ч.Авдайн нэрэмжит танхим болгон тохижуулж нээсэн.

2022-2023оны хичээлийн жил номын сангийн нэг цэгийн үйлчилгээний үйл ажиллагааг шинэчлэн, өргөжүүлж багш нарын ном сурах бичиг, бичиг хэрэг, хэвлэх, хувилах, үйлчилгээнээс гадна бичиг хэргийн барааны төрөл, тоог нэмэгдүүлсэн. Мөн цар тахлын улмаас таслалдаад байсан мерчиндайз бүтээгдэхүүнийг сэргээн хэрэглэгчийн хүртээл болголоо. Ном сэргээн засварлах танхимын үйл ажиллагааг эрчимжүүлэн профессор багш нарт шаардлагатай, зохиогчийн эрх нь шийдвэрлэгдсэн ном сурах бичгийг сэргээн засварлах үйлчилгээ явууллаа.

Шинжлэх ухаан, технологийн төв номын сан нь Засгийн газрын шийдвэр, ШУТИС-ийн Захирлын тушаалын дагуу номын сангийн бие даалтын уншлагын танхимыг тохижуулан 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдрөөс 2023 оны 05 дугаар сарын 30-ны хооронд 24 цагийн уншлагын танхимын үйлчилгээг туршилтаар ажиллуулсан. 24 цагийн үйлчилгээний бэлтгэл ажлын хүрээнд уншигчдад тав тухтай, орчин нөхцөл бүрдүүлэхийн тулд бие даалтын танхимд завсар үйлчилгээ, тохижилтын ажлыг хийж, уншигчдад танхимаар үйлчлүүлэх заавар, зөвлөмж, санамж гарган танилцуулсан. Тус үйлчилгээнд өдөр, шөнийн хоёр ээлжээр 3 ахлах мэргэжилтэн, 3 номзүйч, 16 номын санч, 2 үйлчилгээний ажилтан ажиллаж, 610 оюутанд үйлчилгээ үзүүлсэн байна.

2022-2023хичээлийн жилээс эхлэн номын сангийн баазыг Lib4U программаас Коха систем рүү хөрвүүлэн /21.11 хувилбар/ үйлчилгээнд нэвтрүүлж эхлээд байгаа ба программын хөрвүүлэлтийг хянах, засварлах ажил хийгдсээр байна.

Тус хичээлийн жилд соёлын хөтөлбөрт ажлыг төлөвлөгөөний дагуу явуулж зохиогч уншигчийн уулзалт, нээлттэй хаалганы өдрүүд, гадаад дотоодын хэвлэлийн газруудын хэвлэмэл болон цахим номын үзэсгэлэн, худалдаа, оюутан уншигчдад зориулсан олон талт ажлуудыг тус тус зохион явууллаа.



Төрийн өмчийн 6 их сургуулиудын (ШУТИС, МУИС, ХААИС, АШУУИС, МУИС, МУБИС) хамтран ажиллах санамж бичигт тусгагдсан оюуны өмчийг хамгаалах, бүтээлийн хуулбарлалтыг шалгах, номын сангийн нэгдсэн системийг нэвтрүүлж, хамтран ашиглах зэрэг ажлууд хэрэгжиж, багш, оюутан, судлаачид харьяалал харгалзахгүй номын сангаар харилцан үйлчлүүлж байна.

Номын санчдын мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг тогтмолжуулж, 3 номын санч СУИС-ийн номын санчаар суралцан, 1 номын санч магистрын зэргийг амжилттай хамгаалсан. Мөн Соёлын яамны “Жуух бичиг”-ээр 3 номын санч, “Соёлын тэргүүний ажилтан” цол тэмдгээр 3 номын санч тус тус шагнагдлаа.

Номын сангийн уншлагын танхимуудыг номын санчид өөрсдийн санаачилгаар цэцэгжүүлэн ногоон орчинд уншигчдад соёлч, боловсон, нээлттэй мэдээллийн орчинд үйлчилгээ үзүүлэхийг эрхэмлэн ажиллалаа.

6.2. НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ФОНД БҮРДҮҮЛЭЛТ


2022-2023оны хичээлийн жилд 92,303 уншигчдад 178,768 ном олгож, 12,125 удаагийн номын хугацаа сунгалт хийж ажилласан байна. Үүнээс ШУТНС 57,276 уншигчдад 124,054 ном олгож үйлчилгээ үзүүлсэн байна.

ШУТНС нь нийт 339,986 ширхэг ном, материалын сан хөмрөгтэй. (Хүснэгт 6.1) (Зураг 6.1.) ШУТНС нь “Номын сангийн үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг үндэслэн сан хөмрөгийн баяжилт хийгддэг.

2022-2023оны хичээлийн жилд бүрэлдэхүүн сургуулиуд техник технологийн сургалт, судалгааны нийт 588 нэр төрлийн 5,255 ширхэг номыг 159.6 сая төгрөгөөр худалдан авч, сан хөмрөгийн бүрдүүлэлт хийж уншигчдын хүртээл болгож байна. (Хүснэгт 6.2) Мөн олон улсын EBSCO мэдээллийн сангийн хандалтын судалгааг үндэслэн Инженерчлэлийн багцын эрхийг үргэлжлүүлэн 25.2 сая төгрөгөөр авч судлаачдад эрдэм шинжилгээ, судалгаа хийх боломжийг бүрдүүлж ажиллалаа.

Хүснэгт 6.1

Номын сан	Номын тоо	Эзлэх хувь
ШУТТөв номын сан	161,689	47.6
БУХС-ийн номын сан	27,160	8.0
ДаТС-ийн номын сан	41,706	12.3
МехТС-ийн номын сан	29,720	8.7
МХТС-ийн номын сан	30,847	9.1
ЭрТДС-ийн номын сан	34,280	10.1
ӨмТДС-ийн номын сан	1,262	0.4
ҮТС-ийн уншлагын танхим	13,322	3.9




Зураг 6.1. Бүрэлдэхүүн сургуулийн номын сангийн сан хөмрөгийн судалгаа

ШУТНС-ийн сан хөмрөгийн бүтцийн судалгаа



Зураг 6.2. Шинжлэх ухааны чиглэлийн ном, материалын үзүүлэлт



Зураг 6.3. Оноор болон хэлээр ном, материалын үзүүлэлт




ШУТНС-ийн сан хөмрөгийн бүрдүүлэлтийн тоон үзүүлэлт

Хүснэгт 6.2

№	ШУТТ номын сан	2022 он			2023 оны эхний хагас жил		
		Нэр төрөл	Тоо ширхэг	Үнэ /төг/	Нэр төрөл	Тоо ширхэг	Үнэ /төг/
1	ШУТТНС	12	100	4,690,000	56	1048	31,118,380
2	БАТС-ийн номын сан	25	216	10,790,000	1	10	778,000
3	БУХС-ийн номын сан	49	262	9,974,310	11	69	2,938,000
4	ДаТС-ийн номын сан	34	85	2,470,200	2	8	532,000
5	МехТС-ийн номын сан	29	388	11,641,700	4	165	3,045,000
6	МХТС-ийн номын сан	258	334	91,768,263	3	27	1,001,000
7	ЭртДС-ийн номын сан	45	599	16,315,965	5	106	2,480,000
	НИЙТ ДҮН:	452	1,984	147,650,438	82	1,433	41,892,380

Тус хичээлийн жилд мэргэжлийн ном, сурах бичиг, гарын авлагын эргэлтийн судалгааг шинжлэх ухааны чиглэлээр номын сангийн Коха программаас гаргалаа.


Ном, сурах бичгийн эргэлт



Зураг 6.4. Ном, сурах бичгийн эргэлтийн судалгаа



Гарын авлагын эргэлт



Зураг 6.5. Гарын авлагын эргэлтийн судалгаа

6.3. САНГИЙН АВТОМАТЖУУЛАЛТ, ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ

ШУТИС-ийн номын сан тус хичээлийн жилд уламжлалт үйлчилгээг цахим үйлчилгээтэй хослуулан явууллаа. Хичээлийн жилийн сүүлийн 3 сарын тайлангаар номын сангийн цахим бүтээлийн санг байршуулсан сайтад нийт 9,705 уншигч /давхардсан тоогоор/ нэвтэрч, 2,536 судалгааны бүтээл /давхардсан тоогоор/ үзэж, судалсан байна.

Цахим сан хөмрөгийн баяжилт: ШУТИС-ийн цахим сангийн тоо тасралтгүй өссөөр байгаа ба шинэ төгсөгчдийн судалгааны ажил /магистр, докторын зэрэг горилсон бүтээл/, эрдэм шинжилгээний бичиг, уншигчдын хэрэгцээ шаардлага, зохиогчдын хүсэлтийн үндэслэн мэргэжлийн ном, сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний бичгүүдийг цахим хэлбэрт шилжүүлэн ШУТИС-ийн электрон каталогид оруулж вэб сайт, фэйж хуудсаараа дамжуулан уншигчдад мэдээлэл хүргэж, таниулан сурталчилсаар байна.

2023 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс EBSCO олон улсын мэдээллийн сангийн Engineering Source багцын эрхийг 1 жилийн хугацаатай авч уншигчдадаа үйлчилгээ үзүүлж байгаа ба тус мэдээллийн санд 3,000 гаруй ном, сэтгүүл, эрдэм шинжилгээний өгүүлэл байгаагаас 1,600 гаруйг нь бүрэн эхээр /full text/ үзэх боломжтой, инженерийн салбарын мэргэжилтнүүд, судлаачдад зориулсан шилдэг сан юм.

Мэдээллийн сангуудыг ашигласан байдал: Шинжлэх Ухаан Технологийн төв номын сан нь эрдэм шинжилгээ сургалтын үйл ажиллагааг дэмжих, мэргэжлийн ном



сэтгүүлийн цахим нөөцийг бүрдүүлэх зорилгоор техник, технологийн чиглэлийн үнэтэй болон үнэгүй олон улсын мэдээллийн сангийн эрх авахыг авч ашигласаар байна.

EBSCO мэдээллийн сангаас ШУТИС-ийн уншигчдад зориулан 2023 оны захиалгын урамшуулал болгон дараах боломжуудыг олгосон.

1. eBook collection багцын 10,600 гаруй цахим (ОА) номыг бүрэн эхээр нь татаж авч судлах боломжтой.
2. "EBSCO eBooks Engineering Core Collection" багцын 7,000 гаруй номыг үзэх туршилтын эрхийг 2023 оны 3 дугаар сарын 6-ны өдрөөс эхлэх 4 дүгээр сарын 30-ны өдрийг дуустал нээж ШУТИС-ийн сүлжээнээс үнэгүй ашиглуулсан.

Мөн дараах сангуудыг онлайн үйлчилгээндээ ашиглалаа. Үүнд:

- Research4life: <https://login.research4life.org/> ARDI /Шинжлэх ухаан, техник/, AGORA /Хөдөө аж ахуй/, OARI /Байгаль орчин/, GOALI /Хууль/, HINARI /Эрүүл сэнд/ гэсэн 5 үндсэн мэдээллийн сантай. Мөн тус сангаар дамжуулан Scopus-ыг төлбөргүйгээр ашиглах боломжтой байдгаараа давуу талтай. Мэдээллийн санг ашиглахын тулд ШУТИС-ийн тусгай нэвтрэх нэр, нууц үгийг ашиглана.
- Springer Nature: <https://link.springer.com/> Олон улсын мэдээллийн сан. Тус сангаас 2,550 гаруй ном, 2,730 гаруй сэтгүүлээс мэдээлэл татаж авч үзэх боломжтой.

ШУТИС-ийн сүлжээнээс үнэгүй ашиглах боломжтой болон туршилтаар ашигласан сангууд:

- DOAJ: <https://doaj.org/> Directory of Open Access journals нь дэлхийн 80 орчим хэлээр 19,500 орчим эрдэм шинжилгээний сэтгүүлээс 8,908,194 эрдэм шинжилгээний бүтээлүүдийг онлайнгаар, үнэ төлбөргүй үзэх боломжтой.
- DOAB: <https://www.doabooks.org/> Directory of Open Access Books нь дэлхийн 408 эрдэм шинжилгээний салбарын хэвлэлийн газрын 68,000 орчим номуудыг онлайнгаар, үнэ төлбөргүй орж үзэх, татаж үзэх боломжтой. Тус платформд Монгол улстай холбоотой 18 ном одоогоор бүртгэлтэй байдаг.
- Theses: <https://theses.ai/> Тус платформд 40,100 гаруй эрдмийн зэрэг хамгаалсан дипломууд онлайнгаар үнэ төлбөргүй орж үзэх, татаж авах боломжтой.
- Dimensions: <https://app.dimensions.ai/discover/publication> Open access filter ашиглан 45 сая гаруй мэдээллээс хайлт хийж, үзэх боломжтой.
- Hindawi: <https://www.hindawi.com/> Үнэгүй эрдэм шинжилгээний сэтгүүлүүдийг үзэх боломжтой.
- Writefull: <https://www.writefull.com/writefull-for-word> Англи хэлний алдааг засварлах программ хангамжийн үйлчилгээний **Premium** эрхийг 2023 оны 2 дугаар сарын 15-ны өдрөөс 3 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл 1 сарын хугацаанд үнэ төлбөргүй, туршилтаар ашигласан.



- Sage: <https://journals.sagepub.com/> 1999 оноос хойш хэвлэгдсэн 1,200 орчим нийгэм, хүмүүнлэг болон бусад шинжлэх ухааны салбаруудын эрдэм шинжилгээний сэтгүүлүүдийн бүтээлийг сургалт, судалгааны зорилгоор 2023 оны 6 дугаар сарын 30-ыг дуустал ашиглах туршилтын эрхийг нээлгэн ашиглаж байна.

Бүтээлийн хуулбарлалт, түүний хэрэглээ: ШУТИС-ийн ахисан түвшний төгсөгчдийн судалгааны ажлыг 2022 оны хаврын улирлаас эхлэн батлагдсан түр журмын дагуу бүтээлийн хуулбарлалт шалгах программ /plagscan/-аар шалгаж эхэлсэн ба тус ажлыг ШУТТНС хариуцан ажиллаж байна.

Plagscan программыг 2023 оны 4 дүгээр сараас эхлэн Turnitin программаар шинэчлэн бүтээлийн хуулбарлалт шалгаж эхэлсэн.


Программ шинэчлэгдсэний улмаас Plagscan программын баазад оруулсан мэдээлэл ашиглагдах боломжгүй болсон. Turnitin программын баазад ШУТИС-ийн номын сангийн судалгааны бүтээлийн цахим санд байгаа 5,611 магистр, 522 докторын зэрэг горилсон бүтээлийг (Хүснэгт 6.3) (Зураг 6.б.) оруулах ажлыг богино хугацаанд зохион байгуулж 2023 оны хаврын улирлын төгсөгчдийн судалгааны ажлыг амжилттай шалгах (Хүснэгт 6.4) (Зураг 6.7.) боломжийг бүрдүүлэн ажиллалаа.

Бүтээлийн хуулбарлалт шалгах Turnitin программын баазад оруулсан файлын тоо

/2023 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар/

Хүснэгт 6.3

Цахим судалгааны бүтээлийн тоо		
1	БАС	475
2	БУХС, БАТС	1,628
3	ГУУС	842
4	МехТС	304
5	МХТС	431
6	ҮТС	585
7	ХШУС	402
8	ЭХС	515
9	ДаТС	181
10	ГХС	108
11	ЭрТС	69
12	НБТ /ОУДБСТ/	71
13	Диссертаци	522
НИЙТ		6,133




Зураг 6.б. Turnitin программын баазад оруулсан файлын тоо



**Бүтээлийн хуулбарлалт шалгасан оюутны тоо
/2022-2023оны хичээлийн жилийн хаврын төгсөлт/**

Хүснэгт 6.4

Сургууль	Хуулбарлалт шалгасан оюутны тоо	Хуулбарлалтын нийт хувь	Дундаж хувь
БАС	11	110	10
БАТС	89	1,709	19.2
БУХС	7	63	9
ГУУС	23	342	14.9
ДаТС	9	210	23.3
МехТС	7	100	14.3
МХТС	4	9	2.3
ЭХС	18	169	9.4
ҮТС	6	37	6.2
НБТ	1	21	21
НИЙТ	175	2,770	15.8



**Зураг 6.7. Судалгааны
бүтээлийн давхцалын
дундаж хувь**

Бүтээлийн хуулбарлалт шалгах программ шинэчлэгдсэнтэй холбогдуулан гарын авлагыг шинээр хийж веб сайт болон youtube-д байршуулан, нийгмийн сүлжээний хэрэгслээр дамжуулан судлаачдад таниулан сурталчилсан.

ШУТТНС-аас гаргасан видео танилцуулга, заавар, гарын авлага:



1. ШУТИС-ийн номын сангийн мэдээллийн санг хаанаас, хэрхэн үзэх вэ? - https://youtu.be/9_9rB1YHif0
2. ШУТИС-ийн номын сангийн цагийн хуваарь - https://youtu.be/j5q7VV6oW_Q
3. ШУТИС-ийн номын сангаар хэрхэн үйлчлүүлэх вэ?/МУИС, МУБИС, АШУУИС, ХААИС, СУИС/- <https://youtu.be/uwGmJMNJT5Q>
4. ШУТИС-ийн номын сангаас цахим материал хэрхэн үзэх вэ? - <https://youtu.be/qeZxtkKp2AQ>
5. ШУТИС: Бүтээлийн хуулбарлалт хэрхэн шалгах вэ? Танилцуулга /Plagscan/ - <https://youtu.be/0uX23EtxWQU>
6. ШУТИС-ийн Бүтээлийн хуулбарлалт шалгах гарын авлага /Turnitin-2023/ - <https://youtu.be/Aug7wrb2j8U>

6.4. НОМЫН САНГИЙН СОЁЛЫН ХӨТӨЛБӨРТ АЖИЛ:

ШУТИС нь уламжлал ёсоор хичээлийн жилийн эхэнд шинээр элсэгчдэд зориулан “Нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгуулснаас гадна улсын хэмжээнд зохион байгуулагддаг “Үндэсний номын баяр”-ын үйл ажиллагаанд оролцлоо. Арга хэмжээний хүрээнд ШУТИС-ийн профессор багш нарын бүтээлийг худалдан борлуулах, таниулан сурталчлах зорилгоор “Үндсэн сурах бичиг”, Инженерийн лавлах бүтээлүүдээр номын үзэсгэлэн гаргалаа. (Зураг 6.8.)



Зураг 6.8. “Үндэсний номын баяр”-ын үзэсгэлэн, худалдаа

ШУТИС-ийн Гадаад хэлний сургуулийн 30 жилийн ой, Соёлын бүтээлч сарын хүрээнд Англи хэлний тэнхимийн профессор, багш нарын бүтээлийг таниулан сурталчлах зорилготой “Зохиогч-Уншигчийн уулзалт”-ыг хамтран зохион байгуулав. (Зураг 6.9.)



Зураг 6.9. “Зохлогч-Уншигчийн уулзалт”

Мөн Доктор Ph.D, профессор Э.Нинжгаравын албан ёсны эрхтэйгээр эх хэлнээ орчуулан гаргасан "Хөрсний механик ба буурь суурь" (Зураг 6.10.), Г.Баясгалангийн "Өвчнөө хайрла" (Зураг 6.11.), Б.Гэрлээгийн "Монгол дахь буддын сүм хийд лам хуврагуудын аж байдал, лам нар, ард иргэдийн харилцааны тухай тэмдэглэл" (Зураг 6.12.), Д.Даваасамбуу, Ж.Лхамсүрэн, Ж.Дамдинжав нарын хамтарсан бүтээл болох "Ашигт малтмалын боловруулалтын технологийн минералог ба тэдгээрийн үйлдвэрлэл, хэрэглээ" (Зураг 6.13.) номын нээлт, хэлэлцүүлгүүдийг тус тус зохион байгууллаа.



Зураг 6.10. "Хөрсний механик ба буурь суурь" номын нээлт



Зураг 6.11. "Хөрсний механик ба буурь суурь" номын нээлт



Зураг 6.12. “Монгол дахь буддын сүм хийд лам хуврагуудын аж байдал, лам нар, ард иргэдийн харилцааны тухай тэмдэглэл” номын нээлт



Зураг 6.13. Ашигт малтмалын боловсруулалтын технологийн минералог ба тэдгээрийн үйлдвэрлэл, хэрэглээ” номын нээлт

ШУТИС нь “Дэлхийн номын өдөр”-ийг 13 дах жилдээ тэмдэглэн өнгөрүүлсэн ба уг өдрийг угтаж олон талт арга хэмжээ зохион байгуулж, тэмдэглэн өнгөрүүлдэг уламжлалтай. Энэ өдрийн хүрээнд УТС-ийн ахмад багш ШУТИС-ийн УТС-тай хамтран Ахмад багш Ш.Жадамбаагийн "Хоол зохицохуй-2" номын нээлт (Зураг 6.14.), Зохиолч, найруулагч, жүжигчин А.Миеэгомбын "Соёлын зөөлөн хүч" чөлөөт ярилцлага, уулзалт (Зураг 6.15.), “Дэлхийн номын өдөр боломжийг ашигла”, "Номын үзэсгэлэн", танин мэдэхүйн “АХА” асуулт, хариултын тэмцээн зэрэг арга хэмжээг (Зураг 6.16.) уншигчдын дунд зохион байгуулсан.



Зураг 6.14. "Хоол зохицохуй-2" номын нээлт



Зураг 6.15. "Соёлын зөөлөн хүч" чөлөөт ярилцлага, уулзалт



Зураг 6.16. “Дэлхийн номын өдөр”-ийн хүрээнд явагдсан үйл ажиллагаа



ДОЛОО. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХАНГАМЖ, САНХҮҮ БҮРТГЭЛ, ДОТООД АУДИТ, БАЙР АШИГЛАЛТ

7.1. ТӨСӨВ

Монгол Улсын 2023 оны төсвийн төслийг боловсруулахад баримталсан зарчмын хүрээнд ШУТИС-ийн төсвийн төслийг боловсруулахад дараах зарчмуудыг баримтлав.

- Их сургуулийн төсвийн орлогын ихэнх хувийг бүрдүүлдэг сургалтын төлбөр, эрдэм шинжилгээний орлогоос гадна хуулиар олгогдсон үндсэн бус орлогын эзлэх хувийг нэмэгдүүлэхэд орлогын даалгавар өгч, захиргаа, бүрэлдэхүүн сургууль, нэгжүүд орлогыг нэмэгдүүлэх тал дээр санаачилгатай ажиллах,
- ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургууль, нэгжийн сургалтын үйл ажиллагааны зардлыг сургалтын болон түр сургалтын төлбөрийн орлоготой уялдуулж, бүрэн даалгах,
- Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах,
- Төрийн хэмнэлтийн хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5 дугаар заалтад заасны дагуу он дамнасан сургалтын төлбөрийн авлагыг бууруулах чиглэлээр гаргасан албан даалгаврын хэрэгжилтийн хангахад 2022 оны хагас жилийн санхүүгийн тайланд тусгагдсан сургалтын төлбөрийн авлагын 15 хувиар бууруулах,
- Хөрөнгө оруулалтын үр өгөөжийг дээшлүүлэх, хийгдэх ажлуудыг ажлуудыг аль болох оюутны сурах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэхэд чиглүүлж хийх,
- Урсгал засвар, худалдан авалтын зарим ажлуудыг төсөл, гэрээт ажлын, түр сургалтын орлогоос санхүүжүүлэх,
- Төрийн хэмнэлтийн хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.4 заалтаар бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх зэргээр бичгийн цаас, хувилагчийн хорны зардлыг хэмнэх,
- Төсвийн хариуцлагыг дээшлүүлэх, төсвийг үр ашигтай захиран зарцуулах,

ШУТИС-ийн 2023 оны төсөвт ШУТИС-2030 стратеги төлөвлөгөөний холбогдох зорилт болон нийгэм, эдийн засаг, бусад цаг үеийн хүчин зүйлүүдийг харгалзан үзэж дараах зардлуудыг тусгасан болно. Үүнд:

- Оюутны сурах орчин нөхцөлийг сайжруулах ажлын хүрээнд Хичээлийн II байрны 1-5 давхрын засварын ажил буюу оюутны чөлөөт орчин бий болгоход 200.0 сая төгрөг,
- Хичээлийн II байрны 1-5 давхрын ариун цэврийн өрөөний засварт 280.0 сая төгрөг,
- Хичээл, сургалт, лабораторийн зардалд 2,155.1 сая төгрөг төсөвлөсний 880.3 сая төгрөгийн түр сургалтаас олж буй орлогоос зарцуулахаар,
- Төрийн хэмнэлтийн хуулийн дагуу бичгийн цаас, принтерийн хорны зардлыг бууруулж ШУТИС-ийн хэмжээнд сургалтын бичиг хэргийн зардалд 127.4 сая төгрөг,
- Цар тахлаас шалтгаалан дотоод, гадаадын магадлан итгэмжлэлд хөтөлбөрөө магадлуулах ажил хийгдээгүй байсан учраас ирэх оны төсөвт хугацаа дуусаж байгаа хөтөлбөрүүдийг сунгуулах, сургалтын хөтөлбөрийн чанарын баталгаажуулалт хийхэд 5 хөтөлбөрийг гадаадын магадлан итгэмжлэлд оруулах, хугацааг сунгуулахад зориулан 290.0 сая төгрөг,



- ШУТИС-2030 стратеги төлөвлөгөөний 5.8 дахь зорилт, багшийг дэмжих бодлого, үйл ажиллагааны хүрээнд 299.0 сая төгрөг,
- Бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдээс 2023 оны төсөвт 4.2 тэрбум төгрөгийн ажлыг хийхээр төсөвлөсний 416.9 сая төгрөгийн ажлыг эрдэм шинжилгээ, түр сургалтын орлого болон түүний үлдэгдэл 5 хувиар хийхээр тус тус төсөвлөсөн.

Бүрэлдэхүүн сургуулиудаас ирүүлсэн төсвийн төслийг 2 үе шаттай хэлэлцэн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2022 оны 12 сарын 22-ны өдрийн 09 тоот тогтоолоор нийт 67,8 тэрбум төгрөгийн орлогын, 67,5 тэрбум төгрөгийн зардлын, үүнээс 193 нэрийн 4,6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт, худалдан авалтын төлөвлөгөөг батлуулсан.

2023 оны төсвийн төсөөлөл, 2023-2024 оны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгах төсөл арга хэмжээний санал болон урсгал зардлыг нэмэгдүүлэх арга хэмжээнд холбогдох маягтын дагуу санал боловсруулан илгээсэн.

Мөн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 53 тоот тогтоолоор 3,6 тэрбум төгрөгт багтаан үндсэн хөрөнгө олж авах зөвшөөрөл авсан.

1. ШУТИС-ийн хэмжээнд худалдан авах үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд ил тод, нээлттэй зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавих, гүйцэтгэлийн явцыг хянан шалгаж, баталгаажуулах, удирдлагыг мэдээ, мэдээллээр хангах

Худалдан авах ажиллагааны цахим системд батлагдсан төлөвлөгөөг оруулж, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Сангийн яамаар батлуулан худалдан авах ажиллагааг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах” хуулийн хүрээнд зохион байгуулан ажиллаж байна. 2022-2023 оны хичээлийн жилд нийт 2,8 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгө өөрийн хөрөнгийн санхүүжилтээр худалдан авсан байна.

2022 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХУДАЛДАН АВАЛТЫН ТАЙЛАН /сая төг/

Д/Д	Тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөвт өртөг	Гэрээний дүн	Тайлбар, тодруулга
1	БАС1Барилга архитектурын сургуулийн Хэрлэнгийн полигоны дадлагын байрны засварын ажил	60.00	-	Санхүүжилт бүрдээгүй.
2	БАС2Барилга архитектурын сургуулийн Т-106, Е-116в, Т-307, 8-507, 2-101, 5-129 тоот лабораториудын засвар	45.00	-	Хэмнэлтийн хуулийн дагуу
3	БАС7Барилга архитектурын сургуулийн сургалтын тоног төхөөрөмжийн худалдан авалт	65.00	55.54	Ай Ти Зон ХХК
4	ГХС4Гадаад хэдний сургуулийн суурин болон зөөврийн компьютер, техник хэрэгслийн худалдан авалт	50.50	45.78	“Би Си Ти” ХХК
5	ГХС5Гадаад хэдний сургуулийн проектор, олон үйлдэлт принтер, техник хэрэгслийн худалдан авалт	23.00	11.87	Хэмнэлтийн хуулийн дагуу



6	ГУУС1Геологи, уул уурхайн сургуульд чулуулгийн физик бутлалтын лаборатори байгуулах	63.30	-	Төсөвт өртөг хүрээгүй.
7	ГУУС6Геологи, уул уурхайн сургуулийн хичээлийн 2-р байрны 1-р давхрын 00 өрөөний засварын ажил	70.00	65.66	ЦАГААН УДАМ ХХК
8	ГУУС7Геологи, уул уурхайн сургуулийн 2-25 өрөөний засварын ажил	30.00	28.80	"Жойнт саксесс"ХХК
9	ГУУС13Геологи, уул уурхайн сургуулийн цахим сургалтын ухаалаг дэлгэцийн худалдан авалт	50.00	42.58	"Инфинит блоу скай" ХХК,1. 2022.10.14 2. 2022.10.31 2 удаа зарласан оролцогчгүй
10	ДТС4Дархан-Уул аймаг дахь технологийн сургуулийн аж ахуйн барилгын дээврийн засварын ажил	50.00	49.17	СИ БИ ДИ СИ ХХК
11	ДТС7Дархан-Уулаймаг дахь технологийн сургуулийн Оюутны байранд ор 70 ш	40.00	34.65	Онцгой өргөө ХХК
12	МехТС1Механик, тээврийн сургуулийн барилга, байгууламжийн засварын ажил	180.00	195.53	"Улс туяарах"ХХК, 2022-04-15-ны өдрийн А/122 тоот ШУТИС-ийн захирлын тушаалаар нэмж зардал гаргах нь багтагдсан
13	МехТС2Механик, тээврийн сургуулийн лаборатори,тоног төхөөрөмж, зүтгүүрийн худалдан авалт	40.00		Ай Ти Зон ХХК, 1. 2022.10.04-нд зарласан, оролцогчгүй 2. 2022.10.31-нд багц болгон зарласан
14	МХТС3Мэдээлэл, холбооны технологийн сургуулийн компьютерын лабораториудад шинэчлэл хийх	125.00		
15	МХТС4Мэдээлэл, холбооны технологийн сургуулийн малтмидиа лаборатори, олон сувгийн лабораторийн компьютерын худалдан авалт	38.00		
16	МХТС5Мэдээлэл, холбооны технологийн сургуулийн симуляцийн лаборатори /ХСалбар/ тоног төхөөрөмжийн худалдан авалт	32.00	244.13	Саммит Компьютер Технологи ХХК, багцалсан
17	МХТС6Мэдээлэл, холбооны технологийн сургуулийн Firewall-ын төхөөрөмжийн худалдан авалт	27.80		
18	МХТС19Мэдээлэл, холбооны технологийн сургуулийн суурин болон зөөврийн компьютерын худалдан авалт	46.00		
19	МХТС8Мэдээлэл, холбооны технологийн сургуулийн номын сан, уншлагын танхимуудын урсгал засвар	40.00		Хэмнэлтийн хуулийн дагуу
20	МХТС10Мэдээлэл, холбооны технологийн сургуулийн идэвхтэй сургалтын анги танхимын засвар /401 409/	27.00		Хэмнэлтийн хуулийн дагуу
21	ҮТС3Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн компьютер,проектор, принтерийн худалдан авалт	35.40	31.28	Дижитал сервис ХХК
22	ХШУС1Хэрэглээний шинжлэх ухааны сургуулийн компьютерын худалдан авалт	30.00	28.24	Ай Ти Зон ХХК
23	ЭХС1Эрчим хүчний сургуульд цахилгаан системийн шинжилгээ судалгааны лаборатори байгуулах	80.00	78.58	Бодит чадал ХХК



24	ЭХС6Эрчим хүчний сургуулийн суурин компьютерын худалдан авалт	32.40	26.18	Би Си Ти ХХК
25	ХЕБАС2ШУТИС-ийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургуулийн таблет компьютерын худалдан авалт	33.70	17.75	Би Си Ти ХХК
26	НБТЗНээлттэй боловсролын төвийн студийн бичлэгийн тоног төхөөрөмжийн худалдан авалт	43.90	-	Хэмнэлтийн хуулийн дагуу
27	Зах1Хичээлийн I байр лабораторийн барилгыг холбосон шатны хонгилын засварын ажил	60.00	58.13	СИ БИ ДИ СИ ХХК
28	Зах2Хичээлийн I байрны зүүн, баруун жигүүрийн туслах шатны хонгилын засварын ажил	44.00	43.69	"Мангал констракшн"ХХК
29	Зах3Хичээлийн I байрны 1-р давхрын хойд жигүүрийн ариун цэврийн өрөөг нэгтгэн засах засварын ажил	40.00	39.16	ТЕРМОМАСТЕР ХХК
30	Зах4Хичээлийн I байрны төв болон хойд гол шатны хонгилын засварын ажил	75.00	-	Хэмнэлтийн хуулийн дагуу
31	Зах5Хичээлийн I байрны 3 давхрын урлаг заалны үүдний вестибюлийн засварын ажил	44.00	43.84	"Бий энд Ватст"ХХК
32	Зах6Хичээлийн I байрны 2 давхрын хойд жигүүрийн Геологийн салбарын коридорын засварын ажил	78.00	-	Хэмнэлтийн хуулийн дагуу
33	Зах9Хичээлийн I байрны 2-р давхрын коридорын засварын ажил	70.00	58.73	"Энгүүн сондор"ХХК
34	Зах10Хичээлийн I байрны гадна довжоо, тэргэнцэртэй хүний налуу замын засварын ажил	50.00	-	Хэмнэлтийн хуулийн дагуу
35	Зах12Хичээлийн I байрны 3,4-р давхрын вестибюлийн засварын ажил	160.00	-	Хэмнэлтийн хуулийн дагуу
36	Зах13ШУТИС-ын төв шатны хонгилын засварын ажил	69.00	68.35	ЭНГҮҮН СОНДОР ХХК
37	Зах14Хичээлийн ҮП байрны цонхны засварын ажил	80.00	80.00	"Этүгэн жим"ХХК
38	ЭХС2Эрчим хүчний сургуулийн автомат удирдлагын онол автоматжуулалтын лаборатори өргөтгөх тоног төхөөрөмжийн худалдан авалт	39.10	38.50	Оюу энд интернэшл ХХК, СЯам хүсэлт 2022.03.31 нд №5/195 тоот
39	ЭХС3Эрчим хүчний сургуульд нам хүчдэлийн цахилгаан сүлжээ, тоног төхөөрөмж, удирдлагын лабораторийн виртуаль стенд нийлүүлэх нийлүүлэгчийн сонгон шалгаруулах хэмнэлт төслийн цахилгааны хэрэглээний зардлыг бууруулахад шаардлагатай тоног төхөөрөмжийг нийлүүлэх, суурилуулах	30.00	-	СЯам хүсэлт 2022.10.14 нд №1/626 тоот Гэрээ хийгдээгүй "Эрчим төв" шалгарсан
40	ХЕБАС3 ХЕБАС4ШУТИС-ийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургуульд ухаалаг самбар, суурин компьютер нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах	45.00	-	СЯам хүсэлт 2022.10.14 нд №1/626 тоот Гэрээ хийгдээгүй Санхүүжилт хаагдсан
41	МеХС8Механик тээврийн сургуулийн салбар, танхим, сургалтын албанд компьютерын худалдан авалт	30.00	-	Би Си Ти ХХК, СЯам хүсэлт 2022.10.14 нд №1/626 тоот
42	Зах6Хичээлийн XII байрны Геотехнологийн лабораторийн засварын ажил	98.58	95.15	ТЕРМОМАСТЕР ХХК, 2022-04-15 ны өдрийн А/122 тоот ШУТИС-ийн захирлын



				тушаалаар нэмж зардал гаргах нь батлагдсан СЯам хүсэлт 2022.03.15 нд А/147 тоот
43	ҮТС1Дээврийн засвар	60.00	58.59	"Бат нягт арвижих"ХХК
44	ШУТНС3ШУТИС-ийн төв номын сангийн уншлагын танхимд эд хогшил нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах	33.00	-	СЯам хүсэлт 2022.10.14 нд Гэрээ хийгдээгүй Санхүүжилт хаагдсан
45	адаад хэлний сургуульд "Ерөнхийлөгчийн илгээлт 2100" бэлтгэл хөтөлбөрийн хүрээнд батлагдсан сургалтын анги, танхим тохижуулах ширээ, сандлын худалдан авалт	25.00	18.76	2023 онд
46	Гадаад хэлний сургуульд "Ерөнхийлөгчийн илгээлт 2100" бэлтгэл хөтөлбөрийн хүрээнд батлагдсан компьютер бусад тоног төхөөрөмжийн худалдан авалт	55.90	55.08	2024 онд
47	Барилга, архитектурын сургуульд хэрэгжиж буй төсөлд батиметрийн (усны ёроол) хэмжилтийн лабораторийн тоног төхөөрөмж нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах	79.30	79.30	Тав Ди Ворлд ХХК
48	ШУТНС2Төв номын сангийн албан хэрэгцээнд болон үйлчилгээнд ашиглах зориулалтаар тоног төхөөрөмж нийлүүлэх	24.00	18.54	Би Си Ти ХХК
49	Ерөнхийлөгчийн бэлтгэл хөтөлбөрийн сургалт явуулахад багш нарт шаардлагатай зөврийн компьютер нийлүүлэх	60.00	66.00	Саммит Компьютер Технологи ХХК
50	Хичээлийн 7 байрны цахилгааны хүчдэлийг тогтворжуулахад шаардлагатай тоног төхөөрөмж	50.00	49.68	Фарос интернэшнл ХХК, 2022.04.15-ний А/122 тоот тушаалаар
51	ШУТИС-ийн Нээлттэй боловсролын төвд хэрэгжүүлж буй АРТЕСТ-хүмүүнлэгийн ухааны боловсролын хөтөлбөрийг Европын СТЕМ арга, хэрэгслүүдээр сайжруулах төслийн тоног төхөөрөмж нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах	108.03	-	Зарласан оролцогчгүй тендер
52	Оюутны 5 дугаар байрны 430 тоот өрөөний засварын ажлын гүйцэтгэгчийг ШУТИС/202202006	32.00	32.00	"Мөнхгүүр"ХХК, 2022-04-15 ны өдрийн А/122 тоот ШУТИС-ийн захирлын тушаалаар нэмж зардал гаргах нь батлагдсан
53	ШУТИС-ийн Хичээлийн I байрны 119 тоот багш нарын өрөө, Хичээлийн III байрны 404 тоот лабораторийн засварын ажил	92.54	88.25	ЗАЛУУР ӨРГӨӨ ХХК, 2022 оны 06 дугаар сарын 29 ний А/215 тоот ШУТИС-ийн захирлын тушаалаар зардал батлах тухай
54	Койка төслөөс МХТС-ийн барилгын засвар	2,036.60	2,036.60	
	Дүн	5,027.05	3,984.11	



ШУТИС-ийн 2023 оны төсвийн төсөл хэлэлцэхтэй холбогдон томилогдсон ажлын хэсэгт ажиллаж, 8 бүрэлдэхүүн сургуулийн хөрөнгө оруулалт, урсгал зардлын төсвийн төсөлтэй газар дээр нь очиж танилцсан.

2022-2023 онд БНСУ-ын Олон Улсын Хамтын Ажиллагааны байгууллага болох КОЙКА-гаас хэрэгжүүлж буй “ШУТИС, МХТС-ийн чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд Хичээлийн 6 дугаар байрны гадна фасад, үүдний гонх засвар, дотор засал, дотор гэрэлтүүлэг, хүчит төхөөрөмж, холбоо дохиолол, тоног төхөөрөмж нийлүүлэх, суурилуулах гэсэн 4-н ажлуудын гүйцэтгэлийг шалгаж, хүлээн авч, холбогдох данс бүртгэлд тусгасан.

Боловруулсан төсвийн жагсаалт

д/д	шифр	нэгжийн нэр	Төсвийн нэр	Нийт төсөвт өртөг /сая төг/
2022 он				
1	ШУТИС-төсөв 21-12	ЗА	ШУТИС Хичээлийн 1-р байрны саравч, гонх, үүдний засварын ажлын хяналтын төсөв	50.20
2	ШУТИС-төсөв 21-13	ЗА	ШУТИС Хичээлийн 2-р байрны үүдний засварын ажлын хяналтын төсөв	70.01
3	ШУТИС-төсөв 21-14	ЗА	ШУТИС Спорт заалны хаявчны хэсэгчилсэн болон агуулахын засварын ажлын	19.09
Дүн				139.31
2023 оны эхний хагас жил				
4	ШУТИС-төсөв 22-20	ҮТС	ШУТИС. ҮТС Хичээлийн 1-р байрны "Голомт банк" байрлаж байсан өрөөнүүдийн засварын ажлын хяналтын төсөв	144.03
5	ШУТИС-төсөв 23-01	ҮТС	ШУТИС. ҮТС Хичээлийн 1-р байрны "Голомт банк" байрлаж байсан өрөөнүүдийн засварын ажлын хяналтын төсөв	99.94
6	ШУТИС-төсөв 23-02	ГХС	ШУТИС. ГХС Хичээлийн 2-р байрны 2.3 давхрын коридори болон гадна хана дотор талаас нь дулаалах ажлын хяналтын төсөв	47.88
7	ШУТИС-төсөв 23-03	МХТС	ШУТИС. МХТС Хичээлийн 6-р байрны номын сангийн уншлагын танхим, коридор, шатны хонгилын засварын ажлын хяналтын төсөв	56.81
8	ШУТИС-төсөв 23-04	МХТС	ШУТИС. МХТС Хичээлийн 6-р байрны 1,2,3 давхрын коридорын шал солих, гэрэл солих, шатны хонгилын засварын ажлын хяналтын төсөв	29.37
9	ШУТИС-төсөв 23-05	ЗАХ	ШУТИС. Оюутны 3-р байрны 1 давхрын урд жигүүрийн ариун цэврийн өрөөний засварын ажлын хяналтын төсөв	12.48
10	ШУТИС-төсөв 23-06	ЗАХ	ШУТИС. Оюутны 3-р байрны урд жигүүрийн шатны хонгилын засварын ажлын хяналтын төсөв	38.38
11	ШУТИС-төсөв 23-07	ЗАХ	ШУТИС. Оюутны 3-р байрны хойд жигүүрийн шатны хонгилын засварын ажлын хяналтын төсөв	47.26
12	ШУТИС-төсөв 23-08	БАТС	ШУТИС. БАТС Хичээлийн 5-р байрны 119 тоот Эрдэм шинжилгээний уншлагын танхимын засварын ажлын хяналтын төсөв	63.35
13	ШУТИС-төсөв 23-09	БуХС	ШУТИС. БУХС Хичээлийн 5-р байрны спорт заалны их засварын ажлын хяналтын төсөв	125.06
14	ШУТИС-төсөв 23-10	ЭХС	ШУТИС. Хичээлийн 2-р байрны 0,2,3,4,5-р давхруудын ариун цэврийн өрөөнүүдийн засварын ажлын хяналтын төсөв	280.62
15	ШУТИС-төсөв 23-11	ЗА	ШУТИС. Оюутны 3-р байрны 1.2-р байрны цахилгааны засварын ажлын хяналтын төсөв	98.09
16	ШУТИС-төсөв 23-12	ГХС	ШУТИС. ШУТТНС-ийн 406 тоот өрөөний засварын ажлын хяналтын төсөв	85.11



17	ШУТИС-төсөв 23-13	ЗА	ШУТИС.Хичээлийн 2-р байрны 1.2.3.4.5-р давхруудын цахилгаан, шатны хонгилын засварын ажлын хяналтын төсөв	38.00
18	ШУТИС-төсөв 23-14	БАТС	ШУТИС.БАТС Хичээлийн 5-р байрны 119 тоот Эрдэм шинжилгээний уншлагын танхимын засварын ажлын хяналтын төсөв	30.33
19	ШУТИС-төсөв 23-15	ДаТС	ШУТИС Дархан -Уул аймаг дахь Технологийн сургуулийн оюутны дотуур байрны халаалтын систем хэсэгчилсэн засвар,	87.60
20	ШУТИС-төсөв 23-16	ЗА	ШУТИС-ийн Төв номын сангийн 203 тоот /Оюутны холбоо/ засварын ажил	13.64
21	ШУТИС-төсөв 23-17	ЗА	ШУТИС.Оюутны хөгжил, соёл үйлчилгээний 327.1,327.2, коридорын засварын ажил	19.42
19	ШУТИС-төсөв 23-18	ЗА	ШУТИС. Хичээлийн 8-р байрны 307 тоотын дулаалгын засварын ажил	13.33
20	ШУТИС-төсөв 23-19	ЗА	ШУТИС. Хичээлийн 1-р байрны 216 тоотын дулаалгын засварын ажил	5.17
			Дүн	1,336
			Нийт дүн	1,475

7.2. ӨМЧ ХӨРӨНГИЙН ТАЙЛАН, МЭДЭЭ ГАРГАХ, МЭДЭЭЛЛИЙН САНГ БҮРДҮҮЛЭХ, УДИРДЛАГЫГ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай өмчийг эзэмшүүлэх гэрээ-2022 байгуулж, өмнөх “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ний хавсралт мэдээлэл, тайланг хянаж, нэгтгэн 97 онооны үнэлгээтэй дүгнүүллээ.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын төрийн өмчийн программын ашиглалт, цахимд оруулсан мэдээллийн иж бүрдлийг хянаж шалган, уг мэдээллийг үндэслэн бүрэлдэхүүн сургууль нэгжүүдийн өмч эзэмшүүлэх гэрээг дүгнэж баталгаажууллаа. 2021 оны жилийн эцсийн тооллогын дүнгээр актлагдах хөрөнгийн жагсаалтыг нэгтгэж хянан, ШУТИС-ийн өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцүүлэн зохих газарт хандаж, нийт 1,073,8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах зөвшөөрлийг авч тогтоолын биелэлтэд хяналт тавьж, биелэлтийг холбогдох төрийн захиргааны байгууллагад хүргүүлсэн.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 64 тоот тогтоолыг үндэслэн ШУТИС-ийн захиргаа болон бүрэлдэхүүн сургууль, нэгж тус бүр дээр Захирлын болон бүрэлдэхүүн сургуулийн захирлын тушаалаар тооллогын комисс байгуулагдан ажиллалаа. Бүрэлдэхүүн сургуулийн тооллогын комисст заавар, зөвлөгөө өгөх, тооллогын материалыг хүлээн авч шалгах, нэгтгэх зэрэг ажлууд хийсэн.

ТӨБЗГ-ийн төрийн өмчийн хөрөнгийн бүртгэлийн umch.sgov.mn программд ШУТИС-ийн хөрөнгийн бүртгэл, хөдлөлийн тайланг бүрэн зөв оруулж, цахим тайланг хуулийн хугацаанд илгээсэн.

Байгууллагын эзэмшил ашиглалтад буй авто тээврийн хэрэгслийн лавлагааг “Авто тээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын улсын нэгдсэн мэдээллийн систем дахь мэдээлэлтэй тулгаж, зөрүүтэй мэдээллийг холбогдох дүрэм журмын хүрээнд өөрчлөлтийг тухай бүр хийлгэж, үнэн зөв болгосон.

2021, 2022 оны ТӨБЗГ-тай хийсэн түрээсийн гэрээний дагуу бүрэлдэхүүн сургууль нэгжүүдийн 22 хувь хүн, албан байгууллагын түрээсэлсэн нийт 1004 м2 талбайн сонгон шалгаруулалт, гэрээний биелэлтийг хянаж, гэрээний сунгалтуудыг хийж, түрээсийн төлбөрийн тооцоог хянан баталгаажуулж ажиллав. 2022 оны сүүлийн хагас жилд 2,608,2 сая төгрөгийн, 2023 оны эхний хагас жилд 107,2 сая төгрөгийн сургууль хооронд шилжих хөрөнгийн хөдөлгөөнийг шийдвэрлэв.



7.3. САНХҮҮ, БҮРТГЭЛ

ШУТИС-ийн хэмжээнд тайлант хугацаанд нийт 1560 орон тоотой ажилласнаас үндсэн орон тооны профессор, багш 846 /54 хувь/ ажилласан байна. Нийт оюутны тоо: Хавар, намрын улиралд идэвхтэй сурч буй сонголт хийсэн бакалавр 12014, магистр 1447, доктор 104, МСҮТ, КТКоллеж, ахлах сургуулийн 1,400 суралцагч суралцсан байна.

2022 онд ШУТИС-ийн бүрэлдэхүүний 11 сургууль, НБТөв, 2 Ахлах сургууль, КТКоллеж, Захиргаа, Эрдэм шинжилгээ инновацын газар, ҮТС-ийн МСҮТөв Хэвлэлийн газар, Шинжлэх ухаан технологийн номын сан, Төвлөрсөн зэрэг нийт 21 нэгж, 4 оюутны байр үйл ажиллагаа явуулж тайлан баланс гаргасан. Монгол улсын Сангийн сайдын 388 тоот санхүүгийн тайлан, тодруулга, 55 тоот эдийн засгийн ангилал болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн Санхүүгийн байдлын тайлан (СТ-1А), үр дүнгийн тайлан (СТ-2А), мөнгөн гүйлгээний тайлан (СТ-3А), цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (СТ-4А), санхүүгийн тайлангийн тодруулга (ТБСТТ-1-12) зэргийг гарган өгч, ШУТИС-ийн удирдлагын нэгдсэн системийн дэд хэсэг болох УСНББОУС-д нийцсэн санхүүгийн мэдээллийг боловсруулах “U-Finance 3.0” санхүүгийн программаар санхүүгийн тайланг нэгтгэсэн. 2022 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газар аудит хийгдсэн.

7.4. САНХҮҮГИЙН ТАЙЛАН БАЛАНС

ШУТИС-ийн Санхүүгийн тайлан баланс/сая. төг/

Хүснэгт 8.4

БАЛАНСЫН ЗҮЙЛ	2021 он	Дүнд эзлэх хувь	2022 он	Дүнд эзлэх хувь	Өөрчлөлт	
					Абсолют	Харьцан-гуй
Мөнгөн хөрөнгө	24,785.1	16.2	23,779.5	14.5	(1,005.7)	(4.1)
Авлага	4,228.7	2.8	3,606.4	2.2	(622.3)	(14.7)
Урьдчилгаа	799.2	0.5	900.0	0.5	100.8	12.6
Бараа материал	2,217.5	1.4	2,312.1	1.4	94.6	4.3
НИЙТ ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	32,030.5	20.9	30,598.0	18.6	(1,432.5)	(4.5)
Үндсэн хөрөнгө	121,327.6	79.1	133,882.1	81.4	12,554.5	10.3
НИЙТ ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	121,327.6	79.1	133,882.1	81.4	12,554.5	10.3
НИЙТ ХӨРӨНГӨ	153,358.1	100.0	164,480.2	100.0	11,122.0	7.3
Богино хугацаат өр төлбөр	10,584.8	6.9	12,347.2	7.5	1,762.4	16.7
Урт хугацаат өр төлбөр	52.2	0.0	47.2	0.0	(5.0)	(9.5)
НИЙТ ӨР ТӨЛБӨР	10,637.0	6.9	12,394.5	7.5	1,757.4	16.5
Засгийн газрын оруулсан капитал/ЗГСан/	30,567.5	19.9	30,687.5	18.7	120.0	0.4
Хуримтлагдсан үр дүн	51,047.3	33.3	60,297.4	36.7	9,250.1	18.1



Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	61,106.3	39.8	61,100.8	37.1	(5.5)	(0.0)
НИЙТ ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧ	142,721.1	93.1	152,085.7	92.5	9,364.6	6.6
ӨР ТӨЛБӨР БА ЭЗНИЙ ӨМЧИЙН НИЙТ ДҮН	153,358.1	100.0	164,480.2	100.0	11,122.1	7.3


Эргэлтийн хөрөнгө мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгаа, бараа материалаас бүрдэж байна. Мөнгөн хөрөнгө 1,005.7 сая төгрөгөөр, авлага 622.3 сая төгрөгөөр буурч, урьдчилгаа 100.8 сая төгрөгөөр, бараа материал 94.6 сая төгрөгөөр өссөн дүнтэй гарсан байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 23.8 тэрбум төгрөг, үүнээс 11.6 тэрбум төгрөг нь сургалтын төлбөр, оюутны байр, гэрээт ажил, төслийн урьдчилж орсон орлого байна. Урьдчилж орсон орлого нь өнгөрсөн оны мөн үеэс 2.2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Мөнгөн үлдэгдэл 23.8 тэрбум төгрөгөөс урьдчилж орсон орлогыг хасаж тооцоноор шилжих үлдэгдэл нь 12.2 тэрбум төгрөг байна. Шилжих үлдэгдэл өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 3.2 тэрбум төгрөг буюу 20.6%-иар буурсан байна. Балансын бүтцийг харахад нийт хөрөнгө 164.5 тэрбум төгрөг хүрч өнгөрсөн оноос 11.1 тэрбум төгрөг буюу 7.3%-иар өсжээ. Нийт хөрөнгөд эргэлтийн хөрөнгө 18.6%, эргэлтийн бус хөрөнгө 81.4%, өр төлбөр эзний өмчид өр төлбөр 7.5%, эзний өмч 92.5% тус тус эзэлж байна.

Тайлант жилийн эцэст үндсэн хөрөнгийн хэмжээ 133,882.1 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 12.6 тэрбум төгрөгөөр нэмэгджээ. Тайлант онд үндсэн хөрөнгийн нэмэгдсэн эх үүсвэр:

- Өөрийн хөрөнгөөр 5.4 тэрбум төгрөг,
- Үнэ төлбөргүй авсан 17.6 тэрбум төгрөг (БНСУ-ын Койка олон улсын байгууллага, “Инженер, технологийн дээд боловсрол” төсөл, “Оюу толгой” ХХК, “Санко Маркетинг Монголиа” ХХК зэрэг гадаад, дотоодын байгууллага, хувь хүн, төслийн хөрөнгөөр)
- Бусад 14.9 тэрбум төгрөг / ШУТИС-ийн Захирлын 2022 оны 05-р сарын 30-ны өдрийн А/177, 06-р сарын 24-ний өдрийн А/211, 12-р сарын 23-ны өдрийн А/354 тоот тушаалаар бүрэлдэхүүн сургууль, нэгж хооронд 12.7 тэрбум төгрөг, ТӨБЗГ-ын тогтоолоор баланснаас балансад шилжүүлсэн авсан 1.1 тэрбум төгрөг, данс хооронд 3,250.0 мянган төгрөг, газрын хэмжээ нэмж бүртгэсэн 120.0 сая төгрөг, дахин үнэлж, үнэ шинэчилсэн 671.3 сая төгрөг/

Үндсэн хөрөнгийн нэмэгдсэн хэмжээг эх үүсвэрээр нь харуулбал:



ТӨБЗГ-ын 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 447 тоот тогтоолын дагуу анхны өртгөөрөө элэгдлээ нөхсөн 1294 нэрийн 2,324.9 сая төгрөгийн үнэ бүхий хөрөнгийн ашиглалтын хугацааг сунган 671,3 сая төгрөгөөр үнийг шинэчлэн тогтоож, санхүүгийн тайланд тусгав. Мөн ТӨБЗГ-ын 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн А-1/2142 албан тоот, 11 сарын 22-ны өдрийн 533 тогтоолын дагуу 1,073.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасаж, данс хооронд шилжүүлсэн 3,250.0 мянган төгрөг, ТӨБЗГ-ийн тогтоолоор баланснаас балансад шилжүүлэн өгсөн 51.9 сая төгрөгийн хөрөнгө зэргийг тус тус хасч, санхүүгийн тайланд тусгав.

Нийт үндсэн хөрөнгийн 133.9 тэрбум төгрөг нь цэвэр үндсэн хөрөнгө, 40.8 тэрбум төгрөг нь хуримтлагдсан элэгдэл байна.

Авлагын талаар:

Авлага урьд оны мөн үетэй харьцуулахад 14.7 хувь буюу 622.3 сая төгрөгөөр буурсан байна. Сургалтын төлбөрийн авлага 475.3 сая төгрөгөөр, хувь хүнтэй холбоотой авлага 166.4 сая төгрөгөөр тус тус буурч бусад авлага 143.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Тайлант оны жилийн эцсийн байдлаарх авлагыг төрлөөр харуулбал:

- Сургалтын төлбөрийн авлага хувиараа төлөх оюутны авлага 2,367.4 сая төгрөг
- Боловсролын зээлийн сангийн эрсдэлийн 5% авлага 321.7 сая төгрөг
- Байгууллагатай холбоотой 677.7 сая төгрөг
- Хувь хүнтэй холбоотой 207.2 сая төгрөг
- Сургууль хоорондын тооцооны 32.5 сая төгрөгийн авлага тус тус байна.

Дараах хүснэгтэд бүрэлдэхүүн сургууль тус бүрийн тайлант жилийн эцсийн авлагыг харуулав.

БҮРЭЛДЭХҮҮН СУРГУУЛИУДЫН АВЛАГА (сая төгрөгөөр)



Сургууль	2021 он	2022 он	Үүнээс. Сургалтын төлбөрийн авлага			Өөрчлөлт		Нийт авлага д эзлэх хувь
			Эрсдэлийн сан 5%	Хувиараа төлөх	Дүнд эзлэх хувь	Тоогоор	Хувиар	
БАС	460.5	244.6	47.6	189.0	96.7	(215.9)	46.9	6.8
БАТС	492.3	445.1	20.2	424.9	100.0	(47.2)	9.6	12.3
БУХС	372.4	294.9	28.5	212.4	81.7	(77.5)	20.8	8.2
ГХС	87.1	74.9	4.5	15.6	26.8	(12.2)	14.0	2.1
ГУУС	400.2	549.9	29.2	321.8	63.8	149.7	(37.4)	15.2
ДТС	319.5	288.6	36.0	243.0	96.7	(30.9)	9.7	8.0
МехТС	285.9	194.3	31.6	99.0	67.2	(91.6)	32.0	5.4
МХТС	321.4	244.1	41.2	186.0	93.1	(77.3)	24.1	6.8
ҮТС	169.8	212.8	31.3	180.7	99.6	43.0	(25.3)	5.9
ХШУС	70.3	13.3	5.9	7.4	100.0	(57.0)	81.1	0.4
ЭХС	335.4	223.9	38.2	169.5	92.8	(111.5)	33.2	6.2
АС	206.0	182.5		114.6	62.8	(23.5)	11.4	5.1
КТК	95.2	88.3		88.3	100.0	(6.9)	7.2	2.4
ДТС-АС	11.6	17.2		17.2	100.0	5.6	(48.3)	0.5
НБТ	151.4	105.1	7.5	97.6	100.0	(46.3)	30.6	2.9
ҮТС-МСҮТ	27.4					(27.4)	100.0	-
ХГазар	29.1	29.1			-	-	-	0.8
ШУТНС		18.0			-	18.0		0.5
ЭШИГ	109.6	119.2			-	9.6	(8.8)	3.3
Захиргаа	14.8	11.4			-	(3.4)	23.0	0.3
Төвлөрсөн	268.7	248.9			-	(19.8)	7.4	6.9
ДҮН	4,228.6	3,606.1	321.7	2,367.0	74.6	(622.5)	14.7	100.0

Орлогын талаар:

ОРЛОГО (сая төгрөгөөр)

Хүснэгт 8.5

Үзүүлэлт	2021 он	2022 он		Өөрчлөлт		Нийт орлогод эзлэх %	2022/2021
		Төсөв	Гүйцэт-гэл	Тоогоор	Хувиар		
Шилжих үлдэгдэл		10,441.70	5957.4	-4,484.30	57.1	9.6	
I. Үндсэн үйл ажиллагааны орлого	41,337.40	47,226.70	45,788.50	-1,438.20	97	73.4	110.8
Сургалтын төлбөрийн орлого	40,329.00	43,612.20	42,460.80	-1,151.40	97.4	68.1	105.3
Түр сургалтын орлого	1,008.40	3,614.50	3,327.70	-286.8	92.1	5.3	330




II. Эрдэм шинжилгээний орлого	2,927.40	4,560.40	4,303.50	-256.9	94.4	6.9	147
III. Туслах үйл ажиллагааны орлого	2,952.10	5,021.30	5,596.10	574.8	111.4	9	189.6
Оюутны байрны орлого	408.8	1,042.50	849.9	-192.6	81.5	1.4	207.9
Түрээсийн орлого	102.1	85	104.8	19.8	123.3	0.2	102.7
Бусад орлого	2,441.20	3,893.80	4,641.40	747.6	119.2	7.4	190.1
IV. Төсвөөс санхүүжих	609.0	682.0	700.3	18.3	102.7	1.1	115
Тайлант үеийн орлого	47,825.90	57,490.40	56,388.50	-1,101.90	98.1	100	117.9
Нийт орлогын дүн		67,932.10	62,345.90	-5,586.20	91.8		

Тайлант онд нийт орлого 62,345. сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарч, урьд оны мөн үеийн гүйцэтгэлээс 17.9 хувь буюу 8.6 тэрбум төгрөгөөр өсөж, төсвийн орлогын гүйцэтгэл 91.8 хувьтай байна. Өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлтэй харьцуулахад:

- Сургалтын төлбөрийн орлого- 5.3 хувь буюу 2,131.8 сая төгрөгөөр
- Түр сургалтын орлого -3.3 дахин буюу 2,319.3 сая төгрөгөөр
- Эрдэм шинжилгээний орлого – 41.2 хувь буюу 1.3 тэрбум төгрөгөөр
- Бусад орлого 47.0 хувь буюу 1,376.1 сая төгрөгөөр
- Оюутны байрны орлого 2.2 дахин буюу 441.1 сая төгрөгөөр
- Түрээсийн орлого 2.7 хувь буюу 2.7 сая төгрөгөөр
- Бусад орлого 1.9 дахин буюу 2,200.2 сая төгрөгөөр
- Төсвөөс санхүүжих орлого 15 хувь буюу 91.3 сая төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй гарчээ.

ШУТИС-ийн Бүрэлдэхүүн нэгжүүдийн төсвийн орлогыг гүйцэтгэлтэй нь харьцуулан харуулбал:



Тайлант онд БАС, ГУУС, ГХС, НС, ХГ-иуд орлогын төлөвлөгөөг биелүүлж, БУХС, МехТС, МХТС, ҮТС, ЭХС-иудын орлогын биелэлт 90-98.7 хувийн биелэлттэй байна. Бусад сургууль, нэгжийн хувьд 90 хувиас доош хувийн гүйцэтгэлтэй байна.

Зардлын талаар:



2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн ШУТИС, Санхүү, хөрөнгө оруулалт эрхэлсэн захирлын 4/24 тоот албан бичгийн хүрээнд дараах зардлыг бууруулан ажиллав.

- Бууруулсан зардал: шагнал урамшууллын зардал, зочин төлөөлөгч хүлээн авах зардал, гадаад мэргэжилтний зардал, гадаад томилолтын зардал, багшийг дэмжих зардал, мэргэжил дээшлүүлэх зардал, ойн арга хэмжээний зардал, багш ажилтны арга хэмжээний зардал, оюутны үйлчилгээний зардал Нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардал, дотоод албан томилолтын зардал, мэдээлэл сурталчилгааны зардал, сургалтын бичиг хэргийн зардал, захиргааны бичиг хэргийн зардал
- Хэмнэсэн зардал: Гэрэл цахилгаан, түлш халаалт, цэвэр бохир усны зардал

2022 ОНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ, ГҮЙЦЭТГЭЛ (сая төгрөгөөр)

	2021 он	2022 он		Урьд оноос		Төсвөөс	
		Төсөв	Гүйцэт-гэл	тоогоо р	хувиар	тоогоо р	хувиар
Сургалттай холбоотой шууд зардал	30,403.80	39,910.90	35,565.80	5,162.00	117	4,345.10	89.1
Шууд бус зардал	13,783.40	16,915.40	15,910.30	2,126.90	115.4	1,005.10	94.1
Оюутны үйлчилгээний зардал	164.6	559.3	343.5	178.9	208.7	215.8	61.4
Эрдэм шинжилгээ, инновацын үйл ажиллагааны зардал	3,345.10	5,915.30	4,821.80	1,476.70	144.1	1,093.50	81.5
Хөрөнгө оруулалт	1,329.50	3,973.50	3,807.20	2,477.70	286.4	166.3	95.8
Зарлагын дүн	49,026.40	67,274.40	60,448.60	11,422.20	123.3	6,825.80	89.9

Бүтцээр урьд оны гүйцэтгэлтэй харьцуулан авч үзвэл:

- Сургалттай холбоотой шууд зардал 5,162.0 сая төгрөгөөр
- Шууд бус зардал 2,126.9 сая төгрөгөөр
- Оюутны үйлчилгээний зардал 178.9 сая төгрөгөөр
- Эрдэм шинжилгээ, инновацын үйл ажиллагааны зардал 1,476.7 сая төгрөгөөр
- Хөрөнгө оруулалтын зардал 2,477.7 сая төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй гарсан байна.

Цар тахлын улмаас 2021 онд хичээл сургалтын үйл ажиллагаа цахимаар явагдсантай холбоотойгоор зардал бага гарсан байсан 2022 онд хичээл сургалтын үйл ажиллагаа танхимаар явагдсан, багш, ажилтны цалинг 2 удаа нэмэгдүүлсэн зэргээс шалтгаалсан байна.

Батлагдсан төсөвтэй харьцуулбал сургалттай холбоотой шууд зардал 4,345.1 сая төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй гарч үүний дотор:


- Цалин нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 2,331.3 сая төгрөг
- Хичээл практикийн зардал 908.1 сая төгрөг
- Гадаад дотоодын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн зардал 190.4 сая төгрөг
- Багшийг дэмжих, мэргэжил дээшлүүлэх зардлууд 311.2 сая төгрөг



- Байр ашиглалтын зардал 435.1 сая төгрөгөөр тус тус дутуу гүйцэтгэлтэй гарсан байна. Учир нь төрийн хэмнэлтийн хуулийн дагуу зарим зардлуудад зарцуулалт хийгдээгүй.

Оюутны үйлчилгээний зардал 216.2 сая төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй гарсан. Төрийн хэмнэлтийн хуулийн дагуу спортын уралдаан тэмцээн, олны хамарсан үйл ажиллагаа явуулаагүй учраас дутуу гүйцэтгэлтэй гарсан байна.

Эрдэм шинжилгээ, инновацын зардал төсөвлөсөн хэмжээнээс 1,093.5 сая төгрөгийн дутуу гүйцэтгэлтэй гарсан нь төлөвлөсөн ажил хийгдээгүйтэй холбоотой байна.



Бүрэлдэхүүн сургууль, нэгж нь тэвчиж болох зардлуудыг хойшлуулж, төрийн хэмнэлтийн хуулийн дагуу зарим зардлуудад санхүүжилт хийгдээгүй учраас төсөвлөснөөс дутуу гүйцэтгэлтэй гарсан байна.

САНХҮҮГИЙН ХАРЬЦААНЫ ШИНЖИЛГЭЭ

- ШУТИС-ийн нийт хөрөнгийн 90.0 хувь нь өөрийн хөрөнгөөс, 10 хувь нь гадны эх үүсвэрээс бүрдэж байна. Гадны эх үүсвэрээс хараат бусаар бие даан үйл ажиллагаа явуулах бүрэн чадвартайг харуулж байгаа төдийгүй онолын түвшингөөр нь аваад үзвэл хангалттай түвшинд байна.
- Нийт хөрөнгөнд богино хугацаат өр төлбөрийн эзлэх хувь 7.5 хувь байна.
- Урт хугацаат зээлийн өглөггүй.
- Нийт эзний өмчид өр төлбөрийн эзлэх хувь 10 хувь байна.

НЭГДСЭН ДҮГНЭЛТ

- Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан.
- Тэвчиж болох зардлуудыг гаргахгүй байж зардлыг оновчтой зарцуулсан.
- Орлогод тэмүүлсэн үйл ажиллагааг идэвхжүүлэх /Орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлэх/
- Зардлын өсөлтийг оновчтой болгох
- Урт болон богино хугацааны төлөвлөгөөнд уялдуулан төлөвлөлтийг хийх



- Аливаа шийдвэрт эдийн засгийн дүн шинжилгээг хийж байж гаргадаг байх, уялдуулдаг байх

7.5. САНХҮҮ ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЛААР

ШУТИС-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн СНАГ-2023/17/НА-СТА-ТӨА код бүхий аудитын тайланг Үндэсний аудитын газраас 2022 оны 3 дугаар сарын 15-ны өдөр хүлээлгэн өгсөн. Төрийн аудитын тухай хуулийн 6.3.1, 8.1, Төсвийн тухай хуулийн 8.9.8 заасны дагуу ШУТИС-ийн 2022 оны 12 сарын 31-ны өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлагналын аудит хийгдэж “Хязгаарлалттай дүгнэлт” өгсөн.

Санхүү, хөрөнгө оруулалтын алба нь ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг нэгтгэн, Төсвийн тухай хуулийн 8.9.1-ийн дагуу 2023 оны 2 дугаар сарын 06-нд УАГ-т санхүүгийн тайлангаа хүргүүлсэн. УАГ нь НББОУС, СТОУС, УСНББОУС, АОУС, АДБОУС, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Аудитын тухай хуулийн хүрээнд хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн.

Аудитын илрүүлэлтээр нийт 2,000.0 сая төгрөгийн зөрчил илэрснээс 45.1 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 119.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлага, 1,835.3 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн.

Төлбөрийн акт-2

- ШУТИС-ийн Технологийн сангаас 2014 онд инновацийн төсөлд эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон 40.6 сая төгрөг төлөгдөөгүй.
- Хандивын тоглолтын билетийн үнэ 4.5 сая төгрөг

Албан шаардлага-4

- БШУЯамны хурлын өрөөг тохижуулахад ТӨИС-иуд хөрөнгө зарцуулсан.
- ШУТИС-ийн Захиргааны хөрөнгөнд бүртгэлтэй 4 автомашиныг ТӨБЗГ-т өгөх
- Төгссөн төлөвт байгаа 176 оюутны 81.4 сая төгрөгийн сургалтын төлбөрийн авлагыг барагдуулах /найдваргүй авлага болох эрсдэлтэй/
- Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулах

Зөвлөмж-3

- Шилжсэн төлөвт байгаа 50 оюутны 29.6 сая төгрөгийн сургалтын төлбөрийн авлагыг барагдуулах /найдваргүй авлага болох эрсдэлтэй/
- Сураггүй төлөвт байгаа 2066 оюутны 1,619.6 сая төгрөгийн сургалтын төлбөрийн авлагыг барагдуулах /найдваргүй авлага болох эрсдэлтэй/
- Худалдан авалтыг цахим мэдээллийн системийг ашиглан зохион байгуулах /186.1 сая төгрөг/

7.6. ХАНГАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАНЫ 2022-2023 ОНЫ ТАЙЛАН

Хангамж, үйлчилгээний алба нь нийт 73 хүний орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус алба нь барилга байгууламжийн их болон урсгал засварын ажлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу хийлгэх, хяналт тавих, орчны/гадаад, дотоод/ тохижилт, цэвэрлэгээ үйлчилгээг хариуцах, хичээлийн болон оюутны байруудын дэд бүтцийн хэвийн үйл ажиллагааг хангах, хяналт тавих, өмч хөрөнгийг үр ашигтай зарцуулах,



түрээслэгчдийн түрээсийн гэрээний биелэлтэд хяналт тавих зэрэг ажлуудыг гүйцэтгэлээ.

- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйлчилгээний чиглэлээр

“ШУТИС-ийн хамтын гэрээ”-ний өөрийн үйл ажиллагааны холбогдох бүлэгт тусгагдсан зүйл заалтын хэрэгжилтийг зохих төвшинд хангуулахад анхаарч ажиллаа. Эрүүл мэндийн төвтэй хамтран үйлчлэгч нарт цэвэрлэгээний бодис материалыг зөв хэрэглэх дадал олгох сургалтыг явуулав. Хөдөлмөрийн хортой нөхцөлд ажилладаг үйлчилгээний ажилчдад олгох хор саармагжуулах бүтээгдэхүүн нийлүүлэлтийн гэрээнүүдийн биелэлтийг хангуулж ажиллаа. Ариутгал, халдваргүйжүүлэлт, шавьж, мэрэгч устгалын ажлыг гэрээний дагуу зохион байгуулав. Оюутны соёл үйлчилгээний алба, эрүүл мэндийн төвтэй хамтран оюутны байрны орчинд нэгдсэн шалгалтыг хийж, авч хэрэгжүүлэх ажил үүргийг байр тус бүрээр гарган холбогдох арга хэмжээг зохион байгуулж ажиллаа. Цайны газрын ерөнхий үйл ажиллагаа, хоолны чанар, цэвэрлэгээ үйлчилгээнд Эрүүл мэнд төв, Оюутны холбоотой хамтран үзлэг, шалгалтыг хийж хяналт тавин ажиллав. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж “Өндөржүүлсэн бэлэн байдал”-ын үед ажиллах төлөвлөгөөг боловсруулав. Устгалд оруулах шаардлагатай химийн бодис урвалжийн нэгдсэн судалгааг гаргаж ШУА-ийн химийн хүрээлэнгийн холбогдох ажилтанд цахимаар хүргүүллээ. Мөн химийн хорт болон аюултай бодисыг хадгалуулахаар холбогдох байгууллагатай гэрээ байгуулах бэлтгэл ажлыг хангаж ажиллаа.

- Барилга байгууламжийн инженерийн шугам сүлжээний ашиглалтын талаар Хичээлийн болон оюутны байрнуудын сантехникийн найдвартай ажиллагааг хангах үүднээс халаалтын улирал дуусмагц инженерийн шугам сүлжээнд үзлэг шалгалт хийж, дүнг нэгтгэн илэрсэн доголдлыг засварлах ажлыг зохион байгуулж хэвшсэн. Тайлант онуудад хичээлийн болон оюутны байрнуудын ашиглалтын шаардлага хангахгүй болсон халаах хэрэгслийн хаалт винтель, сгон контур, муфьтийг шинэчлэн солих, ажлын даралт даахгүй болсон халуун, хүйтэн усны шугамыг хаалтуудын хамт шинээр солих ажлууд тогтмолжсон./6ш хаалт,150м шугам хоолой шинээр сольсон, ОБ-IV байрны ялтсан бойлуурыг шинэчилсэн/

Хичээлийн жилд ус хангамжийн шугам тоноглолоос ус алдсан 268, ариутгах татуургын шугам хоолой бөглөрсөн 162, халаалтын 72 дуудлага хүлээн авч цаг алдалгүй шуурхай шийдвэрлэж ажиллаа. /давхардсан тоогоор 180ш бохирын худаг цэвэрлэсэн/

Эрчим хүчний хэрэглээнд судалгаа, тооцоо хийж эрчим хүч хэмнэх боломжийг тодорхойлох ажлыг эхлүүлж, дэвшилтэд технологийг нэвтрүүлэх төсөл боловсруулан ажиллаж байна./ Үүрэг хүлээсэн хэрэглэгч 197 байгууллагаас цахилгаан, дулааны эрчим хүч хэмнэлтээр “сайн” үнэлэгдсэн 53 байгууллагын дотор 73 оноогоор 5-т эрэмбэлэгдсэн/

Хичээлийн I,II,III,IV,V,VIII байр, ШУТГНС-ийн хотын болон дотуур утас, станц, шугам аппаратын найдвартай ажиллагааг ханган, холбооны кабелийн 158 дуудлага хүлээн авч 173 гэмтлийг тодорхойлж засварлан техникийн саатал, осолгүй ажиллаа.

Хичээлийн болон оюутны байрнуудын цахилгаан тоног төхөөрөмж, цахилгаан хангамжийн найдвартай ажиллагааг хариуцан, цахилгаан системийн аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд цахилгааны ерөнхий болон групп шитэнд техникийн үзлэгийг сар бүр тогтмол хийж осол, аваараас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгууллаа. /Хичээлийн I байрны хойд жигүүрийн шитийг шинэчилсэн/

Горхийн полигоны цахилгааны тоолуурыг смарт болгон өөрчилж, хугацаа дууссан гүйдлийн трансформаторыг шинэчилсэн.



БУХС-ийн харьяанд байсан ХТП-713 дэд өртөөний 0,4 Кв-ын нам талын ашиглалтыг УБЦТС ТӨХК-Зүүн Түгээх төвд үндсэн хөрөнгийн балансаас балансад шилжүүлж ажлыг зохион байгуулсан.

“Соргор” ХХК, “Дорнод монгол эрдэс” ХХК-ийн Дорнод монгол секьюрити байгууллагуудтай харуул хамгаалалтын чиглэлээр гэрээтэй ажиллаж байна. Харуулын албаны ахлагч нартай байнгын холбоотой ажиллаж, гэрээний үүргээ биелүүлж ажиллахыг анхааруулан холбогдох үүрэг чиглэлийг өгч, өдөр тутмын үйл ажиллагаанд нь хяналт тавин ажиллаж байна.

Хичээлийн I, II, III байр орчмын авто зогсоолд байрлах автомашины бүртгэл, судалгааг гаргаж, автомашин нэвтрүүлэх зөвшөөрлийг шинэчлэн автомашин эзэмшигчдэд олгож зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллав.

Нийтийн эзэмшлийн зам талбай, орчны их цэвэрлэгээг улирал тутам зохион байгууллаа.

Тайлант онуудад Удирдах зөвлөлийн тогтоолоор батлагдсан жил жилийн хөрөнгө оруулалт, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөнд тусгагдсан урсгал засварын ажлын даалгаврыг боловсруулж, гүйцэтгэлийг зохион байгуулж ажиллаа.